*Ногоон хөгжлийн төлөө*

MONGOLIAN ECONOMY

Саятан хотын эдийн засаг

Түншлэлийн гудамж

Монголын эдийн засаг, бизнесийн сэтгүүл 2013. 11 сар. №22 (056) www.mongolianeconomy.mn

# ШИНЭ УЛААНБААТАР



# VERTUL

**OFFICE FURNITURE - ART GALLERY**

www.vertul.mn




**DOIMO** | Өөрийгөө хүндэлдэг танд зориулав.

Италийн албан тасалгааны тавилгын DOIMO брэндийн Монгол дахь албан ёсны төлөөлөгч ВЕРТУЛ ХХК











Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Их сургуулийн гудамж 31/1, PC mall

**Утас: (+976) 7711 3535**

МОНГОЛ ДАХЬ ОНЦГОЙ ЭРХТ
АЛБАН ЁСНЫ ДИСТРИБЬЮТЕР
АЙ ТИ ЗОН КОМПАНИ

# ZETA FIRE ALARM SYSTEM
# ГАЛЫН ЭРСДЛИЙН ЭСРЭГ ТӨГС ХАМГААЛАЛТ





Барилга байгууламж бол ихээхэн цаг хугацаа, хөрөнгө оруулалтын үр дүнд бий болж, олон зуун хүний амь амьдрал, эрүүл мэнд, эд хөрөнгөтэй шууд холбогддог нэг төрлийн онцгой бүтээгдэхүүн юм.

"Гал" нь хэдхэн хормын хугацаанд энэ их үнэ цэнээр бий болсон байгууламжийг тань бүхэлд нь хүртэл үгүй болгох аюултай, өндөр хор хохирол дагуулдаг эрсдэл тул зайлшгүй галын аюулаас хамгаалах системийг байгууламжид суулгах шаардлагатай.

***Танай байгууллагын "Галын дохиоллын систем" найдвартай ажилладаг уу?***

Ай Ти Зон компани Галын дохиоллоор дэлхийд танигдсан Zeta брэндийн бүтээгдэхүүнүүдийг ухаалаг шийдлээр суурилуулан бүхий л салбарын хэрэглэгчдэд санал болгож байна.

Zeta Fire Alarm System-ийг суурилуулснаар яг ямар объектод гал гарч байгааг нарийн тодорхойлж, гар утас, харуул хамгаалалт, гал унтраах ангид хүртэл автоматаар дохио өгөх байдлаар нэг цэгийн хяналт удирдлагыг боловсруулж болзошгүй эрсдлээс 2 минутын дотор л та бүхнийг хамгаална.

## ЯАГААД ZETA ГЭЖ ?

- Галын дохиолол хамгаалалтын системээр дэлхийд тэргүүлэгч
- 20 гаруй жилийн технологийн хөгжүүлэлт
- Тасралтгүй найдвартай ажиллагааны түвшин хамгийн өндөр
- Дэлхийн нийтэд тархсан R&D инженерүүд
- Нээлттэй технологи хөгжүүлэлт
- Галын дохиоллын технологийн анхдагч
- Иж бүрэн цогц систем болж чадах дэвшилтэт технологи

## ЯАГААД ITZONE ГЭЖ ?

- 10 гаруй жилийн галын аюулгүй байдлын ажлын туршлага
- Албан ёсны төлөөлөгч
- Мэргэжлийн сертификат бүхий галын дохиоллын инженерүүд
- Галын дохиоллоор дагнасан, түргэн шуурхай үйлчилгээ
- Бусад Систем интеграцчиллын инженерүүд
- Галын аюулгүй байдлын стандартад нийцсэн бусад дагалдах бүтээгдэхүүнүүд (Галд тэсвэртэй кабель, холбогч ...гм)

## СИСТЕМИЙН БҮРЭЛДХҮҮН ХЭСЭГ:


УТАА МЭДРЭГЧ


ДУЛААН МЭДРЭГЧ


ДӨЛ МЭДРЭГЧ


ГАР МЭДЭЭЛЭГЧ


ГАЛЫН ХОНХ


УДИРДЛАГЫН САМБАР

Since 1997
ITZONE®
Accelerate Your Success

itzone.mn, si@itzone.mn, 7731-2424, 89105060, 89105090

*Ногоон хөгжлийн төлөө*

MONGOLIAN ECONOMY

ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ЭРХЛЭГЧ:
Д.Бэхбаяр /9999-4248/

ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ОРЛОГЧ ЭРХЛЭГЧ:
И.Отгонжаргал /8800-6228/

ЕРӨНХИЙ РЕДАКТОР:
Б.Цогзаяабаатар /9919-0715/

АНГЛИ ХЭЛНИЙ РЕДАКТОР:
Теренс Эдвардс

ОРЧУУЛАГЧ: Р.Гантулга

СЭТГҮҮЛЧИД:
Б.Баяртогтох
Э.Зоригт
Х.Хулан
Б.Үүрийнтуяа
Б.Бямбадорж

ДИЗАЙНЕР: Ш.Оюундарь
ВЭБ МАСТЕР: Н.Гал

МАРКЕТИНГИЙН МЕНЕЖЕР:
Д.Бариажав /9409-2904/
Д.Баттулга /9409-2905/

БОРЛУУЛАЛТЫН МЕНЕЖЕР:
М.Хишигтогтох /9409-2906/

**“ECONOMY” ТВ СТУДИ**

РЕДАКТОР: Ж.Баяржаргал
ЗУРАГЛААЧ: Ш.Гантуул
ГРАФИКЧ: Т.Баярсайхан

# ОНЛАЙН ЗАХИАЛГЫГ

http://mongolianeconomy.imedia.mn/

# АГУУЛГА

## ЭДИЙН ЗАСАГ


10 Шинэ Улаанбаатар

11 Саятан хотын эдийн засаг

14 Д.Баттулга: Хот төлөвлөгөөтэй хөгжих ёстой

16 Иргэний оролцоотой төсвийн өнгө

18 Хот дагасан асуудал

24 Түншлэлийн гудамж

26 С.Очирбат:
Нийслэлийн хөрөнгө оруулалтын бодлого нь ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэнэ

30 2030 оны Улаанбаатар

34 Онцлох бүтээн байгуулалтаар Та юуг нэрлэх вэ?

36 Нялх хотын төрх

42 Дандаа муулуулах гэж

44 Улаанбаатарчууд ямар ус ууж байна вэ

47 Нийслэлдээ сэтгэл хангалуун байна уу?

49 Хотын ногоон хөгжил

54 Эдийн засагт үзүүлэх нөлөө



"MONGOLIAN ECONOMY"
СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ


**Б.БЯМБАСАЙХАН** Монголын бизнесийн зөвлөлийн ТУЗ-ийн дарга, "Mongolian Economy" сэтгүүлийн Зөвлөлийн тэргүүн


**Б.БОЛД**
"Рио Тинто" компанийн Зэсийн группын Олон улсын үйл ажилллагаа эрхэлсэн Ерөнхийлөгч


**С.БЭХБАТ**
ЭЗХЯ-ны Инновац, төр, хувийн хэвшлийн түншлэлийн газрын дарга


**Д.ЖАРГАЛСАЙХАН**
МІН группын ерөнхийлөгч


**Ц.БАТСҮХ**
СЭЗДС-ийн Эдийн засгийн тэнхимийн эрхлэгч


**Ж.СҮНЖИДМАА**
"Пийбоди Энержи" компанийн Монгол дахь хамтын ажиллагаа, олон нийтийн асуудал хариуцсан менежер


**Б.ТҮВШИНТӨГС**
Эдийн засгийн судалгаа, эрдэм шинжилгээний хүрээлэнгийн захирал

ХАЯГ:
Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг. VI хороо, Их сургуулийн гудамж. AB center. 503 тоот

15160 Улаанбаатар, Төв шуудан, ш/ х-2762
www.mongolianeconomy.mn
info@mongolianeconomy.mn

УТАС/ФАКС: 976 - 7011 5476

*"Улаанбаатар принт" ХХК-д хэвлэв*
*www.ubprint.mn*

**БОРЛУУЛАХ ЦЭГҮҮД:**

"Интер ном"
"Цэцэг төв"
"Минж плаза"
"Алтантүлхүүр" номын дэлгүүр
"Номин" супермаркетийн бүх салбар
"Макс" супермаркетийн бүх салбар
"Фреско" супермаркет
BTSI супермаркет
"Аз орчлон" номын дэлгүүр
"Билэг" их дэлгүүрийн номын тасаг
"Гранд Плаза" дахь супермаркет
"Мир" номын дэлгүүрийн
"Grand plaza"
"Metro mall"
"Sky" супермаркет
"Улаанбаатар" их дэлгүүр дэх салбар
"Max mall" салбарууд

PC mall

СҮЛЖЭЭ ИХ ДЭЛГҮҮР

## Macbook Pro Retina, Macbook Air, iMac

# Урамшуулалт худалдаа эхэллээ.



**СУРГАЛТЫН ЭРХИЙН БИЧИГ**

**БЭЛЭГ**

**100% ЛИЗИНГ**


**PC mall Төв дэлгүүр**
Хүнсний 4-р дэлгүүрийн хойд тал
(+976) 7011-3535

**PC mall 2**
Центр пойнтын замын эсрэг талд
(+976) 7012-3535

**PC mall Хороолол**
3,4-р хороолол, Номин Их дэлгүүрийн урд
(+976) 7014-3535

**PC mall 13**
13-р хороолол, Night Plaza 1 давхар
(+976) 7575-3536


Authorised Reseller




**Кемпински Хаан Палас Зочид буудал & Мираж ресторанд**

*Шинэ Жилийн* хүлээн авалтаа хийхийг урьж байна

**Давуу талууд:**

- Эхний 3 цаг үнэгүй
- Хувцас солих өрөө үнэгүй
- Халуун виногоор угтана
- Сонгосон менюны амталгаа
- Зураг авхуулах чимэглэлтэй орчин
- Өндөр үзүүлэлт бүхий тоног төхөөрөмж
- Олон улсын менежменттэй хамт олон

**Урамшуулал:**

- Хүзүү нүүрний массаж хийлгэх эрх (1 хүн)
- Сандэй Бранч зоогт хосоороо орох эрх
- Байгууллагын шилдэг ажилтанд Жьюниор Сюит-д хосоороо байрлаж, тансаг өглөөний цайнд орох эрх

kempinski.ub kempinskiUB

Утас: 9905 2015, 9905 0074 /Кемпински Хаан Палас/
Утас: 9905 1827, 9590 4502 /Мираж Ресторан/
И-мэйл: sales.uln@kempinski.com

# МОНГОЛД:

## ХОГНЫ МЕНЕЖМЕНТ



Өнгөрсөн өвөл Улаанбаатар хотын хэмжээнд өдөрт дунджаар 1237,2 тонн хог хаягдал гарч байв. Үүнээс 145,7 тонн хог хаягдал нь орон сууцанд амьдарч буй айл өрхүүдийнх. Гэр хорооллын айл өрхүүдээс 690,8 тонн нь гардаг. Аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанаас 159,9 тонн хог хаягдал гарсан байна. Хотын хог хаягдлын менежментийг сайжруулах хөтөлбөрийн хүрээнд нийслэлийн баруун, зүүн хэсэгт тус бүр хог боловсруулах үйлдвэр барих аж. 2015 оны эцэс гэхэд ашиглалтад оруулахаар төлөвлөжээ.

## ХОТЫН ТӨСӨВ

Нийслэлийн есөн дүүрэгт одоо ажиллаж буй төрийн болон хувийн 129 цэцэрлэгт 97010 хүүхэд хамрагдаж байна. Харин цэцэрлэгт огт хамрагдаагүй 31345, хүчин чадал хэтэрснээс 21850 нийт 53195 хүүхдэд цэцэрлэг шаардлагатай байгаа юм. Тиймээс хороодыг цэцэрлэгтэй болгож, нийт хүүхдийг цэцэрлэгт хамруулахын тулд 240 хүүхдийн багтаамжтай 220 цэцэрлэг барих хэрэгтэй гэсэн судалгааг НЗДТГ-аас гаргажээ.

## ГЭР ХОРООЛОЛ

Гэр хорооллын иргэдэд хүргэх нийтийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилгоор нийслэлийн 11 хороонд газрын зураглал хийх ажлыг туршсан байна. Газрын зураглалд тухайн хорооны худаг, цэцэрлэг, сургууль, эрүүл мэндийн төв зэргийг хүн амын тоон дээр үндэслэн тэмдэглэж харуулсан ажээ. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Э.Бат-Үүл гэр хорооллын газрын зураглал хийх ажлыг эрчимжүүлэх үүрэг даалгавар өгчээ. Нийт 87 хороонд хийж гүйцэтгэх захирамж ч гаргасан байна. Газрын зураглалын үр дүнг Улаанбаатар хотын хөрөнгө оруулалтын таван жилийн төлөвлөгөөнд тусгах юм. Түүнчлэн 2014 оны төсвийн хэлэлцүүлэгт ашиглах боломжтой аж.

## НИЙСЛЭЛИЙН ХӨГЖИЛ

Улаанбаатар хотыг 2030 он хүртэл доорх зургаан чиглэлийн дагуу хөгжүүлэхээр төлөвлөжээ. Үүнд:

-Нийслэлийг цаг уурын өөрчлөлт, ирээдүйд учирч болох гамшгийг даван туулах, дасан зохицох чадавх бүхий, аюулгүй, эрүүл, “ногоон хот” болгох

-Улаанбаатарыг зохистой газар зохион байгуулалт, дэд бүтэц, орон сууцны нөхцөл бүхий хүн амын амьдралын таатай орчин бүрдүүлсэн хот болгон хөгжүүлэх

-Иргэд, олон нийт болон хувийн хэвшлийг төрийн үйлчилгээнд татан оролцуулдаг сайн засаглалтай, сайн хууль эрх зүйн орчин бүхий хот болгон хөгжүүлэх

-Нийслэлийг хүн амын нутагшилт, суурьшлын зохистой тогтолцоонд суурилсан эрчимтэй хөгжиж буй дагуул хот, тосгодтой болгон хөгжүүлэх

-Гадаад, дотоодын жуулчдын сонирхлыг татсан Азийн аялал жуулчлалын нэг төв болгох

-Мөн өрсөлдөх чадвартай, олон улсын бизнесийн төв, дэлхийн хөгжилтэй орнуудын нийслэл хотуудын жишигт хүргэн хөгжүүлэх



## ХҮН АМ

Нийслэлийн эдийн засгийн ажлын албаны тооцоолсноор Улаанбаатар хотын хүн амын төвлөрөл 2030 онд 1.7 саяд хүрэх төлөвтэй юм. Мөн хүн амын төвлөрлийг сааруулах үүднээс дагуул хотуудыг хөгжүүлэх талаар “Улаанбаатар хотыг 2020 он хүртэлх ерөнхий төлөвлөгөөний тодотголд” тусгажээ. /Дэлгэрэнгүйг графикаас харна уу/

### Хүн амын өсөлтийн төсөөлөл, 2030 он

| Хот суурингийн нэр | 2010 он /Нийслэлийн статистик | | Хүн амын өсөлтийн төлөвлөлт | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | Хүн ам | Өрх | 2020 он | Хувь | 2030 он | Хувь |
| Улаанбаатар хот | 1058.129 | 264.311 | 1235.5 | 80.55 | 1400.0 | 79.4 |
| Дагуул хот суурин | 103.656 | 30.106 | 298.5 | 19.45 | 363.0 | 20.6 |
| Нийт дүн | 1161.785 | 294.416 | 1534.0 | 100.0 | 1763.0 | 100 |

*Эх сурвалж: Нийслэлийн зураг төслийн хүрээлэн*

# ДЭЛХИЙН УХААЛАГ ХОТУУД:

*“Forbes” сэтгүүлээс гаргасан дэлхийн хамгийн ухаалаг хотуудын жагсаалтыг танд хүргэж байна. Ухаалаг хот гэсэн ойлголт нь гол төлөв ногоон, тогтвортой хөгжлийн асуудалтай холбоотой байдаг. Үүнд зөвхөн дэд бүтэц, амьдрахад таатай орчныг авч үзээд зогсохгүй эдийн засгийн суурь үзүүлэлтэд үндэслэн энэхүү жагсаалтыг гаргасан байна.*

## СИНГАПУР



Сингапурт үндэстэн дамнасан 6000 гаруй корпорацийн 3600 гаруй бүс нутгийн төв оффис байрладаг. Тус улсын “Чанги” нисэх онгоцны буудал Азидаа тавдугаарт, чингэлэг дамжин өнгөрөх агуулах нь дэлхийд хамгийн томд тооцогддог байна. Мөн “Бизнес хийхэд хялбар байдал”-аараа дэлхийд нэгдүгээрт ордог аж.

## ХОНКОНГ




Дэлхийн эдийн засгийн төв өрнөөс дорныг чиглэх болсон. Энэ онцлог үед Хонконг эдийн засгийн хувьд маш үр өгөөжтэй газар аж. Хонконг, Шанхайн банк төв оффисоо Лондонгоос ийш нь шилжүүлсэн байна. Хонконгийн нэг хүнд ногдох ДНБ-ийн хэмжээгээрээ дэлхийд 15 дугаарт эрэмбэлэгдэж буй. “Heritage Foundation” сан болон “The Wall Street Journal” сэтгүүл тус улсыг дэлхийн хамгийн чөлөөтэй эдийн засаг бүхий орноор шалгаруулжээ.

## БРАЗИЛИЙН КУРИТИБА ХОТ



Бразилийн өмнөд хэсэгт байрлах Куритиба хотод автобусны транзит тээвэр хурдацтай хөгжиж буй. Хүн амынх нь 70 хувь нь автобусаар зорчдог байна. Эдийн засгийн хөгжлийн стратеги нь тэнцвэртэй, төрөлжсөн аж. “Гэрэлт цамхаг” хөтөлберийн хүрээнд ядуу иргэдэд зориулсан электрон номын сангууд байгуулжээ. Ингэснээр дэлхий дахины хөгжиж буй хотуудын загвар болж чадсан аж. Мөн “Грист” хэмээх ногоон байгууламж нь дэлхийн гуравдагч “Хамгийн ногоон бүс”-ээр шалгарчээ.

## МЕКСИКИЙН МОНТЕРРЕЙ ХОТ



Монтеррей хот нэлээд хэдэн жилийн өмнө олонд танигдаагүй байв. Гэтэл өнөөдөр үйлдвэр, инженерийн гол төвүүдийн нэг болоод байна. Уг хот нь 3.5 сая хүн амтай. Энд бүх төрлийн химийн бүтээгдэхүүн, цементээс авахуулаад харилцаа холбоо, үйлдвэрийн тоног төхөөрөмж үйлдвэрлэдэг 57 аж үйлдвэрийн парк бий. Мексикийн бусад хоттой харьцуулахад нэг хүнд ногдох ДНБ ойролцоогоор хоёр дахин нэмэгдсэн аж.

## АМСТЕРДАМ



Санхүү, худалдааны эртний төв болох Амстердам хотод дэлхийн “топ” 500 компаниас “Philips”, ING зэрэг долоо нь байрладаг аж. Гаднын байгууллагад харьцангуй бага татвар ногдуулахын зэрэгцээ орлогын албан татвар ч бага. Иймээс гаднын компани, хувь хүмүүс ихээр татагддаг байна. Тус хотын иргэд өндөр боловсролтой, олон хэлтэй аж. Энд улс төрийн авлига багатай. Үүнээс гадна Европ тивийн томоохон онгоцны буудал болон хамгийн том боомт болох Роттердамтай ойрхон байрладаг. Энэ нь уг тивийн зүрхэн тушаа байршилтай нь холбоотой юм.

## АНУ-ЫН СЕАТЛ ХОТ



АНУ-ын Вашингтон мужийн төв Сеатл хот нь Номхон далайтай ойрхон байрладаг. Энэ нь Ази тивийн орнуудтай худалдаа, наймаа хийх сайхан боломжийг бүрдүүлж өгчээ. Мужийнхаа усан цахилгаан станцтай ойрхон байрладаг тул цэвэр эрчим хүчээр хангагддаг. Тус хот АНУ-ын хөдөө аж ахуй болон аж үйлдвэрийн бүтээгдэхүүний экспортын суваг болж өгдөг. ■

ОНЦЛОХ

# ШИНЭ УЛААНБААТАР

И.ОТГОН



Дүн өвлийн хүйтнийг дундрахгүй утаан дунд үдэхээ нийслэлчүүд сайн мэдэж байгаа. Гэхдээ хоолой хорсгож, нулимс асгаруулдаг утаа өмнөх жилүүдийнхээс “уяхан” санагдаж ч болох. Ирэх хаврыг нийслэлчүүд нэг л догдлон хүлээж, хотын гудамжаар өнгө алаглах шинэхэн цэцэгсийг харах гэж яарах учраас тэр. Ахмадууд маань нарлангаа хотын ногоон байгууламж өдрөөс өдөрт устаж үгүй болж байгааг харж, халаглан суудаг байдал өнгөрсөн хавраас огцом шинэчлэгдэн өөрчлөгдөж байгаад нийслэлчүүд баяртай байна. Шинэчлэлийн Засгийн газар гарснаар хотын гудамжаар зөвхөн цэцэг навч алаглаад зогсоогүй замын түгжрэлийг арилгах зорилгоор төв замын нэгдүгээр эгнээгээр зөвхөн нийтийн тээврийн унааг явуулах, автомашиныг улсын дугаарын арын тоогоор нь хязгаарлалттай замын хөдөлгөөнд оролцуулах зэрэг шийдмэг алхмууд хийсэн нь томоохон өөрчлөлтийг авчирсан юм. За тэгээд өвлийн эхэн сар гарчихаад байгаа энэ үед ч Улаанбаатарт шинэ шинэ уулзварууд, өргөн цэлгэр замууд энд тэндгүй ашиглалтад орж, Улаанбаатар нүүрээ угаасаар байгаад иргэд ихэд олзуурхан, ойр хоорондоо “Хот маань үнэхээр гоё болж байна шүү” хэмээн хөөрөлддөг болсон. Ийнхүү нийслэл маань маш богино хугацаанд нүдэн дээр өнгө засаж, шинэ Улаанбаатар болж байгааг мэдээд байгаа хэрнээ хэвлэлийн бид л хамгийн бага дуугарсан байх шүү. Хэвлэлээр “Шинээр тавьсан замын хашлагаа буулгасан байна, замын түгжрэл саарахгүй байна, хот хогтой байна” гэж шүүмжлэх нь их. Ямар сайндаа саяхан мэргэжил нэгт хэдэн нөхөр маань цайлах зуур бидний яриа нэг мэдсэн мөнөөх л хот өнгө зассан сайхан сэдэв рүү хазайсан байлаа. “Сэтгүүлч бид хот гоё болоод байгааг мэдээд байгаа хэрнээ бичихгүй суусаар өвөлтэй залгалаа шүү. Гэтэл одоо болохоор Утаа эхэллээ гээд л балбаад эхэлнэ дээ” хэмээн хошигнож суув. Нээрээ л Монголын хэвлэлүүдийн голчилж бичиж байгаа зүйл дээр бяцхан дүгнэлт хийгээд үзэхэд сүүлийн жилүүдэд сэтгүүлч бид нийгмийн хамаг л болохгүй бүтэхгүй байгаа саар зүйлүүдийг шүүрэн авч, шүүмжилсээр тэр зандаа дассан юм шиг ээ.

Тиймээ, Улаанбаатар маань утаан дундаас сүүмэлздэг өвлийн улирал хэдий айлчилсан ч монгол-англи хэл дээр 14 хоног тутам хэвлэгддэг “Mongolian Economy” сэтгүүл шинэ Улаанбаатарын хөгжил цэцэглэлт, их бүтээн байгуулалт, ирээдүйн гэрэлт хотын төлөө арваннэгдүгээр сарын хоёр дахь дугаараа зориулж байна.

Улсын доторх улс болсон Улаанбаатар хотод Монголын нийт хүн амын 40 гаруй хувь нь суурьшин амьдарч байна. Өдрөөс өдөрт нэмэгдэж байгаа хүн амын өсөлт 2020 он гэхэд 1.5 сая гаруй болж нэмэгдэх хандлага бий. Тиймээс хүн амын өсөлтөөс үүдэлтэй хотын хэт төвлөрлийг хэрхэн сааруулах, хотын замын түгжрэл, агаарын бохирдлыг хэрхэн шийдвэрлэх, хөрөнгө оруулалт, хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох, нийслэлийн иргэдийн соёл, боловсрол, эрүүл мэнд гээд дэлхийн хөгжиж буй том хотуудын өмнө тулгардаг асуудлууд Улаанбаатарын өмнө ч сорилт болж байна.

Сорилтыг даван туулахдаа бусдын гаргасан алдаа, туулсан замналаас хэрхэн суралцаж богино хугацаанд илүү хөгжих вэ гэдэг манай улсын боломж хийгээд Нийслэлийн удирдлагуудын зорилт гэж хэлж болно. »

Улаанбаатарын шинэ удирдлагууд их хотын хөгжлийг өөдрөг төсөөлж, эрч хүчтэй ажиллах хүсэл тэмүүлэл дүүрэн нь хэлж ярьж байгаагаас нь нийслэлчүүдэд тодорхой байгаа. Тухайлбал, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Э.Бат-Үүл “Би Захирагч байх хугацаандаа Улаанбаатарыг хамгийн шилдэг хот болгоно” хэмээн амлаж буй. Үүнийгээ тэр хаана ч хэлдэг. Улаанбаатарын утааг хэрхэн багасгах, гэр хорооллыг барилгажуулах гээд шийдэхэд бэрх олон асуудал байгаа ч түүний багийнхан өнгөрсөн хавар сонгуулийн дараа ажлаа маш эрч хүчтэй, зөв эхэлсэн. Зөв гэдэг нь замын түгжрэл, хот тохижилт, хот төлөвлөлт гээд нийслэлчүүдийг олон жил бухимдуулсан гол асуудлуудыг зоригтой барьж авсныг нь хэлж байгаа хэрэг. Жишээлбэл, эхний ээлжийн гэр хорооллын дахин төлөвлөлтийн ажлыг өнгөрсөн хавар эхлүүлж, иргэдтэй маш богино хугацаанд буюу гурваас дөрөвхөн сарын хугацаанд бүрэн тохиролцож, орон сууцжуулах ажлаа эхлүүлж чадсан тухай НИТХ-ын дарга Д.Баттулга олзуурхан ярьж байсан. Түүний хэлснээр Японд гэхэд иймэрхүү хорооллын дахин төлөвлөлтийг хийхэд бүтэн 10 жил зарцуулсан гэдэг.

Мөн өнгөрсөн оноос Төсвийн тухай хуулиар Нийслэлийн төсвийн зарцуулалтад хотын иргэдийн оролцоо хяналт их байх ёстойг заасан. Нэг үгээр хэлбэл, хотын төсвийг зохиохоос батлах хүртэл иргэдийн оролцоо ихээхэн чухал гэсэн үг. Улсын төсөв батлагдсаны дараа ид хэлэлцэж буй “Хотын төсөв-2014”-д дээрх шаардлагыг чандлан мөрдөж байгаа гэсэн. Ер нь Нийслэлийн шийдвэр гаргагчид зөвхөн төсөв ч биш хороо, дүүргийн оршин суугчдын асуудлыг шийдвэрлэхэд иргэдийн оролцоог хангах зорилгоор тэдний санал хүсэлтийг хүлээн авах хоёр ч тусгай утас ажиллуулж байгаа юм билээ. За тэгээд хот тохижилтын хувьд өнгөрсөн хавар жижгээс нь эхлээд томоохон тохижуулалтыг хүртэл олны нүдэнд харагдаж, гарт баригдахаар хийсэн гэдэгтэй нийслэлчүүд санал нийлнэ дээ.

Олон шинэ замтай, хоггүй цэмцгэр хоттой болохын тулд нийслэлийн иргэний хувьд хотынхоо хөгжил цэцэглэлтэд ямар үүрэгтэй оролцох вэ гэдгийг бодож, ухаарах цаг болсон. Нөгөө талаас нийслэлийн эдийн засгийн хөгжил, хот төлөвлөлт, хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт, ногоон байгууламжийн арчилгаа, томооохон төсөл хөтөлбөрүүд, ирээдүйн Улаанбаатарын тухай манай сэтгүүлд багтсан шинэхэн нийтлэлүүдийг шимтэн уншина биз ээ. ■

ХӨГЖИЛ

# САЯТАН ХОТЫН ЭДИЙН ЗАСАГ

**Б.БАЯРТОГТОХ**

Улаанбаатар Азийн 107 дахь саятан хот. Хүн амынхаа тоогоор 2007 онд ийн “цол” хүртсэн юм. Нийслэл хот маань Монгол Улсын ДНБ-ий 65 хувийг, эрчим хүчний эх үүсвэрийн 85 хувийг, мөн хөрөнгө оруулалтын 50 хувийг тус тус бүрдүүлж байна. Нийт хүн амын 44 хувь нийслэлд төвлөрч байгаа нь саятан хотын эгнээнд нэгдэхэд нөлөөлөв. Саятан гэх тодотгол нь хүн амын тоон хэмжүүр. Түүнээс амьжиргааны түвшинг давхар илэрхийлэхгүй юм.

Нийслэлд 1.3 сая хүн амьдарч байгаагаас 220 орчим мянган хүн тогтмол ажилгүй байна. Энэ нь хотын нийт хүн амын бараг 20 хувийг эзэлж байгаа юм. Ажилгүйдэл байхын хэрээр ядуурал гүнзгийрсээр. Нэг сая хүн амтай хотын эдийн засаг ямар байх ёстой вэ. Мэдээж иргэд нь ажилтай, орлоготой. Өрх гэр нь инженерийн байгууламжид холбогдсон орчин үеийн орон сууц, ажиллаж амьдрах ая тухтай орчноор хангагдсан байх. Нийгмийн байгууламж /эмнэлэг, сургууль, цэцэрлэг / нь хүрэлцээтэй. Үйлдвэрлэл, үйлчилгээ цэцэглэсэн цогцолбор байх учиртай. Сая хүнтэй хотын эдийн засаг ийм байх ёстой гэсэн тогтсон стандарт байхгүй ч иргэдийнх нь амьдралын чанар өндөр байхад оршдог байна.

Тэгвэл Улаанбаатар хотын иргэдийнх нь авч буй цалинг дэлхийн дундаж цалинтай харьцуулахад 3.5 дахин бага гэсэн статистик тоо гарчээ. Түүнчлэн агаарын бохирдол дэлхийн бусад хотуудаас 10 дахин их. Ийм мөртлөө нэг хүнд ногдох ногоон байгууламж нь 10 дахин бага. Нийслэлийн нийт өрхийн 30 хувь нь орон сууцанд, 70 хувь нь гэр




*Хөгжингүй орнуудад том хотууд бараа, үйлчилгээний хэрэглээний төвлөрлийн төв болж, "хэрэглээний нийгэм"-д шилжиж байна.*

хороололд амьдарч байгаа нь саятан хотын үнэлэмж лавтай биш ээ.

"Том хотуудын эдийн засаг" номд өгүүлснээр саятан хот аялал жуулчлалын үйлчилгээ эрхлэх, мөн худалдаа болон бизнесийн үйлчилгээний төв болох боломжтой аж. Боловсрол, эрүүл мэндийн салбарын үйлчилгээ нь үндсэндээ хүн амаа дагах бөгөөд хотын нийгмийн үйлчилгээ нь хүн амын өсөлтөөс голлон хамаардаг байна. Нэг талаасаа хот өөрийн мэдэгдэхүйц нийгмийн "холбоо хэлхээний машин" бөгөөд нийгэм, эдийн засгийн инновацийн төв болдог аж. Үүнээс гадна энэ хэрийн хотын төвийн хороололд "үйлчилгээний шинэ бүс" гэсэн ойлголт үүсчээ. Харин саятан хотод санхүү, удирдлагын төв байрлах болсон. Үүнийг удирдлагын хот ч гэж хэлж болно.

Жишээ нь сүүлийн 30 гаруй жилд Канадын эдийн засагт Торонто хот зонхилох байр суурьтай болсон. Учир нь тус орны томоохон компаниуд удирдлагын байраа дээрх хотод байршуулж байгаатай холбоотой юм. Лондон ч мөн адил төвийн байрлалыг сонгосон байдаг. Энэ бол том хотууд. Ирээдүйд Улаанбаатар энэ зүг тэмүүлэхийг үгүйсгэх аргагүй. Зарим мегаполисуудын хувьд аялал жуулчлал аж үйлдвэрлэлээс илүү ач холбогдолтой болж байна. Тэр тусмаа ногоон эдийн засгийн өсөлтийг дэмжиж улс орны итгэл үнэмшил хотоо ч мөн адил энэ чигт хандуулж буй.

Улаанбаатар хотыг удирдаж буй "шинэ баг" орон сууцтай, дүрэмтэй, соёлтой, хөгжингүй, түгжрэлгүй бас хүнд сурталгүй шинэ нийслэл байгуулах зорилго бүхий мөрийн хөтөлбөртэй. Иймээс гэр хорооллыг орон сууцжуулах, дахин төлөвлөх асуудлыг нэн даруй шийдэх гэж оролдож байгааг тэмдэглэх нь зүйтэй болов уу. Гэхдээ хүн амын тоогоороо саятан хотын босгыг аль хэдийнэ алхсан Улаанбаатар хөгжлийн үзүүлэлтээрээ сайнгүй яваа.

Сая хүнтэй хот ядаж л метротой байхаас гадна хотын албан татвартай байдаг. Тэгвэл Улаанбаатарт дээрх шалгуурын аль нь ч үгүй өнөөдрийг хүрчээ. Гэхдээ метро барих, хотын албан татварын талаар өнөөдөр бодлогын түвшинд ярьж эхэлсэн нь том хотуудын эдийн засгийн хөгжлийн хаялга нөлөө зарим талаараа айлсаж буйг илтгэнэ. Төрөлх хотоо хөгжүүлэх ойрын болон дунд хугацааны хөтөлбөр тодорхой болж, хотын ерөнхий төлөвлөгөөг УИХ баталгаажуулсан. Ингэснээр Улаанбаатар сая хүнийхээ нийтийн тээврийн асуудлыг шийдэх гарц харагдаж буй.

Хөдөлгөөн ихтэй төв замуудын оргил цагийн түгжрэл нь метрог сануулсаар. Нөгөөтэйгүүр сая хүнтэй хотын тээврийн хөдөлгөөнд зохицуулалт хийх, тээврийн бүх төрлийн тогтолцоог хөгжүүлэх асуудал тулгарсаар. Иймд автомашины урсгалыг зохицуулах нэг арга хэрэгсэл нь замаар зорчсоны татварын тогтолцоо аж. Гэхдээ эдийн засгийн хувьд үр ашигтай ч нийгмийн сэтгэлзүйд хүндрэл учруулдаг байна. Энэ төрлийн татвар оногдуулсан орны нэг бол Сингапур. Тус улсад автомашин хотын төв бүсээр зорчих онцгой төлбөрийг тогтоожээ. Ингэснээр хот өөрийгөө санхүүжүүлэх боломжтой аж. Зөвхөн манайх биш дэлхийн бусад хотод тээврийн асуудал хүндэрч байгаа нь дэд бүтцийн цаашдын хөгжлийг чөдөрлөж, санхүүгийн хүндрэлд түлхэн оруулж байна. Үүнээс үүдэж хөгжил зогсох болжээ. Замын асуудлаас гадна Улаанбаатар 1.3 сая иргэнийхээ эрчим хүчний хэрэглээг хангах, эс хангах дээрээ тулаад буй.

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Э.Бат-Үүл “Улаанбаатар зүгээр нэг хот биш асар том зах зээл, эдийн засаг болчихсон. Хөдөө орон нутгаас иргэд хотод шилжиж ирж байгаа нь ерөөсөө муу зүйл биш. Дургүйцэх хэрэг байхгүй. Хятадын эдийн засаг хүчтэй байгаагийн шалтгаан нь хүн ам ихтэйд байна. Хүн ам ихтэй хотын зах зээл хурдтай хөгжинө” хэмээн өгүүлсэн нь бий.

1911 онд нийслэлд 40 орчим мянган иргэн амьдарч байв. Өдгөө 1.3 саяад хүрээд байна. Үүний бараг тал нь шинээр шилжин ирэгсэд. “Хот шиг хот” босгох “багийн тоглолт” Улаанбаатарыг бие даасан эдийн засагтай, хөгжлийн төв байхаар зураглаж буй. Гэхдээ таван тивийн том хотуудтай адил зиндаанд хүрч хөгжих нь олон зүйлээс шалтгаална. Мэдээж гүйцэж түрүүлэх амаргүй. Нийслэлийн авто замын сүлжээг шинэчлэх, дүүргүүдэд явган зорчигчийн гудамжийг бий болгох, нүхэн гарц, газар доорхи болон давхар зогсоолыг жил бүр төлөвлөн барьж байгуулах Хотын даргын зорилт бий.

Зөвхөн яриа төдий түвшинд сая хүнтэй хотын эдийн засгийн асуудал хөндөгдөх учиргүй. Нөгөөтэйгүүр саятан хотыг 1-2 салбар хөтөлнө гэвэл “үлгэр” аж. Өөрөөр хэлбэл, төсвийн хөрөнгө оруулалтаар хот амьдарна гэвэл хөгжихгүй гэсэн үг. Харин санхүүгийн эх үүсвэртэй болох, бонд гаргах, гаднаас хөнгөлөлттэй зээл авах замаар асуудлаа шийдэж, хөгжлийг түргэвчилж болдог аж.

Аж үйлдвэржүүлэлтийн эрин үед дэлхийн хот нь улс төр, соёлын амьдралын төвлөрөл байв. Өнөөдөр тэгвэл эдийн засгийн хөгжлийн төв болон хувирчээ. Хөгжингүй орнуудад том хотууд бараа, үйлчилгээний хэрэглээний төвлөрлийн төв болж, “хэрэглээний нийгэм”-д шилжиж байна. Дэлхийн хотууд хөгжлийн чиг баримжаагаа өөрчилж, явах замаа тодотгож байгаа нь Улаанбаатарт үлгэр дуурайлал юм. Төлөвлөлт хамгийн чухал. Үүний үр дагаврыг бид өдгөө амсч буй. Иймээс сая хүнтэй хотын эдийн засгийн өрсөлдөх чадвар хэр байхаас иргэдийнх нь сэтгэлгээ, эрүүл мэнд, боловсрол, амьжиргааны түвшин хүртэл хамаардаг болохыг “Том хотуудын эдийн засаг” номд дурджээ. Тус номд өгүүлснээр дэлхийн мөнгөний урсгал мегаполисуудад төвлөрч, тэдэнд шинэ эрх мэдэл олгоод байна. Энэ нь хөгжих үүд хаалгыг нээж буй.

Өндөр барилга, хурдны зам, худалдааны томоохон төв, онгоцны буудал, хотжилт гээд дэлхийн зуу зуун хот дээрх үзүүлэлтээр өөр хоорондоо уралдаж буй. Олимпын эрх авахын төлөөх өрсөлдөөнд ялахын тулд хотынхоо хөгжилд үлэмж хэмжээний хөрөнгө оруулалтыг хийж, төрхөө өөрчилж, хөгжлийн хурдаа нэмж байгааг бид мэдэх. Том хотууд өргөжин хөдөөгийн бүс болон уналтад орж буй аж үйлдвэрийн төвүүдийн хүн амын зонхилох хэсгийг өөртөө татан төвлөрүүлж байна. Хотуудын түрэмгийлэл дэлхий нийтэд ийн газар авч байгаагийн ойрын жишээ нь Улаанбаатар.

Хот судлалд хотын том жижгийн үндсэн хэмжүүр нь хүн амын тоо байдаг. Мегаполисын тухай ярихдаа гол төлөв хүн амын тоо нь нэг саяас давсан саятан хотуудыг оруулдаг. Олон хотод өнөөдөр ажил эрхлэлт тулгамдсан асуудал болж байна. Эл байдал нь хотын орон сууцны хүрэлцээний асуудлыг хурцатгах нэг шалтгаан болдог аж. Тогтсон орлогогүй хүнд ямар ч арилжааны банк итгэж моргейжийн зээл олгохгүй. Иймд Улаанбаатар иргэдээ ажлын байртай болгох, орлогожуулах. Ингэснээр гэр хорооллыг орон сууцжуулах зорилт бага ч болтугай урагшлах юм.

Мэдээж Улаанбаатар хүрээгээ тэлэх тусам хотын эдийн засаг саарах ч гэсэн сайн тал бий. Хүн амын тоо өсөхийн хэрээр үйлдвэрлэл төвлөрч, хэрэглэгч болон үйлдвэрлэгчдийн аль алинд нь ашигтай нэг бус давуу тал гарч ирдэг байна. Тухайлбал, хүн амын төвлөрөл нь хэрэглээний зохимжтой, харьцангуй гүн зах зээлийг бүрдүүлдэг байна. Өөрөөр хэлбэл,тухайн бараа бүтээгдэхүүн түргэн борлогдох, үнэд зардлын өртөг бага суудаг аж.

Төгсгөлд нь өгүүлэхэд орчин үеийн хотын эдийн засгийн хувь заяа газар нутгийн өрсөлдөөнөөс хамаарч байгаа юм. Өөрөөр хэлбэл, газар төлөвлөлт, түүнийг үр ашигтай ашиглах эсэхээс эдийн засаг нь хөгжих, эс хөгжих нь шалтгаалж байна. ■

ЗОЧИН

# Д.БАТТУЛГА: ХОТ ТӨЛӨВЛӨГӨӨТЭЙ ХӨГЖИХ ЁСТОЙ



Б.АЛТАЙ

***НИТХ-ын дарга Д.Баттулгатай Улаанбаатар хотын хөгжлийн талаар ярилцлаа.***

**-Нийслэлийг эдийн засгийн эрх чөлөөтэй болсон гэж ойлгож болох уу?**

-Хот эдийн засгийн хувьд эрх чөлөөтэй болсон гэж хэлэхэд эрт байна. Гэхдээ нийслэл хөгжиж, хүмүүсийн орлого нэмэгдэж байгаа нь эргээд эдийн засагт эерэг үр дүн авчирч байгаа. Энэ утгаараа хотын эдийн засгийн суурь болсон хүн амын орлогын албан татварын хэмжээ өссөн. Уг өсөлт нь хотын төсөвт сайн нөлөөтэй. Төсөв нэмэгдсэн гэхээс илүү эдийн засгийн эрх мэдэл иргэддээ хүрч байна гэж ойлгож болно. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар төсвийн тухай хуульд 2012 онд өөрчлөлт орсон. Тус хуульд заасны дагуу төсвийг хэлэлцэхдээ иргэдийнхээ оролцоонд түшиглэх. Тэдний санаа бодлыг тусгах замаар хамтдаа төсөвт суулгах хөрөнгө оруулалтын зардлаа тооцох зэрэг дэвшил гарч байгаа. Ингэснээр төсөв иргэдэд нээлттэй, ил тод байх хуулийн зарчимтай нийцэх юм. Нэг гол зарчим бол орон нутгийн хөгжлийн сан гэж төсвөөс байгуулсан. Тус сангийн хөрөнгөөр иргэд чухам юу хийх вэ гэдгээ өөрсдөө шийддэг. Өөрөөр хэлбэл, иргэдийн гаргасан шийдвэрийг дүүрэг болон хотын удирдлага хэрэгжүүлдэг системд орсон.

**- Та хот гэж нэрлэх шалгуурыг юу гэж үздэг вэ?**

-Хотын олон шалгуур бий. Иймээс нэн тэргүүнд хотоо хөгжүүлэх ёстой. Энэ нь нийслэлээ барилгажуулна, дэд бүтцийг бий болгоно гэсэн үг. Нөгөөтэйгүүр хот олон төвтэй болох учиртай. Энэ талаар манайх олон жил ярьж байгаа ч бодитой үр дүнд хүрээгүй байна. Тиймээс дахин төлөвлөлтийн хүрээнд хотын дэд төвийг байгуулахаар ерөнхий төлөвлөгөөнд тусгасан. Улаанбаатар хотын хувьд нийт нутаг дэвсгэрийн 30-хан хувь нь барилгажсан. Сүүлийн үед Улаанбаатар эрчимтэй барилгажиж байна гэлцдэг ч барилгажилт газар нутгийн дөнгөж гуравны нэгийг эзэлж байна. Улаанбаатар Бага тойрууг тойрсон нэг л төвтэй. Улаанбаатарт амьдарч буй 1.3 сая хүн энэ төвөөс үйлчилгээ авч байна. Соёл, шинжлэх ухааны төв болон төрийн бүх байгууллагууд Бага тойруугийн бүсэд төвлөрсөн. Үүнийг задлах ёстой. Ингэснээр хот шиг хот болно. Хоёрдугаарт, хотын дүрэм байх ёстой. Хот дүрэмгүйгээр 374 жил болжээ. Дүрэмгүй хот гэдэг хуульгүй улстай адилхан. Өнөөдөр Улаанбаатарт ямар дүрэм үйлчилж байгаа билээ. Гэтэл хотод олон үйл ажиллагаа явагдаж байна. Харамсалтай нь түүнийг зохицуулах дүрэм алга. Замын хөдөлгөөн, хаягжилтын асуудал ямар байх ёстой, хотын иргэн ямар үүрэг хүлээх юм. Түүнчлэн өдөр тутмын хотын амьдралын олон талт харилцааг дүрмээр зохицуулах ёстой. Хот болох нэг илэрхийлэл нь дүрмийн асуудал.

**-Улаанбаатарын хөгжлийн гол тулгуур нь иргэд. Иргэд хөгжиж байж хот хөгжинө. Тиймээс нийслэл иргэдийнхээ оролцоог идэвхжүүлэх чиглэлд хэрхэн анхаарч ажиллаж байна вэ?**

-Иргэдийн оролцооны чиглэлээр цөөнгүй ажил зохион байгуулж, эдгээр нь хэвшээд явж байна. Шууд Ард-чиллыг хөгжүүлж, иргэний оролцоог

нэмэгдүүлэх ажлын хүрээнд “Иргэний танхим”-тай болсон. Улаанбаатар 152 хороотой. Үүний 34 хороонд “Иргэний танхим” байгуулагдсан. Тэдгээр нь байнгын үйл ажиллагаатай. Тухайн “Иргэний танхим”-ыг хариуцсан тодорхой цалинтай албан хаагч ажиллаж байна. “Иргэний танхим”-даа дугаар хорооныхон цуглаад “Орон нутгийн хөгжлийн сан”-гийн хөрөнгөө юунд хэрхэн зарцуулах талаараа хэлэлцэж болно. Мөн өөрсдийнхөө өмнө тулгамдаж буй асуудлаа ярилцах гээд бүх талаараа нээлттэй. Үүнээс гадна Хот, дүүрэг, хорооноос гарч байгаа шийдвэрийн талаар иргэний танхимаараа дамжуулж, санал хүсэлтээ өгөх нь тогтмол үйл ажиллагаа болсон. Нэг үгээр хэлбэл, нийслэлийн удирдлага аливаа шийдвэрийг гаргахдаа иргэдээсээ асууж, хамтдаа гарц хайж байна. Тухайн хороонд амьдарч буй иргэн өөрт нь тулгамдаад буй асуудал, түүнийг шийдэх арга замыг биднээс илүү мэдэж байгаа. Миний бие Хан-Уул дүүрэгт амьдарч байна. Тэгвэл Баянхошуунд болохгүй байгаа асуудлыг тэнд амьдарч байгаа хүнээс илүү сайн мэдэхгүй шүү дээ. Өөрийн биеэр мэдэрч байгаа асуудалд иргэн илүү санаа тавьж, шийдэхийн төлөө арга зам хайна. Гол нь иргэд асуудлыг илүү бодитой мэдэж байгаа учраас бид оролцоог хангаж ажиллахыг эрмэлзэж байна. Цаашдаа “Иргэний танхим” бүх хороонд байгуулагдана. Энэ бол иргэдийн оролцоог хангаж байгаа том ажлын нэг.

**-Хотын иргэдийн сэтгэлгээ өөрчлөгдөж байна. Үүнд та бүхний оролцоо, ажлын үр дүн нөлөөлсөн байх. Нөгөөтэйгүүр сэтгэлгээнд өөрчлөлт гарахын хэрээр хөгжил хурдсах болов уу?**

-Хүмүүсийн сэтгэлгээ өөрчлөгдөж байна. Энэхүү сэтгэлгээг илүү өөрчлөхийн тулд үүрэг хүлээсэн шийдвэр гаргагчид өөрсдөө сайн ажиллах хэрэгтэй байгаа юм. Хотынхоо хогийг цэвэрлэхгүй мөртлөө хогоо битгий хая гээд хэлэхэд үүнийг хэн ч хүлээж авахгүй. Тиймээс сэтгэлгээ өөрчлөгдөх орчныг бүрдүүлж өөрсдөө хийж үзүүлэх ёстой. Ингэснээр тавьсан шаардлагыг иргэд илүү хүлээж авна. Тэр сэтгэлгээ суугаад ирэхээр цаашдаа тийм байх ёстой гэсэн хэвшил тогтоно. Хөгжсөн орныхон бидэнд хэлдэг л дээ. Та нарт хөгжих сайхан боломж байна. Бидний алдааг битгий давтаарай гэж. Тэд чинь алдаагүй явсаар энэ зэрэгт хүрээгүй шүү дээ. Олон удаа алдаж, онож одоогийн хөгжлийг бүтээсэн. Тиймээс бид тэднээс суралцаж, алдааг нь давтахгүйгээр цааш хөгжих ийм боломж байгаа.

**-Гэр хороллын дахин төлөвлөлт түүхэн бүтээн байгуулалт мөн үү?**

-Түүхэн гэж хэлж болно. Маш том бүтээн байгуулалт. Энэ бол зөвхөн эхлэл. Аливаа зүйлийг хөндлөнгөөс харах амархан. Харин асуудал өрнөөд ирэхээр олон хувилбар гарч ирдэг. Хүн гэдэг чинь нэг ертөнц. Сайхан амьдрахын төлөөх бодгаль. Ганц өөрийнхөө төлөө биш гэр бүл, тухайн хашаанд амьдарч байгаа хүмүүсийн өмнө хариуцлага хүлээж байгаа. Бид хотын төлөө хариуцлага хүлээж байгаа бол тэр хүн бас гэр бүлийнхээ өмнө хариуцлага хүлээж байна. Энэ хүнтэй тохирно гэдэг амаргүй. Хоёрдугаарт, орон сууц барина гэдэг бол нүсэр ажил биш л дээ. Харин тухайн орон сууцны дэд бүтцийг нь яаж шийдэх вэ гэдэг өөрөө том асуудал. Улаанбаатарын хувьд эрчим хүчний эх үүсвэр дутагдалтай байгаа. Энэ бүгдийн дундуур зохицуулах, заримыг нь хүчээр явуулах ч юм уу янз бүрийн аргаар шийдээд ажил урагшилж байна. Гэр хорооллын дахин төлөвлөлтийн 12 байршилд 14 компани бүтээн байгуулалтын ажил өрнүүлэхээр Чингэлтэй, Сүхбаатар, Баянзүрх, Сонгинохайрхан дүүрэгт ажлаа эхэлсэн.

**-Нийслэлийн хүн амын нэлээд хувийг хүүхэд, залуус эзэлж байна. Тиймээс энэ хэсэгт хандсан бүтээн байгуулалтыг хийх үү?**

-Хүүхэд, залуус, ахмадууд болон хөгжлийн бэрхшээлтэй иргэддээ хүндлэлтэй хандах учиртай. Нөгөөтэйгүүр энэ бүгдийн иж бүрдэл байх ёстой. Залуучууддаа ээлтэй байна гээд гүйлтийн болон дугуйн зам тавиад байвал өрөөсгөл. Ахмаддаа ээлтэй байна гээд ахмадын орон сууц бариад байвал бас өрөөсгөл. Энэ бүхнийг ижил тэгш анхаарах хэрэгтэй. Дугуйн болон гүйлтийн замаа ч барих хэрэгтэй. Хөгжлийн бэрхшээлтэй иргэндээ орж гарахад нь хялбар үүд хаалгатай болох, ахмадууд чөлөөт цагаа өнгөрөөх цэцэрлэг байгуулах ажлыг иж бүрэн бий болгох учиртай. Гол нь хот маань төлөвлөгөөтэй хөгжих ёстой. Бидний хувьд тодорхой бүтээн байгуулалт хийхэд заавал хэсэгчилсэн төлөвлөгөө баталж байгаа. Ингэснээр хот зохистой хөгжих юм.

**-Хотын инженерийн байгууламж нэлээд хуучирсан. Үүнийг шинэчлэхэд хэдий хэмжээний хөрөнгө шаардлагатай вэ?**

-Улаанбаатар хотод 1957 онд татаж байсан кабель. 1960-аад оны дулааны шугамыг одоо ашиглаж байна. Энэ бүгдийг шинэчлэх шаардлагатай байгаа. Үүнд 2.7 их наяд төгрөг хэрэгтэй. Энэ нь хотын төсвөөс 10 дахин их. Энэ бүх санхүүжилтийг улсын төсвөөс авна гэвэл хөгжил саатна. Монгол Улс хөгжих ёстой. Уг асуудлыг хурдан хийхийн тулд инженерийн шийдэл байхаас гадна хөрөнгийн асуудал бий. Инженерийн шийдлийг манай монгол инженерүүд хийж чадна. Хөрөнгөө яах вэ. Энэ асуудлыг шийдэхийн тулд Нийслэлийн татварыг бий болгох саналыг УИХ-д тавьсан. Нийслэлийн татварыг нэг хувиар л бий болгочихоё. Өнөөдөр та 1000 төгрөгийн талх авах юм бол 10 төгрөг нь, 10 мянган төгрөгийн худалдаа хийвэл 100 төгрөг нь нийслэлийн татварт орох юм. Энэ нь хотын иргэнд дарамт болохгүй гэж үзэж байгаа. Ийм байдлаар татвараа цуглуулаад хотын өмнө тулгамдаж буй асуудлаа шийдэх, амьдралын чанараа дээшлүүлэхэд зарцуулж байхаар тооцоолсон. Хотын татварын зарцуулалт нээлттэй, ил тод тунгалаг байх ёстой. Энэ жил хотын татварт 100 тэрбум төгрөг бүрдсэн гэхэд түүнийхээ 50 тэрбум төгрөгөөр нь дулааны шугамаа янзалж, үлдсэн хөрөнгөөрөө III хорооллын ийм байшинг засаж сайжруулаа гээд ил тод зарлах жишээтэй. Ингэх юм бол улаанбаатарчууд татвараа нуухын төлөө бус татвараа төлөхийн төлөө явна. Татвар төлөх нь хотын иргэний том соёл. ■



*Нийслэлийн хуучин хорооллуудын барилгыг сэргээн засварлахад 450 тэрбум төгрөг хэрэгтэй гэсэн судалгаа гарчээ.*

ТӨСӨВ

# ИРГЭНИЙ ОРОЛЦООТОЙ ТӨСВИЙН ӨНГӨ

**Б.АЛТАЙ**

“Нээлттэй нийгэм форум”-ын “Орон нутгийн төсвийн ил тод байдал-2011” судалгааны тайланд дурдснаар хотын төсөв хаалттай гэх нэр зүүсээр цөөнгүй жилийг үдэж буй. Тэгвэл эл байдлыг өөрчлөх, иргэдээ сонсох санаачилга дор хот ирэх оныхоо төсвийг нээлттэй хэлэлцэв. Бид хотын иргэн. Гэвч хот ямар төсөв хэрхэн баталж байгааг тодийлэн мэдэхгүй өнгөрөх нь бий. Тухайн жилийн төсөвт хэчнээн сургууль, цэцэрлэг, эмнэлэг барих санхүүжилт суусан талаарх нарийн мэдээллийг тогтож бас тоож үздэггүй. Тоож үзлээ ч ач холбогдол өгдөггүй. Амьдарч буй хотынхоо “гал тогоо”-нд бус “зочны өрөө”-нд эргэлдсээр. Татвар төлдөг хэрнээ төсөвт суусан амин чухал бүтээн байгуулалтын ажлын үр дүнг нэхдэггүй. Хороо, дүүргийнхээ хөгжил цэцэглэлтэд оролцох бус хөндлөнгөөс шүүмжлэх нь бидний алдаа юм. Нэг талаасаа оролцох гэдэг шүүмжлэхийн нэр биш.

Төсвийн хяналт, хариуцлагын тогтолцоо өнгөрсөн хугацаанд зөвхөн билгэдэл төдий явж. Эцэст нь төсвийн мөнгө салхинд хийсч, төр саар нэртэйгээ хоцрох муу жишиг тогтжээ. Засаглал суларч, хариуцлагын тогтолцоо бүдгэрэх тусам хотын асуудал “хоолой”-д торж үлдсээр. Өнөөдөр алхах гудамж, зугаалах өргөн чөлөө, үр хүүхдээ салхилуулах цэцэрлэггүй өндөр байшин хотыг хэржээ. Мэдээж өндөр барилга хөгжлийн нэг үзүүлэлт. Гэвч ногоон байгууламж, автомашины зогсоолгүй бол зэрэглэл буурна.

Өмнө нь мөнгөгүй гэдэг байсан бол өнөөдөр газаргүй гэх шалтгаанаар төсвийн хөрөнгө оруулалт ухарч байна. Иймээс тухайн дүүрэг газрын асуудлаа элдэв маргаангүй шийдсэн тохиолдолд хотын төсөвт оруулахаар тогтжээ. Өөрөөр хэлбэл, газрын маргаан, хууль бус газарт сургууль, цэцэрлэг шинээр баригдахгүй гэсэн үг. Энэ тохиолдолд урьдын бэрхшээл үргэлжилнэ. Энэ онд л гэхэд газаргүй гэх шалтгаанаар хотод нийгмийн зургаан байгууламж хойшилсон байна.

Нийслэл энэ сарын 28-нд төсвөө хэлэлцэж батлах юм. Ирэх оны төсвийн орлого нь 443.3 тэрбум төгрөг. Энэ нь нийт улсын төсвийн таван хувьтай тэнцэж байгаа юм. Хотын удирдлагууд ДНБ-ий 63 хувийг ганцаараа бүрдүүлж байгаа атлаа төсвийн хуваарилалт шударга бус байгааг хэлдэг. Наанадаж 10 хувийг нь төсөвт тусгаж байвал инженерийн



байгууламжаа шинэчлэх, дэд бүтцийн ажилд хөрөнгө мөнгөний хомсдол үүсэхгүй гэх. Нийслэлийн хуучин хорооллуудын барилгыг сэргээн засварлахад 450 тэрбум төгрөг хэрэгтэй гэсэн судалгаа гарчээ. Хэрэв ийм хэмжээний мөнгөтэй бол 3-4 жилийн дараа гэхэд III, IV, XIII хорооллыг шинэчлэх ажил төвөггүй биелэх юм.

Хотжилт хүрээгээ тэлсээр. Улаанбаатар хотын нийт хүн ам ч цаашид улам нэмэгдэнэ. Сүүлийн арван жилийн хугацаанд хотын хүн ам хоёр дахин өссөн байна. Энэ хэрээр хотын төсвийн орлого, зарлага өсөн нэмэгдэж буй. Гэхдээ хотын төсөв хэт данхайж байгааг “Иргэд төсвөө хянана” төрийн бус байгууллагын тэргүүн Д.Цэрэнжав анхааруулсан юм. Тэрбээр “Жил бүр сургууль, цэцэрлэг барихаар хөрөнгө хуваарилдаг ч явц нь удаан, хяналт сул, төсвийн хөрөнгийг үр ашиг муутай зарцуулж байна” гэв.

Уг нь хотод том амбийц бий. Тиймээс төсвөө хэмнэх, үр ашигтай зарцуулж байж хотын захиргааг Баянхошуу руу нүүлгэнэ. Улаанбаатар хотоо нэг төвт хотоос олон төвт болгон хөгжүүлэх түүхэн шийдвэр ажил хэрэг болно.

Нийслэлийн ирэх оны төсвийн төслийг сонирхлоо. Сүүлийн гурван жилд хотын төсвийн урсгал зардал хоёр дахин өссөн бол хөрөнгийн зардал зургаа дахин нэмэгджээ. Хотын хэмжээнд энэ онд 1.1 их наяд төгрөгийн хөрөнгө оруулалтаар бүтээн байгуулалтын ажил хийгдэх юм. Тухайлбал, Орон нутгийн хөгжлийн сангаас Улаанбаатар хотын ногоон байгууламжийг нэмэгдүүлэхэд 2.5 тэрбум төгрөг хуваарилжээ.

Нийслэлийн төсвийн орлогыг ирэх онд 443.3 тэрбум төгрөг байхаар урьдчилсан байдлаар тооцоолж байна. Үүний 416.7 тэрбум төгрөг нь татварын орлого, үлдсэн нь татварын бус орлого байх нь. Нийслэлийн есөн дүүрэг болон харьяа 43 агентлаг, байгууллагаас ирэх онд 354.1 тэрбум төгрөгийн урсгал зардал авах хүсэлт ирүүлжээ. Тухайлбал, нийслэл, дүүргийн хот тохижуулах зардалд энэ жил 40.6 тэрбум төгрөг зарцуулсан бол ирэх онд 112.4 тэрбум төгрөгийг зарцуулах бололтой.

Нөгөөтэйгүүр Улаанбаатар хот үнэт цаас гаргах эрхтэй. Мөн улсын төсвөөс дөрөв хүртэлх жилийн хугацаатай зээл авч болно. Үүнээс гадна Азийн хөгжлийн банк, Дэлхийн банкнаас дэмжлэг авах боломжтой. Иймээс төсвөөс гадуурх орлогыг хот нэг их зовохгүйгээр бүрдүүлэх гарц бас бий. Дэлхийн банкны “Улаанбаатар хотын санхүүжилт” тайланд “Нийслэлийн нийт орлогын 80 хувийг хотын өөрийн орлогын эх үүсвэр бүрдүүлж байна. Улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг нь 21 хувьтай байна” гэж тэмдэглэсэн. Зүүн Өмнөд, Европын орнуудад нийт орлого ба өөрийн эх үүсвэрийн харьцаа нь дунджаар 34 хувьтай байдаг аж. Эдгээр улсад орон нутгийн төсөв нь өөрийн татварын орлогоос бус Засгийн газраасаа хамаардаг байна.

Нийслэлийн төсвийн нийт урсгал зардал 2008 онд 39 тэрбум төгрөг байв. Энэ тоо 2011 онд 141 тэрбум төгрөг болж өссөн. Урсгал зардлын дийлэнх хэсгийг оюутан сурагч болон өндөр настай иргэдийн нийтийн тээврийн татаасанд зарцуулжээ. Энэ нь нийт төсвийн урсгал зардлын 49 хувьтай тэнцэж байгаа бол захиргааны зардал 25 хувийг эзэлж байна.

Улаанбаатарчууд хотын төсөв гэхээс илүү улсын төсөвт санаа зовних нь бий. Үүнийнхээ “шан”-г жил бүрийн намар хүртэж, сургууль, цэцэрлэгийн эрэлд морддог. Анги дүүргэлт хэтэрсэн болохоор танил тал, таван цаасаа бариад гарах нь ердийн үзэгдэл. Ийм “хувь заяа”-тай эвлэрч бас эвсэн нэгдэж өнөөдрийг хүргэсэн. Товчхондоо, Улаанбаатар хотоо Монгол Улс гэж хөдөөнийхөн маань хараад байдаг. Гэтэл улс доторх энэ “улс”-аа Улаанбаатарынхан авч хэлэлцдэггүй. Хотын иргэн гэдгээ бас мэддэггүй, мэдэрч чадахгүй байгаа нь та бидний дутагдал юм. Өөрөөр хэлбэл, хорооны “үйлчилгээ”-нээс илүү гарах нь ховор. Энэ хэрээр хотын амьдрал бидэнд хол, хөндий байгаа ч юм шиг санагдах нь бий. Төсвийн алдагдал, өр, хуулийн хэрэгжилт гээд бидний “фокус” замхардаг. Угтаа бол нийслэлийн иргэд улсын төсвөөс илүү нийслэлийн төсөвт хамаатай. Ингэж байж л хотын төсөв ил тод нээлттэй, хөгжлийн төсөв болох юм.

АСУУДАЛ

# ХОТ ДАГАСАН АСУУДАЛ

**Э.ТАМИР**

Улаанбаатар хот 2030 он гэхэд 1.7 сая гаруй хүн амтай болох төсөөллийг Нийслэлийн зураг төслийн хүрээлэн гаргажээ. Хүн ам нэмэгдэх тусам хот ачааллаа дийлэхээ байж нийгмийн дэд бүтцийн хүрэлцээ нь олон нийтэд тэгш хүрч чадахгүй байна. Үүнтэй холбоотой эрүүл мэндийн үйлчилгээ доголдож, сургууль цэцэрлэгийн хүрэлцээ хомс, ядуурал, ажилгүйдэл газар авч нийслэлчүүд бухимдуухан бас гундуухан аж төрнө. Энэ мэт нийгмийн өмнө тулгамдаад байгаа асуудлыг тоочоод байвал дуусахгүй. Утааны асуудлаас аваад хотын соёл гээд ярих зүйл олон. Энэ бүхний шалтгаан нь чухам юу байна вэ. Нийслэлийн Засаг даргын орлогч Ц.Энхцэнгэл “Улаанбаатар хотод тулгамдаад байгаа асуудлын ихэнх нь хүн амын механик өсөлттэй холбоотой. Учир нь 600 гаруй мянган хүн амд зориулсан дэд бүтэцтэй хотод Монголын нийт хүн амын тал нь амьдарч байна шүү дээ. Тиймээс хот ачааллаа даахгүй байна” гэв.

## Асуудал эртнээс эхэлжээ

Улаанбаатар түүхэндээ хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг зургаан удаа гаргасан байдаг. Анхдугаар ерөнхий төлөвлөгөөг 1954 онд Москва хотын “Гипрогор” институтэд боловсруулж байжээ. Уг төлөвлөгөөгөөр 1954-1974 онд хотын хүн ам 125 мянгад хүрэхээр тооцоолжээ. Энэ төлөвлөлтийн дагуу өнөөгийн Улаанбаатар хотын төв хэсэг болох Бага тойруу, Их тойруугийн зарим хэсгийг байгуулсан байна. Гэвч 1960 онд буюу зургаахан жилийн дараа хотын хүн ам 180 мянгад хүрсэн тул ерөнхий төлөвлөгөөг дахин шинэчлэхээс өөр аргагүй болжээ. Нийслэлийн одоогийн авто замын сүлжээ 50 жилийн өмнөх үеийн төлөвлөлтөөр явж байгаа гэхэд хилсдэхгүй. Учир нь анхны ерөнхий төлөвлөгөөнд замыг өргөтгөх, шинээр тавих нөөц талбай муутай тусгажээ. Гэтэл одоо автомашины тоо тэр үед тооцоолж байснаaас 110 дахин өссөн байх жишээтэй. Үүнтэй холбоотой өнөөгийн нийгэмд хамгийн их тулгамдаж буй асуудлын нэг нь замын түгжрэл юм.

Хоёр дахь ерөнхий төлөвлөгөөг 1961 онд баталсан. Үүний хугацаа нь 20-25 жилээр, хүн амын өсөлт нь 250 мянга байхаар тооцжээ. Энэ төлөвлөлтийг үндэслэн Туул голын хөндий дагуу 20 км урт, 6-8 км өргөнтэй, 3900 га талбайг барилгажуулсан байна. Гэвч хүн ам 1975 онд 348.7 мянгад хүрч хот бүх хүчин чадлаараа ажиллаж эхэлсэн аж. Дахиад л хүн амын өсөлтийн төсөөлөл дээр алдаа гаргасан нь энэ байлаа. Учир нь, шинэ мянганд малчин монголчуудын хотод амьдрах хүслийг мэргэжлийнхэн зөв тооцоолж чадахгүй байсан бололтой. Ийнхүү гурав дахь ерөнхий төлөвлөгөөг “Гипрогор” институтэд 1975 онд боловсруулж батлуулжээ. Хүн амыг 2000 он гэхэд 400 мянга байхаар тооцоолсон ч энэ нь бас л алдаж, хотын хүн амын өсөлт 1986 он гэхэд дээрх төлөвлөсөн тооноос даваад талийжээ. Тиймээс дөрөв дэх ерөнхий төлөвлөгөөг гаргаж орон сууцны 21 хороолыг 30 болгон нэмэгдүүлж, хотын хүн амын нягтаршлыг сааруулах асуудлыг дэвшүүлсэн байна. Гэтэл 1990 он гарч нийгэм, эдийн засаг шилжилтийн он жилүүд үргэлжилж, Улаанбаатар хот





ямар ч төлөвлөгөөгүйгээр тэлэв. Нийслэл утга учиргүй хүн амын бөөгнөрөл болон хувирчээ. Үүнтэй холбоотой бэрхшээлүүд үүсч өдгөө улам бүр хүндэрсээр.

## Үйлчилгээний хомсдол

Нийслэлчүүдэд хүртээмж муутай байгаа нь үйлчилгээ юм. Эрүүл мэндийн болоод боловсролын салбарын үйлчилгээ өдгөө нойл заачихаад байна. Эрүүл мэндийн салбарын тухайд материалаг бааз дутагдалтай, орчин үеийн нарийн мэргэжлийн оношилгоо, эмчилгээний тоног төхөөрөмж ховор. Эмч, мэргэжилтнүүдийн мэргэжил мэдлэгийг дээшлүүлэх сургалтын оновчтой тогтолцоо бүрдээгүй гэх мэт. Тиймээс оношийн зөрүү гарах, олон дахин шинжилгээ хийлгэж өвчтөнийг чирэгдүүлэх, эмнэлгийн үйлчилгээ авах иргэдийн урт дараалал үүсэх, өвчнийг оройтож оношлох нь түгээмэл. Түүнчлэн эмнэлгийн тусламж үйлчилгээнд хүмүүсийн итгэл буурах, улмаар гадаадад өндөр өртгөөр оношилгоо, эмчилгээ хийлгэхээр явагсдын тоо эрс өсөх зэрэг иргэдэд халгаатай сөрөг үр дагаврууд бий болсоор.

Мөн боловсролын салбарын хүртээмж тааруухан. Нийслэлийн Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын асуудал хариуцсан орлогч С.Очирбат “Өнөөдрийн байдлаар Улаанбаатар хотын хэмжээнд цэцэрлэгт хамрагдаагүй 31 мянга гаруй хүүхэд байгаа. Цэцэрлэггүй 42 хороо бий. Түүнчлэн сургууль гүй 31 хороо, сургууль цэцэрлэгийн аль аль нь байхгүй 14 хороо байдаг. Ер нь Улаанбаатар хотын хэмжээнд нийт

115325 хүүхдийн сургууль цэцэрлэгийн эрэлт хэрэгцээ байгаа. Энэ нь тус бүр 240 хүүхдийн 220 цэцэрлэг, 640 хүүхдийн 97 сургууль барих шаардлагатай гэсэн үг юм. Өнөөдөр нийслэлд 185 цэцэрлэг, 118 сургууль байгаа нь тун хангалтгүй тоо” гэсэн юм. Үүнээс гадна нийслэлд нийгмийн эмзэг хэсэгт үзүүлэх тусламж үйлчилгээ байхгүйтэй адилхан. Энгийн жишээ дурдахад яам, тамгын газрууд, үзвэр, үйлчилгээний төвүүдэд нь ч хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг мартчихсан. Бусад байгууллага нь байг гэхэд Эрүүл мэндийн яам нь ч хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тусгай шатгүй гээд бод доо. Хотын явган хүний зам нь хөгжлийн бэрхшээлтэй иргэн явах нь бүү хэл, эрүүл хүн явахад ч бэрхтэй. Энэ мэт нийгмийн үйлчилгээний асуудлыг тоочоод байвал их.



Фотог Б.Бямба-Очир

*Чулуутын хогийн цэг*

## Ядуурал

Нийслэлчүүдийн хамгийн эмзэг асуудал бол ядуурал. Үндэсний статистикийн хорооноос гаргасан судалгаагаар ядуурал буурч 30

орчим хувьд хүрсэн. Хэдийгээр энэ нь буурсан үзүүлэлт боловч ядуурал бодитоор байна. Ер нь аливаа хотод ядуурал байгаа нь тухайн нийгэмд орлогын тэгш бус байдал газар авч, баян, ядуугийн ялгаа нэмэгдэж, нийгмийн үйлчилгээний болон баялгийн хуваарилалт жигд биш байгаагийн илрэл гэж үздэг. Манайд ядуурал 30 орчим хувьтай байгаа бол Норвеги улсад гурван хувь байна. Энэ нь тухайн орны хөгжил, нийгмийн тэгш хуваарилалтыг харуулах гол үзүүлэлт юм. Мянганы хөгжлийн зорилтын дотоодын зөвлөх Ш.Мөнхцэрэн “Өрх, хувь хүн, нийгэм эдийн засгийн байдлаас хамаарч ядуурлын түвшин өөр өөр байдаг. Ажлын байр бий болголоо гэхэд ядуу иргэдийн олонх нь тухайн ажлын байранд тэнцдэггүй. Ямар ч албан байгууллага ашгийн төлөө байдаг учраас хөдөлмөрийн бүтээмж өндөртэй ажилтан авах болно. Харин ядуу иргэд тэр шалгуурыг хангахгүй бол яах вэ. Ажлын байр байсан ч ажил хийж чадахгүй гэсэн үг. Дээрээс нь эдийн засаг өсөлттэй үед ажлын байр нэмэгдэх ч эдийн засгийн өсөлт саарахад ажилгүйдэл эргээд л нэмэгддэг. Тиймээс Монголын тэр дундаа Улаанбаатар хотын ядуурал нь маш эмзэг мэдрэмтгий зүйл юм” гэв. Ийм учраас ядуурлыг бууруулах бодлого хэрэгжүүлэх болон хэмжиж үзэхдээ болгоомжтой байхыг судлаачид анхааруулж байгаа. Дээрээс нь хамгийн сүүлийн судалгаагаар нийслэлийн ядуу иргэдийн 29 хувь ядуурлын гүнзгийрэлд буюу нэн ядуу гэх ангилалд багтаж байна. Энэ бүгдийн эхлэл бол нөгөө л хотын буруу төлөвлөлт, хүн амын механик өсөлттэй шууд ба шууд бусаар холбоотой гэх. Ядуурлын талаар судалдаг доктор С.Даваасүрэн “Орон нутгаас сайхан амьдрал зорьсон иргэд Улаанбаатарт ирээд ядуусын тоог нэмэх нь олонтаа. Үүний гол шалтгаан нь нийгмийн суурь үйлчилгээ муу байгаатай холбоотой. Өнөөдөр манайд энэ талын хөрөнгө оруулалт маш бага байгаа” гэсэн юм.

## Шинэ төлөвлөгөө

Нийслэл Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөг албан ёсоор 2002 онд баталсан. Энэ төлөвлөгөө нь монголчууд анх удаа өөрсдөө гар бие оролцон хийсэн төлөвлөгөө гэдгээрээ онцлог. Шинэчлэлийн Засгийн газар гарснаар уг төлөвлөгөөнд тодотгол хийж 2030 он хүртэлх нийслэлийн хөгжлийн чиг хандлагын талаарх баримт бичгийг боловсруулсан. Түүний гол онцлог нь нийгмийн хөгжлийн асуудлыг голчлон анхаарч орон нутгаас шилжин ирэгсдийг ад үзэх биш, харин ч хотын соёлтой иргэн болгоход чиглэжээ. Мөн Улаанбаатар хотыг эдийн засгийн хөгжлийн төв цэг болгоход анхаарч байгаа аж. Үүний тулд дагуул хотуудыг хөгжүүлэх, эрүүл мэнд боловсролын салбарыг дэмжих замаар нийгмийн өмнө тулгамдаж байгаа асуудлыг шийдэхээр зорьжээ. Ц.Энхцэнгэл “Өнөөдөр хотын нийгмийн өмнө тулгамдаж байгаа асуудлын цөм нь хүн юм. Тиймээс ирээдүйн ухаалаг, санхүүгийн өндөр чадамжтай Улаанбаатар хотыг бүтээхийн тулд эхлээд хүнээ бэлтгэх хэрэгтэй. Үүнтэй зэрэгцээд хотоо хөгжүүлнэ. Аль нэг талыг нь орхигдуулчихвал хот хөгжихгүй. Энэ хэвээрээ хэдэн зуун жил ч болж мэднэ. Тиймээс Нийслэлийн хэрэгжүүлж байгаа ихэнх төсөл хөтөлбөр, хийж байгаа ажил нь ажил орлоготой, соёлтой дундаж давхаргыг бий болгоход чиглэж байгаа. Үүний тулд нийгмийн суурь үйлчилгээ буюу эрүүл мэндийн болон боловсролын салбарт анхаарч байна” гэв. Учир нь эрүүл мэндийн капитал өндөр байх тусмаа боловсролын хөрөнгө оруулалтын үр өгөөжийг нэмэгдүүлдэг. Боловсролын капитал хэдий өндөр байна эрүүл мэндийн хөрөнгө оруулалтын үр өгөөжийг сайжруулна. Эрүүл мэнд эсвэл боловсролд хийж буй хөрөнгө оруулалт нь ирээдүйн өндөр орлоготой хөдөлмөрийн бүтээмж сайтай иргэдийг бий болгодог аж. Өндөр орлоготой, эрүүл, боловсролтой иргэд соёлтой, илүү дээд зиндааны амьдралын төлөө зүтгэх нь дамжиггүй. Тиймээс эрүүл мэнд, боловсролын салбарт хөрөнгө оруулах нь шууд мэдрэгдэх бодит үр дүн бага хэдий ч ирээдүйд үзүүлэх эдийн засгийн болоод нийгмийн асар том үүрэгтэй гэдгийг хэлэх хүн олон.




### Улаанбаатар хотын хүн ам (2013 оны нэгдүгээр сарын 1-ний байдлаар)

| | |
|---|---|
| Байнга оршин суугч | 1226991 |
| Эрэгтэй | 580981 |
| Эмэгтэй | 646010 |
| Шилжин ирэгсэд | 19887 |
| Шилжин явагсад | 7024 |
| Механик өсөлт | 12863 |
| Ердийн өсөлт | 25770 |

## ТООНЫ ХЭЛЭЭР

Нийслэлийн 2013 оны хөрөнгө оруулалтын ажлын явц, төлөвлөлтийн талаарх тоон мэдээллийг хүргэж байна.

### 2013 оны нийслэлийн хөрөнгө оруулалт (эх үүсвэрээр тэрбум,төг)




Нийслэлийн хэмжээнд 2013 онд Улс, Нийслэл, Орон нутгийн хөгжлийн сан, Бондын хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр 897,0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажил шинэчлэлт хийгдэж байна


### 2013 оны нийслэлийн хөрөнгө оруулалт дүүргээр /тэрбум.төг/





### 2013 онд нийслэлд хийгдэх хөрөнгө оруулалтын ажлууд салбараар (Хөрөнгийн дүн сая.төгрөгөөр)





### 2013 онд нийслэлд хийгдэх хөрөнгө оруулалтын ажлуудыг салбараар




### Хэрэгжиж буй ажил (тоо хэмжээ)




### Хэрэгжиж буй ажил (тоо хэмжээ)




*Эх сурвалж: НЗТГ-ын Стратегийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс*

# УЛААНБААТАРЫН ШИНЭ ӨНГӨ-ФОТО



*“Үндэсний цэцэрлэгт хүрээлэн” нь нийт 183 га талбайг хамарсан. Үүнээс эхний ээлжийн 30 га талбайд бүтээн байгуулалтын ажил хийгдэж нийслэлчүүдэд үүд хаалгаа нээгээд байна*





*23.00 цагаас хойш Улаанбаатарын төв талбайг ийн угаадаг.*





*“Гудамж” төслийн 10 дугаар хорооллын шинэчилсэн уулзвар*





-Хотын 24 байршилд 5000 ам метр талбай бүхий цэцгийн мандал байгуулжээ.



-Өнгөрсөн хавар 200 мэргэжлийн цэцэрлэгчийг шинээр бэлтгэн, ажлын байраар хангажээ.





Давс цацаж буй нь



Нийслэлийн 22-ын товчооны шинэчлэл



“Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр”-ийг хотын хэмжээнд зохион байгуулж, нийт 46,2 мянган ширхэг мод, 130,0 мянган ширхэг сөөг шинээр тарьжээ.

ХОТ ТОХИЖИЛТ

# ТҮНШЛЭЛИЙН ГУДАМЖ




**Б.БАЯР**

Хотын нийт хүн амын 67 хувийг хүүхэд, залуучууд эзэлж байна. Үүний 30 хувь нь хүүхэд. Тэд ирээдүйн хотын эзэд. Улсаа мандуулах бас хөгжүүлэх итгэл найдвар. Зөвхөн итгэл найдвар төдийгүй амьдрах утга учир. Тэд бол та бидэнд бүтээлч амьдралын эрч хүчийг өгөх “бурхад” юм. Иймээс алхам бүрт өөрийнхөө төлөө шийдвэр гаргахаас илүүтэй ирээдүйнхээ төлөө, энхрий нялх үрсийнхээ жаргалт амьдралын өмнөөс хараа цэх, сэтгэл шулуун, ухаан цэлмэг аж төрөх үүрэгтэй улсаа, бид. Тиймээс “нүүдэл” хийх бүртээ ирж яваа цагийн сайн сайхныг бодох учиртай. Сайн сайхан нийгмийг цогцлоох. Тэнд эрүүл саруул амар тайван аз жаргалтай амьдрах суурь нөхцөл бүрдүүлэх нь өнөөдрийн хүн бүхнийг баялаг бүтээгч болгон хувиргахад хүргэж байна.

Хэрвээ Сингапур, Тайланд, Өмнөд Солонгос, Япон, Хятадын нэг үеийнхэн ирээдүйн төлөө тэмцээгүй бол, хөдөлмөрлөж, хөлс хүчээ урсгаагүй бол, шинэчлэл хийгээгүй бол аль аль нь жирийн нэг орон байх байлаа. Тэгвэл өнөөдөр хөгжлийн үзүүлэлтээрээ Азийн бүс нутагтаа тэд манлайлаад зогсохгүй дэлхийн эдийн засгийн хүчирхэг гүрэн болсныг цаг хугацаа гэрчилнэ. Үүнтэй адил бидэнд хөгжих, байрнаасаа хөдлөх цаг иржээ. Ухрах бус урагшлах нөхцөл нь тохиож. Үүний нэг баталгаа нь “Оюутолгой”. Харин тус ордыг ашиглан бодитой алхам хийх нь бидний хичээл зүтгэлээс хамаарах гээд байна.

Улаанбаатарт өнөөдөр нийгмийн хамгийн идэвхтэй хүн ам амьдарч байна. Тиймээс залуусын хот гэж нэрлэх нь бий. Тэгвэл залуусын хотод өнгө нэмсэн бүтээн байгуулалтыг “Оюутолгой” компани өөрийн санаачилгаар хийсэн нь олны талархлыг хүлээгээд байна. Ингэж л ирээдүйнхээ төлөө компани, аж ахуйн нэгж, хувь хүн гэлтгүйгээр гар нийлж ажиллах шаардлага “ургав”. Та МУБИС-ийн уулзвараас Спортын төв ордны баруун хойд уулзвар хүртэлх оюутны гудамжтай танилцаж амсан уу. Үгүй бол тэнд нэг тухлаарай. Хэрвээ яаралтай интернэт үйлчилгээ хэрэгтэй бол “WiFi”-тай тэр гудамжинд очоорой.

Сүхбаатар дүүргийн Бага тойруугийн гудамжийн дээрх хэсгийг “Оюутолгой” компани орчин үеийн технологи, зураг төслөөр тохижуулсан нь оюутан залуусын очих дуртай газрын нэг болжээ.

Өнөөгийн хотод байх ёстой ЛЭД гэрэлтүүлэг, явган хүний зам, амарч тухлах сандал, хогийн сав, үнэ төлбөргүй утасгүй интернэтийн сүлжээг энд суурилуулжээ. Энэхүү бүтээн байгуулалтад нийтдээ 400 мянган ам.долларын хөрөнгө зарцуулсан байна.

Улаанбаатар өдрөөс өдөрт өнгө засаж байгааг бид мэдэх. Гэсэн ч хотоо улам гоё болгох мөрөөдөл хязгааргүй. Хүний амьдарч буй орчин хэдий чинээ тохь тухтай байна энэ хэрээр нийгмийн сэтгэлзүй болоод сэтгэлгээнд эерэг нөлөө үзүүлдэг болохыг судлаачид олж тогтоосон байдаг. Бид үргэлж хаана ч явсан тав тухыг эрхэмлэх нь бий. Тэгвэл нийслэлд өрнөж буй бүтээн байгуулалтын үр дүн та бидний ажил, амьдралд сайнаар нөлөөлөх нь гарцаагүй. Тэр тусмаа урин дулаан цагт хотын гудамж цэмцгэр, цэгцтэй бас цэцэг алагласан байх нь хараа булаадаг.

“Оюутолгой” компани Нийслэлийн Засаг даргын тамгын газартай “Хөгжлийн төлөөх түншлэл” санамж бичигт гарын үсэг зурсан билээ. Тус санамж бичгийн дагуу “Оюутолгой”-д нийслэлийн Бага тойруу орчмын




Фотог Зохиогч

*Энэ гудамжаар өдөртөө 30-40 мянган оюутан явдаг*

гудамжийг шинэчлэх, тохижуулах санал тавьсныг ийн хүлээн авч санхүүжүүлсэн юм. Энэ нь нөгөө талаас төр, хувийн хэвшлийн түншлэлийн бодит жишээ юм.

Нийслэлийн Сүхбаатар дүүргийн Засаг даргын орлогч Л.Амарзаяа “Энэ гудамжаар өдөртөө 30-40 мянган оюутан явдаг. Оюутолгойн хөрөнгө оруулалтаар залуусын амьдрах орчин, нөхцөлийг сайжруулсан чухал бүтээн байгуулалт хийсэн” гэв. Тус гудамжны тохижилтын ажлыг Монголын хотуудын холбоо гүйцэтгэсэн байна. Хотын хөгжил бас тэнд амьдарч буй хүмүүсийн сэтгэлгээг мэдэхийг хүсвэл гудамж, талбайтай нь нэн тэргүүнд танилцдаг байна.

Улаанбаатар та бидний сэтгэл зүрхний хот. Хотод ирэхийг бид илүүд үзсэн. Хөдөө удаан амьдарч тэвчилгүй наашаа бүгдээрээ “зугатаасан”. Тиймээс уугуул иргэдээс илүү суугуул “нутагтан” давамгайлсан нийслэлд урьдын зүйл ул болж байна. Гэсэн ч дэлхийн томоохон хотуудад тулгардаг бэрхшээлтэй манай нийслэл нүүр тулах болсон. Замын түгжрэл, агаарын болон хөрсний бохирдол, эрчим хүчний хомсдол гээд хотод асуудал их бий. Тэгвэл хөгжлийн сул талаа засах нь зүй ёсны шаардлага. Наана нь дэлхийн хот болохоор зорьж буй Улаанбаатартаа иргэн бүр ухаалаг амьдрах илүү чухал юм. ■

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ



Фотог Э.Зоригт

*Бид газар олголтын замбараагүй байдлыг халсан*

# С.ОЧИРБАТ:

# НИЙСЛЭЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БОДЛОГО НЬ ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ЧИГЛЭНЭ

**Д.БЭХЭЭ**

***Нийслэлийн Засаг даргын Хот байгуулалт, хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан Орлогч С.Очирбаттай ярилцлаа.***

**-Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөг УИХ-аас саяхан баталсан. Энэхүү төлөвлөгөөг хэрэгжүүлэх эрх зүйн орчин бүрдсэн үү?**

-Өнөөдрийг хүртэлх хугацаанд Улаанбаатар хот нийт зургаан ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэн хөгжиж ирлээ. Хамгийн сүүлд 2002 онд Нийслэлийг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, Засгийн газраар батлуулсан. Гэхдээ уг төлөвлөгөөний хэрэгжилт маш удаашралтай явж ирсэн. Шалтгаан нь Засгийн газар Улаанбаатар хотын ерөнхий төлөвлөгөөг батлаад хэрэгжүүлэх ажлыг УИХ, Засгийн газар, хотынхоо төсөвт тусгах, УИХ-д уламжлах ерөнхий заалттай байсан. Ийм учраас бидний зүгээс ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлын хаана нь алдаад байгааг тогтоох, засан сайжруулах үүднээс 2006 онд Олон Улсын ЖАЙКА байгууллагад санал тавьснаар юун дээр алдаж ажлыг удаашруулснаа тогтоосон гэж хэлж болно.

ЖАЙКА-гаас ирсэн мэргэжлийн судалгааны баг танайх ерөнхий төлөвлөгөөгөөгөө бол хийжээ, харин Засгийн газар төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг нягтлан авч үзээгүйн зэрэгцээ ганц ч төгрөг хуваарилж батлаагүй юм байна. Нөгөө талаасаа Нийслэлийн тухайн үеийн эдийн засгийн нөхцөл байдал хүнд байсан. Гэхдээ хот санаачилгатай ажиллаагүйтэй холбоотой гэсэн дүгнэлт гаргасан. Энэхүү дүгнэлтийг Засгийн газарт оруулж, хэлэлцүүлсний үндсэн дээр 2020 оны ерөнхий төлөвлөгөөнд тодотгол хийхээр тогтсон. Тодотгол хийх мөнгийг улсаас гаргах хуулийн заалттай. Энэ хуулийн дагуу хөрөнгийг нь шийдэж өгснөөр Хот төлөвлөлтийн хүрээлэн, ЖАЙКА байгууллагын мэргэжилтнүүдийн дэмжлэгтэйгээр зөвлөхүүдийг урт богино хугацаагаар ажиллуулж, ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, УИХ-аар батлуулаа. Үүний хажуугаар хийсэн нэг ажил бол 2008 онд Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг УИХ-аар хэлэлцүүлэхдээ Нийслэл хотын ерөнхий төлөвлөгөөг УИХ батлах нь зүйтэй юм байна гэсэн бодлогын том асуудлыг оруулсан. Учир нь УИХ-ын баталсан ерөнхий төлөвлөгөөний шийдвэр, тогтоол нь хуулийн үйлчлэлтэй байдаг. Тиймээс ямар нэгэн хэлбэрээр ерөнхий төлөвлөгөөг зөрчих, түүнд өөрчлөлт оруулах эрх УИХ-д л байдаг учраас хэн болгон дураараа авирлах нь хумигдаж ирж байна гэсэн үг.

Хоёрдугаар асуудал нь ерөнхий төлөвлөгөөг УИХ батлахдаа уг төлөвлөгөөг хэрэгжүүлэх эхний үе шатанд 25.4 их наяд төгрөгийг жил бүрийн төсөв, хотын төсөв,

олон улсын хандивлагчид, бусад эх үүсвэрээс олж, санхүүжүүлэхээр тусгасан. 2020 он хүртэл ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд жил бүр 25.4 их наяд төгрөг хэрэгтэй гэсэн бодитой тоог баталж өгч байгаа юм.

**-Хууль эрх зүйн хүрээнд санхүүжилттэй нь асуудлыг шийдэж өгсөн гэж ойлгох уу?**

-УИХ-аар ерөнхий төлөвлөгөөг батлахын ач холбогдол гарсан. УИХ ерөнхий төлөвлөгөөг баталж, Засгийн газарт үүрэг даалгавар өгч, 25.4 их наяд төгрөгийг төсөвт суулгах, өөрөөр хэлбэл, хэрэгжүүлэх ажлыг хугацаа, мөнгөтэй нь тов тодорхой шийдэж өгч байгаа юм. Одоо бол Засгийн газар хотын ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх төлөвлөгөөг нарийвчилж гаргаж, хөрөнгө мөнгөтэй уяж өгснөөр тодорхой төслүүд болж хэрэгжих ёстой. Мөн дулааны асуудлаа хэрхэн шийдэх, эх үүсвэр нь бие даасан байх юм уу, инженерийн шугам сүлжээний хувьд одоогийнх шиг урт шугам татаад явах уу гэх мэт асуудлын нарийвчилсан төлөвлөгөөг Засгийн газар хэлэлцэн баталж, хотод болон бодлогын яаманд үүрэг өгөөд уялдаа холбоог нь хангаад ажиллах юм бол Улаанбаатар хотын ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажил эрчтэй явна. Олон ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх явцад алдаж оносон зүйл цөөнгүй бий. Социализмын үед ерөнхий төлөвлөгөө батлагдсан л бол тав таван жилийн төлөвлөгөөндөө тусгаад явдаг байсан. Тэгвэл зах зээлийн нийгэмтэй золгосон сүүлийн 20 жилийн хугацаанд ерөнхий төлөвлөгөөний зураг төслийн байгууллага уначихсан. Мэргэжилтнүүд нь хувь, хувьсгалын ажлаа хөөгөөд явсан байх жишээтэй. Зураг төслийн ажлыг орхигдуулсан тал бий.

**-Ерөнхий төлөвлөгөөг баталснаар цаашид нийслэлийг хөгжүүлэх бодлогод дэвшил гарсан гэж ойлгож байна. Одоо хэрхэн хэрэгжүүлэх вэ?**

-Том дэвшил гарч байгаа юм. Дөрвөн уулын дунд төвлөрсөн, хэт нягтаршсан энэ байдлаас татгалзах боломж бүрдэж байна. Улаанбаатар хот зөвхөн төвдөө төвлөрсөн, бүх үйлчилгээ бага тойргоос хамааралтай болчихсон, засаг захиргааны үйлчилгээ, их, дээд сургууль, урлаг соёлын байгууллага, дэлгүүр, бизнесийн төвүүд бүгд хотын төвд. Өнөөдөр бүх хүн хотын А бүс рүү явж байгаа. Тэгвэл үүнийг задлах ёстой. Ерөнхий төлөвлөгөөгөөр найман дэд төв, дагуул хоттойгоор хөгжүүлэхээр шийдсэн. Тухайлбал, Баянхошуу, Сэлбэ, Амгалан, Улиастай, Сонгино гэх мэтээр найман дэд төвийг хөгжүүлснээр төв рүү чиглэсэн их төвлөрөл саармагжина. “Тэнгис” кино театрт кино үзэх гэж Баянхошуунд амьдардаг хүн хотын төв рүү ирдэггүй, тэндээ үзвэрээ үздэг орчныг бүрдүүлмээр байна. Өнөөдөр бид орон сууцны хотхон хороолол байгуулахдаа хүн оройдоо очиж хонодог газрыг л төлөвлөж босгоод байдаг. Тэгвэл тэнд хүн ажиллаж, амьдардаг тийм орчин байх ёстой. Ийм байдлаар сэтгэх боломж бололцоог шинэ ерөнхий төлөвлөгөө олгож байгаа юм.

Хотын засаг захиргаанаас ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажил руу шуурхай орсон. Эхний ээлжинд Баянхошуу, Сэлбэ төвүүдийг хөгжүүлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх саналыг АХБ-нд өнгөрсөн жил тавихад тус банк 1.5 сая ам.долларын техникийн туслалцаа үзүүлсэн. Тус техникийн туслалцаагаар Баянхошуу, Сэлбэ төвийг хөгжүүлэх техник эдийн засгийн үндэслэл, зураг төслийг нь боловсруулж, хэлэлцээд сая Засгийн газарт оруулж, дэмжлэг авлаа. Мөн УИХ-ын холбогдох Байнгын хороогоор хэлэлцүүлээд гэрээ байгуулах эрхийг Засгийн газарт өгсөн байгаа. Үүний дагуу Азийн хөгжлийн банктай хэлэлцээр хийж, тус банк 224 сая, хот өөрөөсөө 96 сая ам.доллар нийтдээ 320 сая ам.долларын хөрөнгөөр Долоон буудлын орчим болон Баянхошууг бие даасан хотын дэд төв болгон хөгжүүлэх бодит нөхцөлийг бүрдүүллээ. Ийм замаар бид дараа дараагийн ажлуудыг эрчимжүүлнэ. Тухайлбал, Шувуун фабрик, Өлзийт хорооллыг хөгжүүлнэ. Энэ онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар авто замын асуудлыг нь бараг шийдсэн. Үүнтэй уялдуулаад төлөвлөлтийн ажлаа давхар хийгээд явах юм. Энэ нь тодорхой чиг үүрэгтэй хөгжих дэд төв байж болно. Нэг зүйлийг тэмдэглэхэд Өмнөд Солонгосын Эдийн засгийн хамтын ажиллагааны сангаас гэр хорооллын дахин төлөвлөлт, дэд төвийг хөгжүүлэх, орон сууцжуулах ажлуудад тодорхой хэмжээний хөрөнгөөр дэмжих санал тавьсан. Миний бие саяхан тус улсад ажиллаад ирлээ. Энэ асуудлыг энэ өвөл яаралтай ажил хэрэг болгож, ирэх хавар ажлыг эхлүүлэх хэрэгтэй байна. 25.4 их наяд төгрөгийг бүгдийг нь улсын төсвөөс авахгүй. Тодорхой хувийг нь улсын төсөвт суулгаж, заримыг нь олон улсын байгууллагаас олох, мөн хотын төсвөөс бүрдүүлэх даалгавартай ажиллаж байна.

**-25.4 их наядын тодорхой хэмжээний хэсэг нь саяхан баталсан 2014 оны төсөвт орж байгаа юу?**

-Бид УИХ-д ирэх онд хэрэгжүүлэх бодит ажлуудын саналаа хүргүүлсэн. Эхний ээлжинд 800 гаруй тэрбум төгрөгийн зураг төслийн ажлыг хэрэгжүүлэх боломжтой гэсэн санал тавьсан. Улсын төсөв батлагдсаны дараа хот төсвөө ярьдаг. Ер нь цаашдаа ерөнхий төлөвлөгөө батлагдсантай холбоотойгоор Улаанбаатар хотын хөрөнгө оруулалтын бодлого бол энэ ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх бодлого байх ёстой. Инженерийн шугам сүлжээг нь яах юм, барилга орон сууц, хотхон хорооллоо хэрхэн хангах, урт шугам хоолой татах уу гэх мэт бодлого ерөнхий төлөвлөгөөний хүрээнд ажил хэрэг болох учиртай.

Жишээлбэл, ерөнхий төлөвлөгөөний дагуу 14 дагуул хотыг хөгжүүлнэ. Энэ бүхэн дээр хэсэгчилсэн төлөвлөлт, нарийвчилсан зураг, төсөл хэрэгтэй болно. Тэгвэл 2014 оны улсын төсөвт 92.4 тэрбум төгрөг зураг төсөлд шаардагдах асуудлыг мөн УИХ-д хүргүүлсэн. Сайн зураг төсөлтэй байж сайн ажил хийнэ. Зураг төсөлд мөнгө өгдөггүй учраас зураг төсөлгүй баахан ажил хийхэд хүрдэг сул тал бий. Тухайн хийх ёстой зураг төслийг нь барьж байгуулах угсралтын ажилд




*Ерөнхий төлөвлөгөөгөөр найман дэд төв, дагуул хоттойгоор хөгжүүлэхээр шийдсэн.*

нь өгчихдөг. Тэгээд зургаа хийнэ гэдэг. Ингээд жил алдаж, хөрөнгө хураагддаг. Тиймээс зураг төслөө байнга өмнө нь явуулъя гэж байгаа. Өнгөрсөн жилд бидний хийсэн нэг ажил бол 2012 оны төсвийн тодотголоор 10 тэрбум, 2013 оны төсөвт 10 тэрбум төгрөг нийтдээ 20 гаруй тэрбум төгрөгийг суулгаж зураг төсөлд зарцуулж байна. Тэгэхээр зурагтай байж хөрөнгө босгоно, төсөлтэй байж хөрөнгө оруулалт татна. Төсөл хамтын ажиллагааны тусгай хэлтэс ч манайд ажиллаж байна.

**-Хөрөнгө оруулалтын бодлогод шинэчлэл гарсан уу?**

-Хууль эрх зүйн хувьд, бодлогод ч шинэчлэл гарсан. Төсвийн шинэ хууль хэрэгжиж эхэлсэн, үүн дээр хөрөнгө оруулалтын урт, дунд хугацааны хөтөлбөртэй байна гэсэн заалт бий. Тийм учраас өнгөрсөн арванхоёрдугаар сараас бүх харьяа хороо, дүүргийн салбар болгоноос судалгаа авч, хөрөнгө оруулалтад тусган хэрэгжүүлэх хийх ажил хэрэгжилтийг нь авсан. Үүний дараа асуудлыг эрэмбэлж, ямар ажлыг нь хотын төсөвтэй ярих, ямар ажилд олон улсын санхүүжилт татах, улсын төсвийг аль хэсэгт хуваарилах талд анхаарсан. Нэг тоглоомын талбайг байгуулах мөнгө улсын төсөвт орсон явж байдаг, хот, дүүрэг, цаашлаад УИХ-ын гишүүн санаачлаад явж байдаг ийм хоорондын уялдаа холбоогүй, замбараагүй байдал байсан. Тэгвэл өнөөдөр энэхүү эмх цэгцгүй байдлыг халж, хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлогын чиг баримжаатай болъё. 2018 он хүртэл хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний бодлогын баримт бичгийг боловсруулаад Эдийн засгийн хөгжлийн яаманд хүргүүлсэн. Энэ нь нийгэм хөрөнгө оруулалтын дунд хугацааны хөтөлбөртэй болж байгаа гэсэн үг. Дээр нь хөрөнгө оруулалтын ажлыг удирдан чиглүүлэх үүрэгтэй Улаанбаатар хотын хөрөнгө оруулалтын удирдах хороо гэж байгуулсан. Үүнийг бол дэвшил гэж харж байгаа. Манай мэргэжлийн болон хяналтын байгууллагууд үүнийг зөв зүйтэй алхам гэж үзсэн.

**-Иргэдийн нүдэн дээр Улаанбаатар хот өөрчлөгдөж буйд хүмүүс сайшаалтай хандаж байгаа. Гэхдээ хот дэндүү замбараагүй байна. Хаана нь л хоосон газар байна, тэнд барилга, байшин босгоод авдаг ийм төлөвлөлтийг та юу гэж үзэж байна. Ерөнхий төлөвлөгөөнд энэ байдал хэрхэн сууж байгаа вэ?**

-Миний хувьд Улаанбаатар хотын сүүлийн хоёр ерөнхий төлөвлөгөөг боловсруулах ажилд гар бие оролцсон. Төлөвлөлтийг гаднын мэргэжилтнүүд ч тодорхой хэмжээнд үнэлсэн гэдгийг дээр дурдсан. Хэрэгжүүлэхэд л асуудал байгаа юм. Өнгөрсөн хугацаанд үндсэндээ газар олголтоор тоглосон шүү дээ. Хотын иргэд мэдэж байгаа. Өнөөдрийн шинэ баг хотын удирдлагад гарч ирээд хамгийн түрүүнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ бол газар олголтын замбараагүй байдлыг халж чадсан. НИТХ-аар энэ асуудлыг оруулж хэлэлцүүлээд тодорхой тогтоол гаргаад хотын төвийн хуучин барилгажсан 1300 га газарт шинээр ямар нэгэн газар олголт хийхгүй. Зайлшгүй улсын зориулалттай барилга байгууламж барих юм бол төслөө НИТХ-д танилцуулна. Угаасаа газрын тухай хуульд төсөл сонгон шалгаруулалт, дуудлага худалдаагаар газар олгоно гээд заачихсан байхад л газрыг зүгээр олгож ирсэн. Тэгвэл өнөөдөр газрын ийм замбараагүй байдал арилсан гэж ойлгож болно. Энэ газрыг надад олгоод өгөөч хэмээн бид нарт ямар нэгэн байдлаар хандах асуудал байхгүй болсон. Үүнээс өмнө нь авсан, эсвэл энэ шаардлагын дагуу хуучин 1,2,3 давхрыг шинэчлэн барилгажуулж байгаа бол техникийн зөвлөлийн хурлаар оруулж, хэлэлцүүлээд зохих зөвшөөрлийг нь өгөөд явж байна.

Нөгөө талаараа барилгын норм,

дүрэм зөрчсөн, иргэдийн оршин суух эрх ашигт харшилсан ажил байвал иргэдээсээ асуу, иргэдийнхээ зөвшөөрлийг ав гэх бодлого барьж байгаа. Зарим нэг маргаантай асуудал дээр хотын удирдлагууд өөрсдөө очиж, иргэдтэйгээ ярилцаж шийдвэрлэж байна. Ер нь хотын хөгжлийн үйл явц 50-60 жилд өөрчлөгдөж, шинэчлэгддэг. Миний хувьд энэ салбарт 20 шахам жил ажиллаж байна.

Анх 40, 50 мянгатыг, гэр хорооллыг дахин төлөвлөж, хотын дүр төрхтэй нийслэлийг 70-80 жилд бий болгосон. Тэгвэл одоо гэр хорооллоо дахин төлөвлөж, хуучин 2-3 давхар 60-70 жилийн настай барилга байгууламжаа шинэчлэн барилгажуулах,сайжруулах ажил давхар явагдахаар байна. Үндсэндээ 20 жил урсгалаараа явчихсан алдаа гажуудлыг бид нэг жилд засаж барахгүй шүү дээ. Тиймээс тодорхой зарчмаар явах үндэс суурийг зөв тавих нь чухал юм. Тавиад ч явж байна.

Дахин төлөвлөлтийн ажлыг янз бүрийн байдлаар хийж байна. Тухайлбал, нийслэлийн 12 байршил дээр гэр хорооллын дахин төлөвлөлт хийх тухай ярьж байсан бол одоо энэ 12 байршил дээр бодит ажлууд хийгдээд эхэлсэн. Хувийн хэвшлийнхэнтэйгээ хамтран ажиллаж байна. Хөгжлийн банкнаас 85.7 тэрбум төгрөгийн дахин төлөвлөлтийн инженерийн шугам сүлжээний хөрөнгийг шийдэж өглөө. Хот өөрийн төсөв дээр гэр хорооллын инженерийн шугам сүлжээнд холбогдох ажлын хүрээнд 40 тэрбум төгрөг гаргасан. Нийтдээ 120 гаруй тэрбум төгрөгийн буюу 100 сая ам.долларын хөрөнгийг гэр хорооллын дэд бүтцэд хийж чадлаа. Энэ бол үнэхээр гэр хорооллын иргэдийн санал бодолд нийцсэн ажил болсон. Энэ хүмүүс өнөөдөр ирэх жил орон сууцандаа орно гэсэн хүсэл эрмэлзэлтэй хүлээж байна. Хувийн хэвшлийнхэн эхлээд нэлээд ажиглалтын байдалтай байсан бол одоо гэр хорооллын дахин төлөвлөлтөд оролцох тэдний идэвх өсч, ашигтай бизнес юм байна гэдгийг ойлголоо.

Өнөөдөр хоёр дахь ээлжийн ажил эхлэх гэж байна. Найман байршилд дахин төлөвлөлтийн ажлыг эхлүүлэхээр есдүгээр сард НИТХ-ын тогтоолоор шийдвэрлэж, олон нийтэд зарласан. Хувийн хэвшлийнхэн чөлөөтэй өрсөлдөх боломжтой. Түүнчлэн хот, улсын зүгээс үзүүлдэг тодорхой дэмжлэгүүдээ үзүүлнэ. Жишээлбэл, инженерийн шугам сүлжээг хотын болон улсын төсвөөр хийнэ. Сургууль, эмнэлэг, цэцэрлэг, орон сууц, үйлчилгээний барилга юм уу, бизнес төвүүдийг хувийн хэвшлийнхэн хөрөнгөө босгоод хийгээд явна. Ийм бодитой ажлуудыг амжилттай эхлүүллээ.

**-Нэг талаас засаг захиргаанаас**

Улаанбаатар хот маань хурдан хөгжих гарааныхаа замд орчихлоо гэж бодож байна. Өөрөөр хэлбэл, УИХ-аар бодлого төлөвлөлтөө батлуулж, тодорхой хөрөнгийн баримжаатай болсон. Олон улсын байгууллагууд тусалж дэмжье гэж байна. Бид суурь дэд бүтцээ барьж байгуулахад эхний ээлжинд урт хугацаатай бага хүүтэй зээлийг авахаас өөр арга байхгүй. Энэ бол хөрөнгө оруулалтын хамгийн гол бодлого байх ёстой.

**хотоо хөгжүүлэх бодлого, ерөнхий төлөвлөгөө гаргаад хэрэгжүүлэхээр явж байна. Тэгвэл нийслэлийн иргэдийн сэтгэлгээ бас өөрчлөгдөх цаг болсон гэж хүмүүс үзэх боллоо. Та ямар бодолтой байна вэ?**

-1.2 сая гаруй хүн дотор хотод насаараа ажиллаж амьдарсан, хөдөөнөөс дөнгөж орж ирсэн иргэн ч байгаа. Тэгэхээр хээр тал дунд давхиж явсан, төвөөс алслагдсан сумын төвд амьдарч байсан сэтгэхүйгээр Улаанбаатарт орж ирээд ажиллаж амьдарч болохгүй л дээ. Хот оршин суугч иргэндээ үйлчлэх ёстой. Үйлчилгээг хамгийн түргүнд хүргэх эрхэм үүрэг нь хотын захиргаанд бий. Энэ үүргээ шуурхай, чанартай болгохын, иргэддээ улам ойртохын төлөө энэ бүх ажлыг шинээр эхлүүлж байна. Тэгэхээр иргэн өөрөө яах ёстой вэ гэдгийг бодох л хэрэгтэй. Мэдээж хүн амьдрах орчноо өөрөө сонгоно гээд Үндсэн хуульд заачихсан тул нийслэлийг сонгоод ирж буй хүнийг ямар нэгэн захиргааны аргаар хязгаарлаж чадахгүй нь ойлгомжтой. Хотоос үйлчилгээ авч л байгаа бол тухайн иргэн үүрэг хүлээсэн байх ёстой гэсэн зарчим баримталж байгаа. Аливаа асуудлыг иргэддээ урьдчилаад хэлэхэд иргэд ойлгодог юм байна. Бид иргэдээсээ өнгөрсөн хугацаанд тасарчихсан байж. Тийм учраас хувийн хэвшлийнхнийг эхлээд иргэдтэй очиж ярилц гэхээр тэдний дуу нь намсаад явчихаж байна. Ерөөсөө төрөөс л юмаа авч хийгээд сурч. Эхний компаниуд иргэдтэйгээ очиж ярилцаад амжилтад хүрээд ирэхээр араас нь бусад нь хуйларч байх жишээтэй. Хотын захиргааныхан ч тодорхой асуудлыг иргэдтэйгээ очоод ярьдаг болъё гэдэг үүднээс Иргэний танхим байгуулсан. Тухайлбал, Баянхошуу, Сэлбэ төвийг хөгжүүлэхээр дөрвөн удаа иргэдтэй уулзалт хийж, ярилцлаа. Дахин төлөвлөлтийн ажлыг танай хороонд хийнэ гэж эхлээд асууж ярилцана. Дараа нь ийм компани шалгарсан, тэр компанитай та нар өөрсдөө ажиллах ёстой гээд компанийг нь танилцуулна. Цаашид ийм байдлаар явбал хүмүүс хотын иргэн болж төлөвшинө. Өөрийнхөө амьдрах орчны төлөө санаа тавьдаг болж байна. Миний гудамж, миний хот гэсэн сэтгэл нь өөрчлөгдөж байна.

**-Та өмнө нь мэргэжлийн хүний хувьд хотыг гаднаас нь хараад ийм тийм ажил хийхсэн, хөрөнгө мөнгийг ийм тийм зүйлд зарцуулахсан гэж боддог байсан байх. Тэгвэл дотор нь орж ирээд ажиллахад хөрөнгө оруулалт, хот төлөвлөлтийг базаад ирэхээр ямар бэрхшээл тулгарч байна вэ. Гадна талаас бодож байсан зүйл чинь хэр нийцэж байна вэ?**

-Миний хувьд хотод шинэ хүн биш л дээ. Би 1996-2006 он хүртэл Хотын захиргаанд мөн Хот

төлөвлөлтийн хүрээлэн, хотын бодлогын тогтвортой хөгжлийг нь бариад бас мэргэжлийн хяналтыг нь хариуцаад бүхий л үйл явцад нь оролцоод нэгэн аравныг өнгөрөөсөн. Тэгээд дараа нь бодлогын яаманд 6-7 жил ажиллаад эргээд ирж байгаа нь энэ л дээ. Энэ хугацаанд энэ ажлыг ингээд хийгээсэй, ийм шийдвэр гаргах юмсан гэх олон бодол байсан. Харин өнөөдөр өөрөө шийдвэр гаргах түвшинд ороод ирсэн учраас нэг талаас санаж бодсоныхоо дагуу шийдвэр гаргаж, ажиллаж байна. Гэхдээ дунд, доод шатанд нэг жилийн дотор шинэ горимд цэгцлэхэд хугацаа шаардлагатай юм байна. Хуучны арга барилыг санагалзсан, хуучин арга барилаараа явах гэсэн хөшүүн байдал ажилд сөргөөр нөлөөлөх хэмжээнд байгааг мэдэрч байна. Тийм учраас бүтцийн өөрчлөлт хийж, институци хоорондын уялдаа холбоог сайжруулах ажлыг дахиж харж үзье гэдэг дээр хотын удирдлагууд санал нэгдсэн. Манай хотын хоёр даргын хувьд биднийгээ манлайлж, чиглүүлж, урам зориг өгч ажиллаж байгаа. Ийм туршлагатай, шат шатанд ажилласан, УИХ-д тодорхой хэмжээгээр сууж туршлагажсан хүмүүс тул нэг баг болж ажиллахад урамтай, нөмөр нөөлөгтэй байдаг.

**-Нэг сая хүн амтай Улаанбаатар хотын эдийн засаг ямар байх ёстой вэ?**

-Энэ том эдийн засгийг бид яаж багцалж авах ёстой юм гэдэг талаар эргэн харах шаардлагатай. Арваад жилийн өмнө Улаанбаатар хотын хөрөнгө оруулалт 40 гаруй тэрбум төгрөг байсан бол өнөөдөр их наядаар хэмжигддэг боллоо. Тэгвэл яаж төлөвлөж, төсөөлөх ёстой юм. Эдийн засгийн салбаруудын бүтэц нь ямар байх юм гэдгийг цоо шинээр харах ёстой. Улсын хэмжээнд ДНБ-ий 67.9 хувийг хот дангаараа бүрдүүлж байгаа мөртлөө эргээд хөрөнгө оруулалтад 10 хувийг нь ч авч чадахгүй байна гэдэг дэлхийн нүдийг бүлтийлгэсэн гаж тогтолцоо болчихоод байна шүү дээ. Үүнийг бид өөрчлөх ёстой. Улаанбаатар хот маань хурдан хөгжих гарааныхаа замд орчихлоо гэж бодож байна. Өөрөөр хэлбэл, УИХ-аар бодлого төлөвлөлтөө батлуулж, тодорхой хөрөнгийн баримжаатай болсон. Олон улсын байгууллагууд тусалж дэмжье гэж байна. Бид суурь дэд бүтцээ барьж байгуулахад эхний ээлжинд урт хугацаатай бага хүүтэй зээлийг авахаас өөр арга байхгүй. Энэ бол хөрөнгө оруулалтын хамгийн гол бодлого байх ёстой. Хоёрдугаарт, хувийн хэвшилтэйгээ түншлэх. Хөрөнгө оруулалт гээд жаахан мөнгө тавьчихаад түүнийгээ булаацалдаж суудаг цаг өнгөрсөн байна гэдгийг ойлгох хэрэгтэй.

**-Их наядаар хэмжигдсэн, том бүтээн байгуулалт яригдаж байна. Хотын төсвийн зарцуулалт хэр ил тод байна вэ?**

-Бүх ажил ил тод байгаа. Төсвөө батлаад бид нийтэд шууд зарладаг. Гарсан аливаа шийдвэрүүдээ гурав хоногт багтаан хотын цахим хуудсандаа танилцуулж байна. Хэрвээ зарлаагүй бол тэр шийдвэрийг хүчингүй гэж үзнэ. Ийм зарчимтай ажиллаж байна. Улаанбаатар нээлттэй хот болсон.■

ИРЭЭДҮЙ

# 2030 ОНЫ УЛААНБААТАР

**Ч.ЛУТАА**


Улаанбаатар хотын ирээдүйн талаарх иргэдийн үзэл бодлыг сонирхохын сацуу Нийслэлийн Зураг төслийн хүрээлэнгээс гаргасан “Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол”, “2030 оны хөгжлийн чиг хандлага” зэргээс тоймлон хүргэж байна.

## Г.Золбоосайхан /Хан-Уул дүүргийн иргэн/:

*-Ногоон байгууламж Улаанбаатар хотын хувьд харьцангуй ховор. Тиймээс нийслэлийн төв хэсэгт боломжоор нь хэд хэдэн газар цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламж байгуулах хэрэгтэй. Энэ нь нэг талаар иргэдийн сэтгэл санааг өргөнө. Нөгөө талаар нийслэлийн өнгө төрхийг сэргээнэ. Онгон байгаль хүнд зөв энерги өгдөгийн адил хотын хүн амын төвлөрөлтэй холбоотой бухимдал байгаль орчны доройтлыг багасгах гол арга бол ногоон байгууламж юм.*

Дэлхий нийт ногоон хөгжлийн зүг хүлгийн жолоо залсан энэ үед Улаабаатар хотын ирээдүйг энэ зүгт чиглүүлэх нь зүйн хэрэг. Тэгвэл Улаанбаатар хотын “2030 оны хөгжлийн чиг хандлага” төлөвлөгөөнд энэ тухай хэрхэн тусгасныг сонирхоё. Тус төлөвлөгөөнд “... Хотын орон зайн тэлэлтийг хязгаарлан барих, хүн амын амралт зугаалга, чөлөөт цагаа өнгөрүүлэх задгай талбай, улмаар эрүүл, аюулгүй, тав тухтай

Зураг-1. Төлөвлөлтийн нэгж хорооллууд




*Эх сурвалж: Нийслэлийн зураг төслийн хүрээлэн*

амьдрах орчныг бүрдүүлэх, хот орчмын байгаль орчныг хамгаалах, болон хотын хүн амыг эрүүл хүнсээр хангахад зориулагдсан хөдөө аж ахуйн зориулалттай газар ашиглалтыг хадгалан үлдээх зорилгоор нийслэлийн нутаг дэвсгэрт ногоон бүсийн аргыг хэрэгжүүлнэ" гэж заажээ. Энэ зорилгод хүрэхийн тулд

-Усны менежментийг боловсронгуй болгох

-Гэр хорооллыг ногоон хөгжлийн механизмаар хөгжүүлэн агаар, ус, хөрсний бохирдлыг бууруулах


-Ногоон химид суурилсан хаягдалгүй, цэвэршүүлэх, өндөр технологийг нэвтрүүлж, хог, хаягдлын менежментийн шинэ тогтолцоог бий болгох зэрэг ажлыг нэн түрүүнд тусгасан байна.

## Ч.Энхтөр /Чингэлтэй дүүргийн иргэн/:

*-Би гэр хорооллолд амьдардаг. Хотын хөгжлийг гэр хороолол руу чиглүүлэх хэрэгтэй гэж бодож байна. Нийслэлийн иргэдийн 70 орчим хувь нь гэр хорооллолд амьдарч байна шүү дээ. Гэтэл өнөөдөр хотын иргэн гэхээр орон сууцанд амьдардаг, ганган машин унасан, гал түлдэггүй хүмүүсийг хэлнэ гэж боддог болчихсон байна. Тиймээс ирээдүйн хот төлөвлөлтийг хийхдээ энэ ялгааг багасгах хэрэгтэй байх.*

НЗДТГ-ын "Гэр хорооллыг орон сууцжуулах" төслийн дарга А.Лхагвадоржийн хэлсэнчлэн "Гэр байшин хоёрыг зодолдуулсан" өнөөдрийн буруу чиг хандлагыг өөрчлөх зайлшгүй шаардлага бий. Улаанбаатар хотын "2030 оны хөгжлийн чиг хандлага" төлөвлөгөөнд тусгаснаар бол гэр хорооллыг байршлын хувьд төвийн, дунд, захын гэж ангилан хөгжүүлэх юм байна. Гэр хорооллыг дахин төлөвлөж, өндөр болон дунд давхрын барилгаар барилгажуулах, дунд хэсгийн гэр хорооллыг нам давхрын барилгаар дахин төлөвлөж,төвлөрсөн инженерийн шугам сүлжээнд үе шаттайгаар холбох ажээ. Төвийн гэр хорооллыг дахин төлөвлөж, орон сууцны хороолол болгон хөгжүүлэх хөтөлбөрийн эхний үе шатанд "Шинэ бүтээн байгуулалт" дунд хугацааны зорилтот хөтөлбөрийг хэрэгжүүлэх юм. Харин дунд хэсгийн гэр хорооллын эргэн тойронд үндсэн дэд бүтцийг бий болгож, ариутгах татуурга, усан хангамж, цахилгаан дулаан хангамж, зам, далан суваг, хатуу хог хаягдлын төв байгуулах цогц төслийг хэрэгжүүлэхээр заасан байна. Түүнчлэн захын гэр хорооллын тэлэлтийг зогсоож, ашуултай, тохиромжгүй газруудад байрласан айлуудыг нүүлгэн шилжүүлэхээр төлөвлөжээ. Цаашдаа хотын захын хороо, алслагдсан дүүрэг, дагуул хотыг жигд тэнцвэртэй хөгжүүлэх замаар суурьшлын шинэ бүсийг байгуулж, Улаанбаатар дахь өнөөгийн хүн амын хэт төвлөрлийг сааруулан, гэр хорооллын эзлэх хувь хэмжээг бууруулахаар төлөвлөж байгаа юм байна. /Дэлгэрэнгүйг хүснэгтээс харна уу/

# Зураг-2. Улаанбаатар хотын дагуул хот, тосгодын 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага




*Эх сурвалж: НЗТХ*

Хүснэгт-1. Хот байгуулалтын үйл ажиллагаа

| Бүсийн нэр | Зориулалт | Талбай /га/ | Эзлэх хувь |
|---|---|---|---|
| Барилгажсан хэсэг | Орон сууц, олон нийт барилга бүхий цаашид хэвээр хадгалах талбай | 1604.63 | 4.55 |
| Шинээр барилгажих хэсэг | Шинээр барилгажуулах хоосон талбай | 2169.97 | 6.16 |
| Дахин төлөвлөх хэсэг | Гол төлөв гэр хороолол бүхий барилгажуулах талбай | 4263.61 | 12.11 |
| Сайжруулсан гэр сууцны хороолол | Амьдрах нөхцөл сайжирч хэвээр үлдэх гэр хороолол | 5488.55 | 155.58 |
| Үйлдвэрлэлийн бүсийн барилгажсан хэсэг | Зориулалтыг хэвээр хадгалах хэсэг | 1039.67 | 2.95 |
| Бусад | - | 19.340.15 | 54.96 |
| Нийт | - | 35.206 | 100 |

*Эх сурвалж: НЗТХ*

## Г.Ганчимэг /Баянгол дүүргийн иргэн/:

*-Хотын хөгжлийг ирээдүйд илүү эрүүл зөв харилцаанд суурилсан, эдийн засгийн үр ашигтай ухаалаг хот болоосой гэж мөрөөддөг. Нэг газар бөөгнөрөх биш өргөн уудам газартаа тархаад эрх дураараа сайхан амьдрах боломжийг бүрдүүлж өгөхийг дарга нараас хүсч байна. Би хотоос зайдуу амьдрахыг хүсдэг. Гэтэл хотын төвд ажилтай болохоор ирж очих гэж цаг алдана. Тиймээс хотын захад очдог метротой болчихвол цэвэр агаарт, чимээ аниргүй сайхан орчинд амьдрахыг надтай адилхан хүсдэг залуус олон бий. Энэ их утаан дунд эрүүл, зөв амьдрах талаар бодоход ч хэцүү байна. Хэрвээ метротой болчихвол хүн амын төвлөрөл саарч утаа багасах болов уу.*

Иргэдийн сэтгэгдлийг сонсоход Г.Ганчимэгтэй ижилхэн бодолтой хүн цөөнгүй байсан юм. Тэгвэл нийслэлийн хэтийн төлөвлөгөөнд замын хөдөлгөөний менежменттэй уялдуулан оновчтой, нэгдсэн цогц хотын гудамж замын сүлжээг бий болгох хэд хэдэн ажлыг үе шаттайгаар төлөвлөсөн байна. Үүнд:

-2016 он гэхэд 216 км хатуу хучилттай зам, хотын төвийн долоон хэсэгт олон түвшний уулзваруудыг шинэчлэн барих

-2030 онд 3000 орчим км хатуу хучилттай замтай болно

-Ачаа тээврийн төмөр замыг Богд уулын урдуур хот тойруулан байгуулах, үүнтэй уялдуулан хот доторх төмөр замыг нийтийн тээвэрт ашиглах

-Тусгай замын автобусны (BRT) зам, метро (LRT)-г барьж байгуулах

-Багтаамж ихтэй нийтийн тээврийг хөгжүүлэх юм. Энэ тухайд эдийн засгийн үр ашиг хэрэгжүүлэх бодит боломж, түүнээс үүсэх сөрөг үр дагавар зэргийг олон талаас нь үндэсний мэргэжилтнүүдийг оролцуулан нарийвчлан судалж тооцно. Тэгж гэмээнэ эцсийн шийдвэрээ гаргах юм. /Дэлгэрэнгүйг Зураг-1-ээс харна уу/

## А.Түмэнномин /Сүхбаатар дүүргийн иргэн/:

*-Гаднын орнуудын жишгээс харахад хотыг бүсчлэн хөгжүүлдэг. Тухайлбал, оюутны, ажилчдын, үйлдвэрлэлийн тэр бүүхэл Хятад, Япон, Мексик хороолол гэх мэт хөгжсөн нь бий. Тиймээс яг энэ жишгээр ирээдүйн Улаанбаатарыг бүсчлэн хөгжүүлж болно шүү дээ. Ингэж хөгжүүлэх нь нэг талаар эмх цэгцтэй, дүүрэг бүр нь өөрийн онцлогтой хөгжих боломжийг бүрдүүлнэ гэж бодож байна. Мөн хотын захын дүүргүүдийг хөгжүүлж иргэдийг тэр зүг татмаар байна. Гаднын хөгжингүй орныг харахад баячууд нь хотын захдаа амьдардаг шүү дээ. Энэ жишгийг Улаанбаатар хотод нэвтрүүлж нийслэлийг тэлэх бодлогоо яаравчлаасай.*

Ирээдүйд Багануур, Багахангай, Налайх дүүргийг нийслэлийн дагуул хот болгон эрчимтэй хөгжүүлэхээр төлөвлөжээ. Үүний тулд энэ хотуудад боловсруулах үйлдвэрлэлийг бий болгохоор “2030 оны хөгжлийн чиг хандлага” төлөвлөгөөнд тусгасан байна. 2030 онд алслагдсан дүүргүүдийн хүн амыг өнөөгийн түвшнээс 4,15 дахин нэмэгдүүлэх ерөнхий төлөвлөгөөтэй. Уг төлөвлөгөөнд хүрэхийн тулд дагуул хотуудыг татваргүй бүсийн чиг үүрэгтэй болгох юм. Ойрын 20 жилийн хугацаанд нэг шинэ дагуул хотыг байгуулж 60 мянган хүн суурьшуулна. Тус хотыг нисэхийн “Аэро сити” чиг үүрэгтэй хөгжүүлэх юм байна. /Дэлгэрэнгүйг Зураг-2-оос харна уу/. ■

Хүснэгт-2. Хот байгуулалтын үйл ажиллагаа

| Төлөвлөлтийн бүс | Газар нутгийн хэмжээ /га/ | 2010 он Нийслэлийн | | 2020 он Нийслэлийн | | 2030 он Нийслэлийн | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Хүн ам | Өрх | Хүн ам /мянга | Өрх /мянга/ | Хүн ам /мянга | Өрх /мянга/ |
| Төвийн бүс | 2025.0 | 59805 | 228809 | 71.1 | 263.0 | 74.9 | 269.6 |
| Зүүн бүс | 3642.0 | 42181 | 159683 | 51.5 | 190.5 | 59.8 | 215.1 |
| Хойд бүс | 4233.0 | 41327 | 155323 | 53.9 | 199.5 | 59.4 | 213.7 |
| Баруун хойд бүс | 2819.0 | 31557 | 127284 | 33.0 | 122.0 | 33.3 | 120.0 |
| Баруун -1 бүс | 2035.0 | 58770 | 239899 | 65.2 | 241.2 | 66.2 | 238.4 |
| Баруун-2 бүс | 3414.0 | 15428 | 60706 | 24.1 | 89.3 | 28.9 | 104.0 |
| Баруун өмнөд бүс | 3288.8 | 12421 | 49041 | 20.4 | 75.6 | 47.4 | 170.6 |
| Шинэ бүс | 4791.0 | 3968 | 19619 | 14.7 | 54.4 | 19.1 | 68.6 |

*Эх сурвалж: НЗТХ*

ДҮҮРГЭЭР СОНИН ЮУТАЙ ВЭ

# ОНЦЛОХ БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ

***Улаанбаатар хотод энэ онд бүтээн байгуулалт, тохижилтыг эрчимтэй хийсэн. Тэгвэл нийслэлийн төвийн зургаан дүүрэгт бүтээн байгуулалтаас онцлох зүйл юу байна вэ гэдгийг сонирхлоо.***



## Баянгол дүүрэг:

Баянгол дүүргийн хувьд 2014 онд 50 жилийн ой нь болох аж. Тус ойг угтаж нэлээд ажил хийхээр төлөвлөжээ. Энэ онд тус дүүрэгт нийт 95.6 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийжээ. Энэ нь Баянголын сүүлийн 3-4 жилийн хөрөнгө оруулалттай тэнцэх хэмжээний юм. “Дээрх хөрөнгө оруулалтын ихэнх нь дэд бүтэц, авто зам руу орсон. Манай дүүргийн хувьд энэ жил ихээхэн бүтээн байгуулалтын суурийг тавьсан. 2014 онд бид дүүргээ илүү тохилог, хүн амьдрахад таатай хөрс, агаарын бохирдолгүй эрүүл болгохын төлөө ажиллана” гэж тус дүүргийн Засаг дарга Д.Оросоо хэллээ .



## Сонгинохайрхан дүүрэг:

Орон сууцанд амьдардаг хүн ам цөөн боловч 2020 он хүртэлх ерөнхий төлөвлөгөөнд Нийслэлийн Засаг даргын Тамгын газрыг тус дүүргийн VI хорооны нутаг дэвсгэрт буюу Ханын материалын орчимд нүүлгэн шилжүүлэхээр байгаа нь Сонгинохайрхан дүүргийн онцлох мэдээ юм. Хотын бусад дүүрэгтэй харьцуулахад шилжин иргэдсэд түлхүү суурьшдаг, ажилгүйдэл, ядуурал ихтэй тус дүүргийн хувьд хотын төв болно гэдэг үнэхээр сайхан мэдээ.

Мөн ажлын байр нэмэгдүүлэх, Жижиг, дунд үйлдвэрийн парк байгуулах чиглэлээр тодорхой ажил эхлүүлээд байгаа аж.



## Сүхбаатар дүүрэг:

Бусадтай харьцуулахад төвийн дүүрэг гэдэг утгаараа Сүхбаатарын тохижилт харьцангуй сайн байсан. Тус дүүргийн Засаг даргын орлогч Л.Амарзаяа “ Энэ жилийн бүтээн байгуулалт дээр Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтыг онцолж хэлмээр байна” хэмээсэн. Улаанбаатар хот Төсвийн тухай хуулийн дагуу энэ оны нэгдүгээр сарын 1-нээс иргэдийн зүгээс гарсан санал

санаачилга дээр үндэслэн бүтээн байгуулалтын ажлаа хийдэг шинэ зохион байгуулалт, шинэлэг аргад шилжсэн билээ. Энэ дагуу тус дүүрэг иргэдийнхээ санал санаачилгаар тухайн хороон дээр юу хийгдэх вэ гэдэг санал асуулга явуулж, есөн чиглэлийн 42 төсөл арга хэмжээний санаачилга гарсныг 20 хороондоо хуваагаад ажлаа зохион байгуулж байгаа аж. Үүнээс онцлон нэрлэх ажил гэвэл гэр хороолол руу хийгдэж байгаа хайрган замын хучилт гэнэ. Улсын чанартай авто замын стандартаас арай доогуур ч энхэл донхолтой шороон замаар бүдчиж явдаг гэр хорооллын иргэдийн хувьд орчин нөхцөл сайжирч байна л гэсэн үг. Сүхбаатар дүүргийн ихэнх хороо Сэлбэ голын дагуу байрладаг учраас намаг ихтэй. Тиймээс шороон зам ч хүн явахад бэрхтэй болдог байна.



## Баянзүрх дүүрэг:

Тус дүүрэгт энэ жил улсын болон нийслэлийн хөрнгө оруулалтаар 100 орчим тэрбум төгрөгийн бүтээн байгуулалтын ажил хийгдсэн байна. Зүүн тийш чиглэсэн төв замууд бараг бүгд толийсон сайхан болсон нь энэ дүүргийн ажил сайн явааг гэрчилнэ. “Энэ жил зам засварын ажлууд өмнөхийг бодоход үерийн ус зайлуулах шугам, гэрэлтүүлэг, явган хүний зам, тохижилттой хийгдсэнээрээ онцлогтой байлаа” гэж Баянзүрх дүүргийн Засаг даргын орлогч Т.Батцогт онцоллоо. Мөн дүүргийн нийт 28 хорооны иргэдээс санал авахад хамгийн тулгамдсан асуудал цэцэрлэг, сургууль гэж гарсан байна. Тиймээс улсын цэцэрлэг огт байхгүй дөрвөн хороонд 100-150 хүүхдийн багтаамжтай цэцэрлэг барихаар төлөвлөгдөөд зургийн ажил нь хийгдэж дуусаад, гурван цэцэрлэгийг нь барих компани шалгарчээ.



## Чингэлтэй дүүрэг:

Чингэлтэй дүүргийнхувьд ирэгдийнхээ эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх. Хүүхэд залуусын сурч боловсрох боломж бололцоог бий болгох. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих нь хот хөгжих томоохон хүчин зүйл юм гэсэн философийн дагуу ажиллаж буй аж . Энэ хүрээнд дүүргийн Засаг даргын тамгын газраас энэ онд Хүнлэг орчин нийгмийн хөгжил, Нээлттэй орчин эдийн засгийн хөгжил, Тохилог орчин дэд бүтцийн хөгжил, Байгаль орчин ногоон хөгжил, Хяналттай орон нутгийн удирдлагын хөгжил гэсэн зорилгын хүрээнд ажиллаж байна. Тиймээс орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлт, хүүхдийн тоглоомын талбай байгуулах гээд олон ажлыг хийж гүйцэтгэжээ.




## Хан-Уул дүүрэг:

Зайсан хорооллын тансаг орон сууцны барилгуудаараа бусдаас ялгардаг Хан-Уул дүүргийн Яармагийн дэнж барилгажиж, хурдны замтай болно гээд ирээдүйд ихээхэн бүтээн байгуулалт өрнөнө. Энэ жилийн хувьд цахим дүүрэг болох зорилгыг өмнөө тавьсан. Үүнтэй холбоотой зарим нэг мэдээллийг авахдаа интернэт ашиглах боломжийг бүрдүүлсэн нь иргэдэд учирдаг үйлчилгээний болон бусад асуудлыг шийдвэрлэж чадсан байна. Уг ажлын хүрээнд дүүргийн цахим хуудсыг шинэ мэдээ мэдээллээр баяжуулах, архивын бичиг баримтыг цахимжуулах, иргэдийн санал хүсэлтийг цахим хэлбэрээр авах гээд нэн тэргүүнд хийх 12 төрлийн ажлыг эхлүүлжээ. ■

ДЭЛХИЙН ЗАЛУУ УДИРДАГЧ

# НЯЛХ ХОТЫН ТӨРХ



**Х.ХУЛАН**

*Жэймс Ло нь анх 2001 онд байгуулагдсан "Жэймс Ло Сайбертекчюр Интернэшнл" компанийн үүсгэн байгуулагч. Тэрбээр Лондоны их сургуулийн Коллежийн уран барилгын ангийг 1992 онд төгсжээ. Дэлхийн эдийн засгийн форумаас 2010 онд Дэлхийн залуу удирдагчаар шалгарсан аж. Одоо сайбер технологийг орчин үеийн барилгатай хослуулах зорилгыг дэвшүүлэн ажиллаж байна.*
*Жэймс Ло нь алдартай архитектор. Английн уран барилгачдын "Ройал" институтын гишүүн.*
*Тэрбээр 2011 онд Монголд болсон Залуу манлайлагчдын хурлын үеэр ирсэн юм. Түүний ярилцлагыг хотын дугаарт зориулж дахин нийтэлж байна.*

**-Таныг Улаанбаатар хотын төлөвлөлт дээр хамтран ажиллах сонирхолтой гэж сонслоо. Та төлөвлөгөөгөө гаргасан уу?**

-Юуны өмнө хот нь аливаа улсын маш чухал хэсэг мөн гэдгийг хэлмээр байна. Ялангуяа өөрчлөлт шинэчлэлтийг дагуулах Монгол Улсын хувьд амин чухал үүрэгтэй. Бид хотын төлөвлөлтийг өнгөрсөнд бус, ирээдүйдээ зориулж гаргах хэрэгтэй. Тэгэхлээр Улаанбаатар хотын төлөвлөлтийг 10, 20, 50 жилээр бус, харин ирэх хэдэн зуун жилийг урьдчилан харж хийх шаардлагатай. Танай нийслэлд ирж үзсэний хувьд хэлэхэд, өнгөрсөн үеийн бүх бэрхшээл нь ил харагдаж байна. Дотоод бүтэц тааруухан, мөн хот асар хурдацтай өсөн томрох хандлагатай байна.

Ирэх жилүүдэд гарах өсөлтөд зориулж "ухаалаг" хотын сүлжээний суурийг тавих хэрэгтэй. Үүний дизайн болон тогтолцоог үйл ажиллагаа тус бүрт зориулсан бүсээр эхлүүлж болно. Ингэснээр бизнесийн, оршин суугчдын, соёлын, эрдэм шинжилгээ технологийн, мэдээллийн, эрчим хүчний гэсэн дүүргүүдтэй болно. Дүүрэг бүр органик хэлбэрээр өсөж, цаг хугацаа өнгөрөх тусам сайжирна. Үүнийг компьютерийн программыг шинэчлэхтэй адил гэж зүйрлэж болно. Ийм шинэ ухаалаг хотуудыг бид сайбертекчюр хот гэж нэрлэдэг. Эдгээрийг улс үндэстэн, нийгэм хөгжих тутам компьютерийн программ шиг сайжруулан шинэчилж болдог.

Мөн хотыг илүү тогтвортой хөгжлийн замаар хөгжүүлэх хэрэгтэй. Эрчим хүч болон бусад нөөцийг шинэ маягаар дахин боловсруулж, хэрэглэснээр үндсээр нь шинэчилнэ. Тэгэхлээр өнөөдөр хотыг ирээдүйн цахилгаан машинд зориулж төлөвлөнө. Хотод амьдарч ажиллах хэдэн мянган хүмүүст зориулсан, агаар бохирдуулахгүй, түгжрэл үүсгэхгүй тийм олон нийтийн тээврийн хэрэгсэл болох дамжин суух галт тэргийг бодолцох хэрэгтэй. Өнөр бүлээрээ таатай бөгөөд ногоон орчинд амьдрах байшин барилга, олон улсын дээд зэрэглэлийн стандартад нийцсэн бизнесийн дүүргийг бодолцоно. Энэ бүх ажлыг өнөөдөр төлөвлөж эхэлнэ. Учир нь, эдгээр санааг хэрэгжүүлэхэд 10, 20, 30 жилийн хугацаа орно. Хуучин биш, шинэ “сайбертекчюр” концепц бидэнд хэрэгтэй. Бид хотыг зөвхөн бетон, төмөр, шилнээс бус харин эдгээрийг маргаашийн технологи, шинэчлэлтэй хослуулан барих хэрэгтэй. Тэгж чадваас энэ нь Монголд урт удаан наслах үндэслэлтэй болно.

**-Та манай хотыг анх удаа хараад архитектор мэргэжилтэй хүний хувьд юу гэж бодсон бэ?**

-Анх нийслэл Улаанбаатар хотыг хараад нялх хүүхэд шиг байна даа гэсэн сэтгэгдэл төрсөн. Онгоцноос харахад уулсын дунд олон жижиг чулуунуудыг талаар нэг тараасан мэт харагдсан. Ямар ч зохион байгуулалт, хил хязгаар, бүлэглэл, удирдлагагүй замбараагүй. Харин хот руу ороод ирэхээр хөгжил нэлээд хурдацтай явагдаж буйг мэдэрсэн. Шинэ барилга байшин баригдаж байгаа ч нэгдсэн бодлогын хүрээнд орж чадаагүй байна. Мөн орон сууцны байранд зориулсан загвар алга. Хүмүүс гэрт, хувийн байшинд, зарим нь нийтийн орон сууцанд амьдарч байна. Аливааг бүтээхдээ, мөн чанарыг хэрхэн бий болгох вэ гэдэг дээр тодорхой систем алга. Замын түгжрэлийн бэрхшээл нь зам биш, харин зохицуулалтдаа байна. Гэрлэн дохиог би анзаарч харсан. Зарим үед гэрэл асахгүй, дохио солигдох хугацаа буруу, эсхүл хүмүүс гэрлэн дохиог үл тоомсорлон гарч байсан.

Хотын замын хөдөлгөөнийг зохицуулна гэдэг нь ганц биш, хэдэн мянган уулзварыг удирдана гэсэн үг. Компьютер ийнхүү хөдөлгөөнийг хамгийн үр ашигтайгаар зохицуулж чадна. Орчин үеийн хотын цагийн тогтолцоо нягт нямбай байх ёстой. Нийслэл хотыг балчир хүүхдээр авч үзэхэд, энэ хүүхдийг өсгөж томруулахын тулд шинэ тоглоом, хэрэгсэл өгөх зайлшгүй хэрэгтэй. Өөрөөр хэлбэл, ур чадвар олгож, том хүн болгож авна гэсэн үг. Энэ бүхнийг яг одоо л хэрэгжүүлж эхлэхгүй юм бол, Улаанбаатар хотын ачаалал, бэрхшээл нь улам нэмэгдэнэ. Бид урьдчилан харагчдын хувьд Засгийн газарт хот төлөвлөлт дээр зөвлөж байж урт настай, тогтвортой, орчин үеийн, ухаалаг хот бий болно.

**-Ухаалаг хот гэж Та ямар хотыг хэлэх вэ. Жишээ хэлж болох уу?**

-Ухаалаг хот гэдгийг тайлбарлахаас өмнө, хот гэж чухам юу болохыг ойлгох хэрэгтэй. Нийгэм, эдийн засгийн шалтгааны улмаас нэг газар аж төрж, ажилладаг хүмүүсийн бүлэг хотыг бүрдүүлдэг. Тэнд том компани аж ахуйн нэгжүүд, Засгийн газар, сургууль, онгоцны буудал, аж үйлдвэр бүгд төвлөрдөг тул хүмүүс ч мөн адил тэнд төвлөрдөг. Гэхдээ энэ хүмүүсийг нэг дор бөөгнөрүүлэхэд тэд сайн зохицуулагч байж чадахгүй. Хүн хэдийгээр сайн сэтгэн боддог ч амиа хичээсэн байдаг. Эртний хотууд ухаалаг байгаагүй.

Ухаалаг хот гэдэг нь хотыг төлөвлөж, үр ашгийг өндөр түвшинд байлгахад чиглэгдсэн хүрээ юм. Эрсдэлтэй тулгарахад давах чадамжтай байх ёстой. Жишээ нь хотод үр ашиггүй алдагдаж байгаа ус, эрчим хүчний хэмжээ асар их байна. Ухаалаг хотод нэг дүүрэг албан байгууллагын зориулалттай байх бөгөөд өдрийн цагт эрчим хүчийг түлхүү хэрэглэнэ. Өөр нэг дүүргээс тэр эрчим хүчийг хуваалцах боломжтой. Тэгээд бизнесийн хороололд амралтын өдрүүдэд эрчим хүчний зарцуулалт бага болохоор нь илүү их хэмнэлт гаргаж болно. Эрчим хүч, хүний нөөц, харилцаа холбоон дээр ч гэсэн ийм л аспектаар хандах шаардлагатай билээ. Бүсүүдийг бизнесийн болон оршин суугчдийнх гэж хуваана. Хүмүүс ажилдаа очих гэж хотын нэг захаас нөгөө рүү явж байна. Тэгвэл шинэ хотын оршин суугчид яагаад нэг л газраа ажиллаж амьдарч болохгүй гэж. Бид эрчим хүч, цагаа хэмнэн тэрхүү нөөцөө хүмүүсийн амьдралыг нь сайжруулахад зарцуулъя. Иргэдийн боловсрол, эрүүл мэнд, амьдралын стандартыг нь сайжруулж байж ухаалаг хот болно. Ийм хотыг бүтээн байгуулахын тулд шинэ дотоод бүтэц, шинэлэг санаа бидэнд шаардагдана.

**-Улаанбаатар маань хэзээ таны ярьж байгаа шиг ийм ухаалаг хот болох бол?**

-Нэг шөнийн дотор бүтээн байгуулагдах зүйл биш. Гэхдээ Монгол Улсын хувьд том давуу талтай. Лондон, Хонконг гэхчлэн томоохон хотуудын дотоод бүтэц аль хэдийнэ хийгдсэн учир шинэчлэхэд хэцүү. Өсөлтийнхөө дунд шатанд байгаа Шанхай, Бээжин хотууд ч мөн адил.

Харин Улаанбаатар залуу хот учраас хүмүүс ирээгүй, утасгүй холболт, шугам сүлжээ тавигдаж дуусаагүй байна. Иймд одооноос ухаалгаар ажлыг эхлүүлбэл хотын өсөлт хөгжил ч үүнтэй хамт эхэлнэ. Эхний үе шатанд таван жилийн хугацаа шаардлагатай байх гэж бодож байна. Гэхдээ маш ухаалгаар бодож хийх нь чухал. Тэрнээс биш, шил толь болсон гял цал өндөр барилгуудыг чухалчлах нь гол биш. Хойч үеэ бодож, урт хугацааны төлөвлөлтөд чиглүүлэх хэрэгтэй.


**-Та залуучуудад хандаж юу хэлэх вэ?**

-Монгол хүүхэд, оюутан залуустай уулзсан. Тэд өөдрөг үзлээр дүүрэн байгаа нь мэдэгдсэн. Мөн хүмүүс өнөөдрөөр биш, маргаашаа бодож амьдарч байгаа нь улс орны хувьд маш сайн юм. Монгол 15 жилийн дараа дэлхийд тэргүүлсэн манлайлагч орон болохыг үгүйсгэхгүй. Залуу удирдагчид бид өөрчлөлт шинэчлэлт, өөдрөг байдал, мөрөөдлийн эрч хүчийг олж хардаг. Монголд ирээд сая хүний амьдралыг өөрчлөх боломж байгааг мэдэрсэн. Тэр бол жинхэнэ боломж. Бид цаг алдалгүй боломжийг тэвэрч аван, ирээдүйд тохирсон бодит санаа, арга барил, алсын хараатай байх хэрэгтэй байна. ■


# АМНЫ ХААЛТАА ЗҮҮГЭЭРЭЙ, УТАА ЭХЭЛЛЭЭ



SO2 -хүхрийн давхар исэл, мг/шоо метр




CO угаарийн хийн агууламж, мг/шоо метр






Фотог Б.Бямба-Очир

*Чингисийн талбай. 2013 оны арваннэгдүгээр сарын 14-ний 14.30 цаг.*


## Азотын давхар ислийн сарын дундаж агууламж

*(2010-2012 оны 10-12 дугаар сар,*
*2011-2013 оны 1-3 дугаар сар)*





## Том ширхэгт тоосонцорын сарын дундаж агууламж

*(2010-2012 оны 10-12 дугаар сар,*
*2011-2013 оны 1-3 дугаар сар)*




## $NO_2$ Азотын давхар ислийн агууламж, мг/шоо метр




*Эх сурвалж: Нийслэлийн агаарын чанарын алба*

ТҮҮХ

# ИХ ХОТЫН ТОВЧООН



2013 оны аравдугаар сарын 29. Эл өдөр Улаанбаатар хот үүсэн байгуулагдсаны 374 жилийн ойн баярын өдөр тохиов. Эсгий хотоос түүхээ бичиж эхэлсэн Монгол Улсын нийслэл Улаанбаатар хот монголчуудын эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө тэмцэл, тусгаар тогтносон орны улс төр, эдийн засаг, шашин, соёлын хамгийн том төв, монголчуудын эрхэм бэлгэдэл юм. Улаанбаатарын үндэс суурь болох Хүрээ буюу Өргөөний тухай түүх 1649 оноос эхлэлтэй байдаг ч одоогийн нийслэл хотын шав Орхон, Тамир, Туул голуудын хөндий дагуу 29 удаа нүүдэллэсний эцэст Алтан тэвшийн хөндийд 1778 онд тавигдсан гэж үздэг. Үүнээс хойш Монгол Улсын нийслэлийн нэр түүхэндээ таван удаа солигдож байжээ.




## Өргөө /1639-1651 он/

1639 онд одоогийн Өвөрхангай аймгийн Бүрд сумын нутагт Цагаан нуур буюу Ширээт нуур гэдэг газар шашны тэргүүнээр Занабазарыг өргөмжлөхдөө түүнд зориулж Орд-Өргөөг байгуулж өгчээ. Энэ өргөө нь өнөөгийн Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын үүсэл болсон гэж үздэг.

Өргөө нь Монголын шарын шашны төв байснаас гадна тухайн үедээ Халх Монголын улс төрийн төв байсан гэдэг. Өргөө нэрээр анх ханаа дугуйлсан нийслэл хотын анхны нэр 1651 оны үед Номын хүрээ болж өөрчлөгдөн 1706 оныг хүртэл тийн нэрлэгдэж байжээ.

## Их хүрээ /1706-1911он/

Энэ үед одоогийн Сэлбийн голын хөндийд суурьшмал бас нэгэн шинэ хот болох Их Хүрээ үүсэн хөгжиж эхэлсэн нь өдгөөгийн Улаанбаатар хотын эхлэл болсон байна. Монгол урчууд Их Хүрээнд сүм дуганыг барьж байгуулахдаа үндэснийхээ барилга ялангуяа гэрийн уламжлалыг чадамгай ашиглан хөгжүүлсний зэрэгцээ Хятад, Төвд уран барилгын уламжлалаас хэрэглэж байжээ. XIX зууны үед Их хүрээ зөвхөн шашны төв төдийгүй Монгол орны улс төр, засаг захиргаа, соёлын чухал төв, худалдаа харилцааны том зангилаа болж жинхэнэ хот болон хувирсан байна. Тухайн үед Их хүрээний нийт хүн ам 15-20 мянга орчим байсан болов уу гэж үздэг.



1780-1870 оны хооронд 70 гаруй суурин сүм, дуган, ялангуяа өнөөгийн Гандантэгчилэн хийд 1809 онд баригджээ. 1861 онд Оросын консулын газар байгуулагджээ. Хүрээний хүн ам нэмэгдсээр 1910 онд 50 мянга болжээ. Монголын улс төр, шашны нэн чухал төв болсон Их Хүрээ 1912 онд нэрээ сольж Нийслэл Хүрээ хэмээн нэрлэгдэх болсон байна. Энэ нь Нийслэл Хүрээ Монгол улсын нийслэл болж, улс орны амьдралд онцгой үүрэг гүйцэтгэх болсон үе байлаа.



## Улаанбаатар хот /1924 оноос одоог хүртэл/

1924 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 14 дүгээр хуралдаанаар нийслэл хотыг улсын нийслэл хот гэдгийг давтан хуульчилж хотын нэрийг Улаанбаатар хот хэмээн өөрчлөхөөр болжээ. 1926 онд Ардын цэнгэлдэх хүрээлэн буюу Бөмбөгөр ногоон сүндэрлэсэн нь Улаанбаатар хотыг чимсэн хамгийн том барилга байгууламж байжээ.

1954 онд анх удаа Улаанбаатар хотыг хөгжүүлэх 20 жилийн хэтийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлж эхэлсэн гэдэг. Өдгөө Улаанбаатар хот нь Хэнтийн нурууны урд үзүүр болох Баянзүрх, Богд хан, Сонгинохайрхан, Чингэлтэй хайрхан уулсаар зүүн, урд, баруун, хойд талаараа тус тус хүрээлэгдсэн бөгөөд Туул, Сэлбэ голуудын бэлчир хөндийд байрладаг. Дунджаар далайн түвшнээс дээш 1351 метр өндөрт оршдог. Нийт 4,704.4 ам. метр газар нутагтай. Засаг захиргааны есөн дүүрэгт хуваагддаг. ■



Фотог Б.Бямба-Очир

*Нийслэлийн хүн амын 70 гаруй хувь нь гэр хороололд амьдардаг*

ӨӨР ӨНЦГӨӨС

# ДАНДАА МУУЛУУЛАХ ГЭЖ

**Э.ЗОРИГТ**

Навтгар байшин, навсгар гэр, банзан хашаа, усны тэрэгтэй хүүхдүүд уралдаж гүйсэн гэр хорооллын гудамж миний өссөн орчин. Мэдээ орохдоо л мэдэрч өссөн бүхэн наддаа л үнэ цэнэтэй. 10 нас хүрээгүй жаалууд аравтын хувин бариад усанд явдаг. Ах нар тамхи татаж, танхай нэг нь архи уудаг. Гудамж бүхэн атамантай. Атаман бүхэн нь шоронгийн тухай үлгэр ярьдаг. “Бацаануудаа ах шигээ болж болохгүй шүү” гэж сургадаг. Багачууд нь чулуугаар байлдаж, хөгшчүүд нь хороогоор эргэлддэг. Миний мэдэхийн л зовлон жаргал хосолсон гэр хорооллын гудамжинд гоё ч юм бий муухай нь ч бий. Өдгөө муухай зүйлийнх нь талаар амтай болгон муулж, муухай бүхнийг гэр хороололд чихдэг болсонд нь ч тэр үү, өссөн орчноо өмөөрөх сэтгэл байнга төрөх юм. Гэмт хэрэг гарлаа, гал түллээ, хог асгалаа, утаа гаргалаа, модон жорлон барилаа, муухай үнэр гаргалаа, хөрс бохирдлоо, хөдөөнийхөн ирлээ, бүгд л гэр хорооллын буруу. Тэнд хотынхон биш хог новшнууд амьдардаг мэтээр ярьж, бичиж, харуулах нь их болж. Нийслэлийн гэх тодотголтой орон сууцанд амьдардаг иргэд гэр хорооллынхноос жигшдэг. Ганган машин унаж, гутлаа тосолсон нэг нь гэр хорооллоос дөлдөг. Нийслэлийнхний 70 гаруй хувийг бүрдүүлдэг банзан хашаатангууд дугуй түлж, гудамжинд гарахаараа хулгай дээрэм хийгээд, усанд орж хувцсаа угаадаггүй угаар, хир үнэртүүлсэн байдаг гэнэ ээ. Уучлаарай, энэ бол нийслэлчүүдийн талаас илүү хувийнх нь амьдралыг харлуулсан хэт туйлширсан гүтгэлэг. Тиймээс өөрийн өссөн орчноо өмөөрч хэдэн үг хэлье.

## Утаа

Гэр хороололд 180 гаруй мянган өрх амьдарч төдий тооны яндангаар утаа уугиулж, нийслэлийн утааны

50 хувийг дангаараа бүрдүүлдэг. Тиймээс Улаанбаатар “Утаанбаатар” хоч зүүхэд хүргэсэн гол буруутан нь гэр хорооллынхон болчихдог. Тэд л нийслэлийн иргэдийг утаагаар хордуулж байна гэх. Энэ үнэн. Гэхдээ гэр хорооллын яндангаас өөр агаарын бохирдолд нөлөөлж буй олон зүйлийн тухай тодийлэн дуугарахгүй зөвхөн гэр хорооллыг гол буруутанд тооцож, дээр доргүй ярьсаар. Тиймээс өдгөө нийслэлийн иргэдийг гэр хорооллын заваан, орон сууцны цэмцгэр тансаг оршин суугчид гэж нийгмийн эцэс төгсгөлгүй ялгаа гаргаж, ялгаварлан гадуурхалд хүргэж буй юм. Гэр хороололд төрж өсөж байгаа хойч үе өнөөдрийнх шиг муухайгаар хэлэгдэж, өөнтөглөгдвөл ийм орчинд төрсөндөө харамсаж, “Ганц өрөө ч гэсэн байр авчихгүй яав даа, аав ээж минь” гэж эцэг эхдээ “гомдож” торинох ёстой юу. Сүүлийн арваад жил утааг багасгах гэж дорвитой ажиллаагүй байж, гэр хорооллыг хэт нүд үзүүрлэсэн сэтгэхүйг нийгэмд хавтгайруулсан. Тэр нь дээр хэлсэн тун таагүй байдалд хүргэж байгаа. Тэгвэл өөр өнцгөөс харъя л даа. Нийслэлийн агаарын чанарын албаны судалгаанаас харахад, утааны 20 хувийг авто машины утаа үүсгэж байгаа гэнэ. Дулаан цахилгааны станц зургаа, бага дунд оврын халаалтын зуух 10, шороон зам болон шинээр баригдаж байгаа барилга байгууламжийн тоос тоосонцор агаарын бохирдлын 14 хувийг эзэлдэг гэдгийг дурдсан байна. Энэ тоог нэмээд үзэхэд утааны гол буруутан болох гэр хорооллын иргэдийн үйлдвэрлэдэг утааны хэмжээтэй дүйнэ. Гэтэл гэр хорооллынхон өвлийн улиралд л утаа их гаргадаг. Гэтэл автомашины яндангаас гарч байгаа угаар болоод бусад тос тосолгооны материалын бохирдол, шороо тоос дөрвөн улирлын турш гардаг. Монголд явж буй Япон, Солонгосын хуучин автомашин дунджаар евро стандартын буюу байгальд ээлтэй 70-80 автомашины гаргах хорт бодисыг агаарт хаядаг гэсэн судалгаа бий. Хэрвээ орон сууцны тансаг хүмүүс үнэхээр л утаандасанаа зовоод байгаа бол том, ганган машинаа эко машинаар сольж яагаад болохгүй гэж. Ингэж чадвал агаарын бохирдол 20 хувиар буурна. За тэгээд гурван том станц, 1400 гаруй нам даралтын зуухны янданд орчин үеийн технологийг суурилуулах юм бол утаа даруй 16 хувиар багасна гэдэг.

Мөн барилгын компаниуд нь дүрэм журмынхаа дагуу ажиллаад байвал агаарын бохирдол багасахад чамгүй хувь нэмэр оруулчихна. Гал түлж дулаацахаас өөр аргагүй гэр хорооллын иргэдийг зүхэж суухаар агаар бохирдуулагч бусадтай нь хатуу тэмцвэл мэдэгдэхүйц үр дүн гарах юм биш үү. Гэр хороолол руу инженерийн шугам сүлжээ татах том төлөвлөгөө бий ч одоохондоо үр дүн харчих дорвитой шийдэл алга. Нэгэнт уул толгод давж өргөжсөн гэр хорооллыг шийдэх гээд ч шийдэл бага. Харин өрхийн тоог яаж өнөөдрийн түвшинд нь барьж нэмэхгүй байх вэ. Мөн гэр хорооллын яндангаа хэрхэн цөөлөх вэ гэдгээ л бодох нь зөв байх. Түүнээс биш, тэднийг хэчнээн харааж, зүхээд нэмэргүй. Харин ч нийслэлчүүдийн дунд нийгмийн байдлаар нь ялгаварласан том ан цав үүсгэж байгааг хаана хаанаа бодох ёстой юм шиг ээ. Улаанбаатарын 180 гаруй мянган яндангийн эзэд дотор сайхан аж амьдралтай, боловсрол мэдлэгтэй, үр хүүхдээ сайн сайхан хүмүүжүүлж, улс нийгэмдээ хувь нэмэр оруулж яваа хөдөлмөрч, үлгэр дууриалал болох цэвэр цэмцгэр гэр бүл цөөнгүй бий.

## Хог

Гэр хороолол хогтой, бохир заваан. Тэд хог тарьж, угаадсаа асгаж, үнсээ хаядаг. Энэ үнэн гэж гэр хорооллын иргэн би буруугаа хүлээе. Гэхдээ ялгаа бий. Гэр хорооллын айл өрхийн хогийг сард нэг л удаа л ачдаг байхад орон сууцны айл өрхүүдийн хогийг өдөр бүр ачдаг шүү дээ... “Мишээсэн дагина шиг миний Улаанбаатар” гэх сайхан дуу хадаасан, гоё машин ирээд, орон сууцны өрхүүдийн хогийг нь хамаад явчихна. Гэтэл банзан хашаатай айлуудын хогийг ачих гэж түмэн асуудал болно. Хашаандаа овоолсон хогийг нь ачих машин хүрэлцэхгүй, ахуйн бус хогийг авахгүй, төмөр савтай хогийг нь даахгүй бол орхичихно. Хогны мөнгө гэж гэр хорооллын болон орон сууцны айлуудаас сард 2500 төгрөгийг цахилгааны төлбөр төлөх үед нь хамт авдаг. Гэтэл хогийг нь ачихдаа ялгаатай. Дээрээс нь хэн ч хэзээ ч гэр хороололд төсвийн мөнгөөр хогийн сав тавьж байсангүй. Харин орон сууцны эргэн тойронд хогийн сав байршуулж “Иргэдээ хогийн саванд хогоо хийе” гэж уриална. Хийсэн нэгийг нь магтана, хотын соёлтой гэж урамшуулна. Харин нүүрсний шуудай, төмөр сав гээд өөрсдөө хогийн сав бий болгож түүндээ хогоо хийчихээд ачих өдрийг нь хоног тоолон хүлээдэг гэр хорооллын иргэдийг муу хэлсээр л.

## Ялгаварлан гадуурхалт

Нийслэлийн иргэдийн 70 хувь нь гэр хороололд амьдардаг гэх. Энэ газрын иргэд баялаг бүтээхэд тодорхой хэмжээгээр оролцож л байгаа. Хар ухаанаар бодоход л ажиллах хүчний 60 орчим хувь нь энэ хэсэгт байна шүү дээ. Гэхдээ гэр хорооллын иргэдийн олонх нь ядуу, ажилгүй гэж шүүмжлэх хүн байж болно. Ажил хийдэггүй байлаа гээд тэр хүмүүс юм иддэггүй гэсэн үг биш. НЗДТГ-ын “Гэр хорооллыг орон сууцжуулах” төслийн дарга А.Лхагвадорж “Бид траншейны хүн гээд л байдаг. Гэхдээ тэр хог түүдэг хүн татвар шингэсэн талх авч иддэг шүү дээ. Түүнээс биш, татвар төлөгч гэхээр л АПУ аль эсвэл “Талх чихэр” гэсэн компаниар төсөөлж болохгүй. Тэр компаниудын зах зээлд борлуулж байгаа бараа бүтээгдэхүүн чинь татвар шингээд дээрээс нь ашгаа олж авах хэмжээний үнэтэй байдаг. Тэр үнээр нь ард иргэд худалдан авалт хийдэг. Тэгэхээр хүн амын 70 хувь нь гэр хороололд амьдарч байгаа бол татварын заримынх нь 70 хувийг гэр хорооллын иргэд л бүрдүүлж байна гэсэн үг” гэж хэлсэн юм. Энэ өнцгөөс нь харвал Улаанбаатар хотын орлогын тийм хувийг л гэр хороололд зарцуулах ёстой. Гэтэл

гэр хорооллын иргэд улсаас татаас авахгүй амьдардаг хүмүүс. Харин орон сууцанд амьдардаг өөсрдийгөө боловсролтой дээд зиндааны чинээлэг аль эсвэл сэхээтэн гэж бодсон хүмүүсийн зарим орчны тохижилт, зам засвар гээд бүх л ажлыг татварын мөнгөөр хийлгэдэг шүү дээ. Дээвэр засна, цахилгаан шат тавина гээд бүх ажилд татварын мөнгийг л зарцуулдаг. Уг чанартаа гэр хорооллын айлын дээврийг татварын мөнгөөр засах нь орон сууцны дээврийг төсвийн мөнгөөр засч байгаагаас ямар ч ялгаагүй. За тэгээд гэр хороололд стандарт, гудамжны зай хэмжээ, гэрэлтүүлэг, өнгө үзэмж, тохижилт, хогийн сав, муу усны нүх, 00, гудамжны ариун цэвэрт нь гэхчилэн анхаарал хандуулдаг дарга байхгүй. Харин хотын төвийн орон сууцны хорооллын орчинд анхаарал тавьдаг хүн олон.

Орон сууцны оршин суугчдын крант нээгээд л авдаг ус нь хямдхан. Харин гэр хорооллын иргэдийн тэргээ түрээд өвлийн хүйтэн, зуны халуунд авдаг ус нь орон сууцны оршин суугчдын уудаг уснаас хэд дахин илүү үнэтэй. Орон сууцны иргэд нэг литр усыг 40 мөнгөөр хэрэглэдэг бол гэр хорооллынхон нэг төгрөгөөр худалдаж авдаг. Олон улсын байгууллагын судалгаагаар хүн өдөрт 20-25 литр ус хэрэглэх ёстой байтал, манай гэр хорооллын иргэд 10 хүрэхгүй литр ус хэрэглэдэг болох нь тогтоогдсон. Харин орон сууцны иргэд өдөрт 250 литр ус хэрэглэдэг гэх. Тэр усны үнийн зөрүү хаанаас гарч байгаа вэ. Бодоод үзэх л ёстой асуудал. Энэ мэт гэр хорооллын иргэдийг ялгаварлан гадуурхдаг мөртлөө адгийн бүхнийг энэ хэсэгт чихэх нь хэтэрхий өрөөсгөл туйлшрал юм. Тиймээс ад үзээд байдаг гэр хорооллынхонд анхаарал хандуулдаг болчихоод хатуу үгсээ хаях үедээ хаяж баймаар.

Хамгийн бага гомдоллодог, галаа өөрсдөө түлж, усаа тэргээр авдаг, гэрээ өөрсдөө барьж, гудамжаа эзэгүүд нь шүүрддэг гэр хороолол миний өссөн орчин. Өссөн орчноо өмөөрөх үг дэндүү олон. Орон сууцны туяхан залуусын хажууд миний гэр хорооллын охид элдэв маяггүй, эгэл даруухан. Гэр хороололд дэд бүтэц хөгжөөгүй, халуун усгүй, тог тасардаг. Интернэт, кабель байхгүй. Тэглээ гээд би хүний дор ороогүй. Энэ бүгдийн эцэст нийслэлийн хүн амын дотор гэр хороолол, орон сууц гэсэн ялгаварлан гадуурхал бүү байгаасай гэж хүсье. Муу ард түмэн гэж байхгүй, муу төр гэж бийг сана. ■

ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

# УЛААНБААТАРЧУУД ЯМАР УС УУЖ БАЙНА ВЭ

**Ч.ЛУТАА**

Нийслэлчүүд ус уух хувьтай хүмүүс. Сингапурын иргэд хөршөөсөө ундны усаа хоолойгоор татаж хэрэглэдэг. Гэтэл улаабаатарчууд хатан Туулынхаа сав дахь гүний уснаас хүссэн үедээ, дуртай хэмжээгээрээ аваад ууж байна. Гэхдээ ууж байгаа ус маань аюулгүй байж чадаж байна уу. Энэ талаар эргэлзээтэй асуулт олон бий. Тухайлбал, Улаанбаатар хо-тын усны эрүүл ахуйн чиглэлээр хэрэгжүүлж буй нэг бус төслийн хүрээнд хийсэн шинжилгээгээр ундны усны 80 гаруй хувь нь бохирдолтой гарсан байдаг. Гэтэл зарим эх сурвалжийн мэдээлж байгаагаар нийслэлчүүд дэлхийн хаана ч байхгүй цэвэр усыг




*“Mongolian Economy” сэтгүүлийн зохион байгуулсан Усны хэлэлцүүлэг*

ундандаа хэрэглэдэг гэх. Тиймээс энэ эргэлзээг тайлахын тулд Ус сувгийн удирдах газар, “Mongolian Economy” сэтгүүл болон “Ногоон эдийн засгийн өсөлт” ТББ, МІН групп хамтран “Улаанбаатарчууд ямар ус ууж байна вэ” уулзалт хэлэлцүүлгийг зохион байгуулсан.

## Эрүүл ус

Улаанбаатарчууд усны тунгалгийг уудаг гэдгийг Усны төв лабораторын эрхлэгч Б.Урнаа хэлсэн. Учир нь Улаанбаатар хотыг усаар хангадаг үндсэн дөрвөн хэсэг 160-170 гүний худгаас усаа татдаг. Энэ нь газрын гүний хамгийн цэвэр, унданд шууд хэрэглэж болох ус байдаг аж. Тиймээс хотын иргэд маань ундны усны эх үүсвэрийн эрүүл ахуйн хувьд санаа зовохгүй байж болох аж.

## Гэхдээ . . .

Ундны ус хэрэглэгчдэд хүрэх замдаа бохирддог байж болзошгүй гэдгийг мэргэжилтнүүд сануулж байна. Тухайлбал, нийслэлийн орон сууцны иргэдэд ундны усыг хүргэдэг шугамын насжилт өндөр дунджаар 31-53 жил ашиглагдсан байдаг аж. УСУГ-ын Техник бизнесийн хөгжил, Хөрөнгө оруулалтын газрын дарга Б.Батсүх “Өнөөдөр манай ихэнх ус дамжуулах шугам хүчдийн зулай шиг нимгэн болчихсон байна. Үүний гол учир нь удаан хугацаанд хэрэглэсэн ган хоолойнууд зэвэнд идэгдээд байгаа юм” гэв. Тиймээс орон сууцны хэрэглэгчдэд ундны ус очихдоо уг зэвтэй хоолойгоор дамжин ямар хими, физикийн урвалд орж байгааг шууд тодорхойлох боломжгүй гэнэ. Гэхдээ энэ эрсдэлээс сэргийлэхийн тулд усыг хлороор ариутгадаг аж. Тийм болохоор иргэдийн ууж байгаа уснаас хлор амтагдаж л байвал тэр нь ариутгагдсан ус гэж ойлгох учиртай юм байна. Нэгэнт татчихсан ус дамжуулах хоолойг солих боломжгүй тул доторлох ажлыг УСУГ эхлүүлээд байгаа ч хөрөнгө мөнгө нь хүрэлцэхгүй байгааг УСУГ-ын дарга С.Үнэн учирласан юм. Дараагийн нэг асуудал бол хотын 70 хувийг бүрдүүлдэг гэр хорооллын иргэд эрүүл ахуйн чанарын шаардлага хангасан ус ууж чадаж байна уу гэдэг юм. Ус түгээх газраас айл өрхийн авч байгаа ус эрүүл ахуйн шаардлага хангасан төдийгүй дахин ариутгагдсан байдаг аж. Гэхдээ гэр хорооллын хэрэглэгчдийн усаа хадгалдаг сав, шанага зэрэг нь чанарын шаардлага хангадаггүй гэнэ. Тиймээс цэвэрхэн байсан ус иргэдийн гарт очоод бохирддогийг мэргэжлийн хүмүүс үгүйсгэхгүй байна. Ер нь дан ганц иргэдийн зүгээс ч биш ус зөөж байгаа машины ёмкос, худгийн усан сангийн эрүүл ахуй, ариун цэвэр ямар түвшинд байгааг хэлж мэдэхгүй. Тиймээс зөөвөрлөх явцад ус бохирдох тал байж болох юм. Ийм тохиолдолд халдварт өвчний тархалт багасахгүй гэдгийг усны салбарын мэргэжлийн хүмүүс хэлж байлаа. Дээрээс нь иргэдийн дунд усны хадгалалтын тал дээр ямар ч ойлголт байдаггүй болохоор ундны ус нь ямар саванд хэд хонож байгааг тодорхойлох боломжгүй. Гэр хорооллын иргэдийн ихэнх нь усаа зөөж хадгалдаг “усны шар” гэх хуванцар сав нь ус хадгалах тийм ч таатай эд биш гэнэ. Хүнсний бус зориулалттай буюу элдэв төрлийн өнгөтэй хуванцар савыг үйлдвэрлэхэд бисфелон А болон меламин гэх бодисыг ашигладаг АНУ-ын эрдэмтдийн судалгаагаар уг бодис нь хөхний хорт хавдар, үргүй болгох, зарим төрлийн хорт хавдар үүсгэх суурь нөхцөл болдог гэдгийг хэдийнэ тогтоосон байна. Тиймээс энэ мэт буруу зуршлыг өөрчлөхийн тулд иргэдийг мэдээллээр сайн хангах хэрэгтэй гэдгийг С.Үнэн дарга хэвлэл мэдээллийн байгуулагуудад хандаж хэлсэн юм.

## Нөөцийн талаарх маргаан

Ундны усны нөөц хэдхэн жилийн дараа хомсдож эхэлнэ гэх түгшүүр сүүлийн хэдэн жил нийслэлчүүдийн чихийг сортолзуулж байгаа. Нийслэлийн цэвэр усны нөөцийн судалгааг 1980-аад оны эхээр, 1995 он гээд хэд хэдэн удаа хийсэн байдаг. Гэвч хэмжээ нь өөр өөр гарчээ. Хамгийн сүүлийн үеийн судалгаагаар 237 мянган м3 цэвэр ус байна гэж тогтоосон. Түүнийхээ 60-аад хувийг ашиглачихаад байгаа. Ингэхээр 2017-2018 оны үед цэвэр усны хүр¬тээмж хэцүүдэх нь ор үндэслэлгүй зүйл биш гэх нэг хэсэг бий. Гэтэл зарим хэсэг нь бидэнд цэвэр усны хангалттай нөөц байгаа санаа зовох хэрэггүй гэнэ. ШУТИС-ийн профессор Д.Басандорж “Нэгдүгээрт усны нөөц нь хэд юм бэ гэсэн тооцоогоо нэгтгэмээр байна. Өнөөдөр хоёр, гурван янзын зүйл яриад байна. Энэ нь иргэд, аж ахуйн нэгжүүдэд буруу ойлголт өгөхөд хүрнэ. Манай усны нөөцийн 10 хүрэхгүй хувь нь газрын гүндээ байдаг. Гэтэл хэрэглээнийхээ 90 гаруй хувийг газрын гүний уснаас хэрэглэдэг. Тиймээс газрын гадаргуу дээрх усыг ашиглахаар ярьж байгаа нь зөв” гэсэн юм. Төрөөс ч гадаргын усыг ашиглах талаар анхаарч эхэлжээ. Тухайлбал, Туул голын сав газарт Гачууртад, Яармагийн шинэ орон сууцад зориулсан усан сан, мөн Буянт-Ухаа орчимд нэ¬гийг байгуулахаар ажиллаж байна.

## Усны эдийн засаг

Цэвэр усаар бохироо зайлдаг улс манайхаас өөр эх дэлхийн хаана ч байхгүй. Газрын доорх ус бол том баялаг. Гэтэл өнөөдрийг хүртэл усанд өөрийн гэсэн үнэ байхгүй. Нийслэлчүүд өнөөдөр нэг литр усыг нэг төгрөгөөр авч байна. Гэтэл энэ нь усны үнэ биш. Бид усанд төлбөр төлөөгүй харин ус тээвэрлэлтэд л мөнгө төлж байгаа хэрэг аж. Өөрөөр хэлбэл, үйлчилгээний зардлыг төлөөд усаа үнэгүй хэрэглэж байгаа гэсэн үг. Энэ нь эргээд худагт ус хүргэж байгаа жолооч, тухайн худагт ажиллаж байгаа хүний цалин зэрэгт зарцуулагддаг байна. Тиймээс иргэдэд очиж байгаа ундны усыг өөрийг нь үнэлэх цаг ирснийг хэлэх хүн олон бий. Гэхдээ өнөөдөр манай гэр хорооллынхон нэг литр усанд нэг төгрөг төлж байгаа бол орон сууцанд амьдарч буй иргэд 40 мөнгө төлж байгаа юм. Өвөл, зуны алинд ч тэргээ түрээд усаа зөөдөг иргэдийн усны төлбөр их мөртлөө крант нээж хаагаад халуун хүйтэн усыг хүссэнээр хэрэглэдэг орон сууцны иргэд хямдхан ус хэрэглэж байгаа ялгаа нь хачин. Дээрээс нь

гэр хорооллын нэг өрх өдөрт 10 гаруй литр ус хэрэглэдэг бол орон сууцны өрх 250 литр ус ашигладаг. Тиймээс иргэдэд очиж байгаа усыг үнэлэхдээ бодолтой л байхгүй бол болохгүй. Усны газрын орлогч дарга асан З.Батбаяр “Нийслэлчүүдийн усны хэрэглээний 30-хан хувийг л хэрэглээний ус эзэлдэг. Тиймээс иргэдийн хэрэглэж байгаа үндны усыг үнэтэй болголоо гээд ямар ч ашиггүй. Харин тэр үндны усыг ихээр үйлдвэрлэлд ашиглаж байгаа үйлдвэрлэгч нарт хариуцлага тооцож усыг эдийн засагжуулах цаг нь болсон. Өөрөөр хэлбэл монголчуудын нэг хэсэгт ус нь багадаад үнэ нь ихдээд, нөгөө хэсэгт нь үнэ нь багадаад ус нь ихдээд байна” гэсэн юм.

## Хуулийн өр

Усыг эдийн засагжуулах иргэдийн хэрэглэж байгаа усыг суурь үнэтэй болгох гэдэг бол шийдэх олон асуудлын ердөө л нэг хэсэг нь. Нөгөө талдаа саарал усыг ашиглах асуудал бидний өмнө тулгамдаж байна. “Улаанбаатарчууд ямар ус ууж байна вэ” хэлэлцүүлгийн үеэр өнгөрсөн онд батлагдсан Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилт хаана байна вэ. Гаргасан хуулиа хэрэгжүүлэхгүй бол хууль гаргаад хэрэг байна уу гэж өр нэхэх хүн олон байсан. Хэрвээ хууль хэрэгжээд эхэлбэл үйлдвэрлэлийн болон бусад ус их хэрэглэдэг газар цэвэр усыг их ашиглаж, бохирдуулсны төлбөр төлөхгүйн тулд өөрсдөө байгальд ээлтэй технологийг үйлдвэрлэлдээ нэвтрүүлэх шаардлагатай. Нэгдүгээрт, ус бохирдуулж буй газрууд өөрсдөө цэвэршүүлэх байгууламж барих хэрэгтэй. Ингээд цэвэршүүлэх байгууламжтай болоод ирэхээр ус бохирдуулсны төлбөрт санаа зовохгүй болно.

Хоёрдугаарт, усаа цэвэршүүлсэн тохиолдолд эргүүлээд арьс ширний үйлдвэр гэх мэт цэвэр ус ашиглах шаардлагагүй үйлдвэрлэлд цэвэршүүлсэн усыг ашиглана. Тэгвэл цэвэр усанд төлбөр төлөхгүйгээр эдийн засгийн хэмнэлттэйгээр үйлдвэрлэлээ явуулаад байх бүрэн бололцоотой. Гэтэл өнөөдөр хуулийн хэрэгжилтийн бараа сүүдэр нь ч алга. Хяналт хаан байна аа. Тухайлбал, Улаанбаатарын гурван цахилгаан, дулааны станц өдөрт гүний усыг хэр хэмжээтэйгээр ашиглаж байгааг мэддэг хүн ховор. Турбин хөдөлгүүрийг ажиллуулах мөн шатаасан нүүрсний үнсийг зайлуулахын тулд өдөрт 50000 тн гүний ус хэрэглэдэг. Энэ нь Улаанбаатарын нийт гэр хорооллын хэрэглэж буй гүний уснаас гурав дахин их гэсэн үг. Дээрээс нь автомашин угаалгын газар, арьс шир угаах, ноос ноолуур боловсруулах, өлөн угаах үйлдвэрүүд гээд өдөрт хичнээн тонн цэвэр усыг үр ашиггүй урсгадаг гэдгийг мэдэхгүй. Тиймээс цэвэр ус хэрэглэж байгаа нь төлбөрөө төлдөг, усаа цэвэршүүлээд үр ашигтай зарцуулж байгаа хэсэг нь хөнгөлөлтөө эдэлдэг тэр зарчмыг цагийн эрт дээр бий болгох нь зөв юм. Ер нь усгүй эдийн засаг, улс орны хөгжил, ард иргэдийн амьдрал байхгүй. Монгол Улсын ДНБ-ий 60-70 хувь нь Улаанбаатар хотод үйлдвэрлэгддэг. Тийм болохоор нийслэлд усыг эдийн засагжуулах зайлшгүй шаардлага байгаа гэдгийг ШУТИС-ийн профессор Д.Басандорж сануулсан. Олон улсад хөрвөсөн ус гэх ойлголт байдаг. Энэ нь хүмүүсийн өдөр тутамддаа хэрэглэдэг бараа бүтээгдэхүүнийг үйлдвэрлэхэд ашигласан ус юм. Тиймээс аливаа үйлдвэрлэл явуулахад хөрвөсөн усны ашиглалт болон бохирдлын хэмжээгээр эдийн засгийн үр ашгаа тооцдог. Ийм тогтолцоог Монголд нэвтрүүлж яагаад болохгүй гэж. Ер нь энэ салбарт хийх ажил их. Хамгийн наад зах нь устай холбоотой бүх талын тоо баримт, судалгааны ажлыг нэгтгэх шаардлага бий. ■



*Усыг эдийн засагжуулах иргэдийн хэрэглэж байгаа усыг суурь үнэтэй болгох гэдэг бол шийдэх олон асуудлын ердөө л нэг хэсэг нь.*

ЧАНСАА

# НИЙСЛЭЛДЭЭ СЭТГЭЛ ХАНГАЛУУН БАЙНА УУ?

**Б.БЯМБАДОРЖ**

Ямар ч улсын нийслэл хот тухайн орны хөгжлийг илэрхийлдэг. Монгол Улсын эдийн засгийн идэвхийг Улаанбаатар хотоос тольдож болно. Жишээлбэл шинээр тавьсан замууд, өдрөөс өдөрт нэмэгдэх машины тоо, бүтээн байгуулалт зэргээс харахад нийслэлээ хөгжиж байна гэж харж болох юм. Үүний зэрэгцээ хотын замын хөдөлгөөн, барилгын ажлаас үүдсэн золгүй явдлууд гэх мэт сөрөг талуудыг ч ажиглаж болно.

Харин Улаанбаатартай төстэй нийслэлүүд өнөөдөр ямар түвшинд байна вэ? Азийн цагаан дагина гэгддэг байсан Улаанбаатар өдгөө агаарын бохирдлын хэмжээгээрээ дэлхийд тэргүүлж яваа нь хөгжлийн адил шатанд байгаа нийслэлүүдтэй харьцуулахад хэвийн үү? Мэдээж хэрэг энэхүү орнуудад дайн, хууль, бодлогын алдаа оноо, авлига, дэд бүтцийн бэрхшээл, иргэдийн боловсрол зэрэг тоочих асуудал их. Гэтэл өнөөдөр бидэнтэй адил социализмын тогтолцооноос ерээд онд салсан Белорус улсын хоёр сая хүн амтай нийслэл Менск нь 35 км үргэлжлэх метроны системтэй юм. Тэгвэл Улаанбаатар метротой болсон байх ёстой юу?

Улс орнуудын түүхэн замнал ба эдийн засгийн онцлог нь ялгаатай. Иймд энэхүү харьцуулалтад улсын эдийн засаг, хүн ам ба түүхийг голчлон авч үзэв. Манайхтай ойролцоо эдийн засгийн хөгжилтэй орнуудын нийслэлүүдтэй жишиж, Улаанбаатар хот ямар түвшинд байгааг мөн ямар түвшинд байх ёстойг сонирхъё.



*Менскийн метро нь 28 буудалтай*

## Метротой Менск

Беларус улс нь хуучин ЗХУ -ын бүрэлдэхүүн байсан. Өнөөдөр тус улсын нийслэл Менск нь хоёр сая хүн амтай. Хөгжлийн хувьд Улаанбаатар хоттой ойролцоо юм. Эдийн засгийн хувьд Беларусын ДНБ нь манай улсаас зургаа дахин их. Мөн ялгарах гол ялгаа гэвэл тус улсын эдийн засаг бараг бүхэлдээ улсын мэдэлд байдаг. Зарим улсын төлөөлөгчид Беларусыг хуучин ЗХУ-тай зүйрлэсэн нь ч бий. Энэ нь тус улсын 31 банкнаас 30 нь улсын мэдлийнх байдгаас харагдаж байгаа юм.

Менск хотын суурь IX зууны үед зүүн зүгээс хүмүүс нүүдлэн оршин суусnaар нь тавигджээ. Түүхэнд тус хотыг Орос, Литва, Польш зэрэг хаант улс эзлэн түрэмгийлж байж. Менск хот нь Дэлхийн I дайны үеэр Орос-Германы тулааны цэг байсан ба II дайнд мөн л Орос-Германы хоорондын дайны гол талбар болж, хотын талаас илүү хувь нь устжээ. Товчхондоо энэ хот нь олон үндэстэн, ард түмний нүүр үзсэн нурж, сэргэж байсан түүхэн хот юм.

Хүнд хүчир үеийг туулсан Беларус нь ЗХУ–ын эрхшээлээс гарсан

орнуудтай харьцуулахад эдийн засгийн хамгийн хурдацтай өсөлттэй орнуудын нэг. Нийслэл хот Менск нь машин техникийн аж үйлдвэрийн төв болжээ. Тус хотод машин, тоног төхөөрөмжийн 250 гаруй жижиг, том үйлдвэр байдаг. Өөрөөр хэлбэл, Монголыг уул уурхайн орон гэдэг шиг Беларус нь машин тоног төхөөрөмжийн орон юм.

Хөгжиж буй Менск нь өндөр түвшний нийтийн тээврийн системтэй. Хотын хүн ам нь өнөөдрийн Улаанбаатарын түвшинд буюу нэг саяд тэртээ 1977 онд хүрсэн ба удалгүй анхны метроны систем баригдаж эхэлжээ. Ингэснээр Менск хотын анхны газар доорх метро 1984 онд найман буудалтайгаар ашиглалтад орж байж.

Харин Улаанбаатар хотын хувьд “Улаанбаатар Метро” төсөл нь судалгааны шатанд байгаа. 2020 онд метротой болох төлөвлөгөө бий. Ямар ч байсан нэг сая гаруй хүн амтай Менск хотын хувьд наяад онд өдгөөгийн нэг сая гаруй хүн амтай Улаанбаатараас илүү метроны хэрэгцээтэй байжээ.

## Лаосын Вьентьян

Лаос улсын ДНБ нь Монгол Улстай ойролцоо буюу есөн тэрбум ам.доллартай тэнцэнэ. НҮБ–ын мэдээлснээр Монголын хүн амын 30 хувь нь ядуурлын түвшинд амьдардаг. Харин Лаос улсын хүн амын 75 хувь нь ийм байдалтай амьдардаг байна. Тус улс нь Маркс-Ленины үзэлтэй нэг намт социалист Засгийн газартайгаараа онцлог. Эдийн засгийн өсөлтийг газар тариалан, аялал жуулчлал гэх хоёр салбар нь тэргүүлж байна.

Беларустай адил Лаос улс нь түүхэндээ хэд хэдэн хаант улсын нүүр үзсэн. 1893 онд Францын колони болж, дэлхийн II дайнд япончуудад эзлэгдсэн. Тэр үед хараахан тусгаар улс болоогүй байв. Тиймээс дайны дараа 1945 онд дахин Францын колони болжээ. Үүний эцэст 1949 он гэхэд тусгаар тогтносон ч тодорхой засгийн газар байгуулахын төлөө иргэний дайн өрнөжээ.

Өнөөдрийн байдлаар 6.5 сая хүн амтай Лаос улс нь дэлхийн ядуу орнуудын нэг гэж тооцогддог.



*Вьентьян хотын төв хэсэг*

Нийслэл хотын хувьд ч харахад Вьентьян нь тав тух зохион байгуулалтаараа Улаанбаатараас сул. Хотын нийтийн тээвэр, усан замын тээвэрт улсаас тогтоосон нэгдсэн тариф байдаггүй.

Дээрх хөгжиж буй хоёр улсын нийслэлтэй харьцуулахад Улаанбаатар хот өнөөдөр муугүй байна гэж харж болох нь. Ийнхүү гурван улс эдийн засаг, түүх, хөгжлийн хувьд зарим зүйлсээр ойролцоо хэдий ч өнөөдрийн байдлаар нийслэлүүдийн хөгжил нь ялгаатай байгаа юм. Эцэст нь тухайн хүмүүсийн соёлын онцлог, түүхэн замнал нь хотын аж байдлыг тодорхойлдог гэж дүгнэж болох нь. Жишээлбэл, Улаанбаатарын агаарын бохирдлын хувьд монголчууд арчаагүйдээ биш, харин нэг цэгт хэт төвлөрөл бий болж, гэр хороолол тэлсэн нь өдгөө Улаанбаатарыг “Утаанбаатар” гэдэг хоч зүүхэд хүргэсэн хэрэг. Үүний нэгэн адил Лаосын олон жилийн дайн, сөргөлдөөнөөс болж газар нутагт нь тэсрэх бодис тархсан аюул нүүрлэсэн. Тэр нь орон нутгаа тэлж хөгжүүлэх боломжгүй болгодог. Ямар ч байсан өнөөдрийн байдлаар Улаанбаатар маань агаарын аймшигт бохирдлыг эс тооцвол харьцангуй сайн хөгжиж байгаа юм байна. Мэдээж үүнд сэтгэл ханалуун байх үгүй нь тухайн хүний сонголт шүү дээ.

ҮЗЭЛ БОДОЛ

# ХОТЫН НОГООН ХӨГЖИЛ



**Л.ЭНХТУЯА**
***(“Цэцэрлэгжүүлэлт ногоон байгууламжийг хөгжүүлэх үндэсний холбоо”ТББ-ын тэргүүн)***

Нийслэл маань агаарын бохирдлооroo дэлхийд тэргүүлэх боллоо. Иймээс ногоон байгууламж урьд урьдынхаас илүү хэрэгтэй болж байгааг аль аль талдаа ойлгож хүлээн зөвшөөрөхөөс өөр аргагүй. Хотын захиргаа энэ жил нийтийн зориулалттай ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлтийг бий болгох, арчлах, тордох зэрэгт шаардлагатай 7,6 тэрбум төгрөгийг төсөвлөсөн. Ногоон байгууламжийн арчилгаанд 4.0 тэрбум гаруйг, шинээр бий болгоход 2,6 тэрбум төгрөгийг зарцуулсан. Ийм байгууламжийг цаашид улам нэмэгдүүлнэ, дэлхийн хамгийн том цэцэрлэгт хүрээлэнг байгуулна гэдэг зорилготой. Мэдээж энэ бол сайн хэрэг. Гэхдээ яаж. Мод ихээр тарина гэв үү. Нөгөө улиас модоо л хаа сайгүй тарих гэж үү. Ногоон байгууламжийг хэн бий болгож бас хэн арчлах вэ. Энэ бүгдийг бид урьдчилан тооцож, хэрэгжүүлэх арга замаа тодорхойлох шаардлага нийслэлчүүдийн өмнө тулгарч байна.

Ногоон байгууламжийн ашиг тусыг хүүхэд хөгшидгүй л мэднэ. Харин хотын болон орон нутгийн засаг захиргаа их бага хэмжээгээр нийтийн зориулалттай ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлтийг бий болгоход анхаарч байна. Гэхдээ хэд хэдэн саадтай учирна. Өнөөгийн газар ашиглалтын олон төрлийн хэлбэр нь түүнийг эдийн засгийн өөр өөр өртөгтэй болгодог. Эрчимтэй газар ашиглалтын хэлбэр болох барилга барих, үйлдвэрлэлийн талбай зэрэг нь газрын үнийг нэмэгдүүлдэг бол газрыг ногоон байгууламжаар ашиглах нь тийм биш. Энэ утгаараа захиргааны байгууллагууд ногоон талбайн мөнгөөр илэрхийлэгдэхгүй үнэ цэнийг биш барилга барих эдийн засгийн боломжийг л урьтал болгон хардаг. Угтаа ногоон байгууламж нь нийгэм, соёлын, хүмүүсийн хэрэглээнд чиглэсэн орон зайн илэрхийлэл, байгаль экологийн үнэ цэнийг бий болгодог юм. Түүнчлэн ногоон байгууламжийг бий болгоход мөнгө төсөвлөдөг хэдий ч энэ талын хариуцах ажилтан, төсвийг захиран зарцуулагч нь, төсөв олгогч нар нь мэргэжлийн үр дүнг нь ойлгох хамгийн энгийн ойлголтгүй байдаг. Тэр нь ногоон талбайн хөрөнгө оруулалт, арчилгааны зардал гэсэн чухал хэсгийн хөрөнгө оруулалтыг төсвөөс хасах хамгийн эхний үзүүлэлт болдог юм. Ийм л байдлаар сүүлийн арваад жил нийслэлийн ногоон байгууламж,шийдвэрлэх түвшинд орхигдон үнэгүйдэж, хэнд ч хэрэггүй зүйл мэт явсан. Үүний улмаас өнөөдөр Улаанбаатар хотын сул талбай, ногоон байгууламжууд зам талбай, эмх замбараагүй барилга байгууламжид шахагдсан хөөрхийлөлтэй дүр зурагтай болжээ. Тиймээс өдгөө ногоон байгууламж гэдэг хот төлөвлөлтийн хамгийн сөрөг үр дагаваруудын золиос болов. Түүнийг засаж залруулахад их хүчин чармайлт тавьж, хөрөнгө мөнгө зараад ч хүндрэл нь улам бүр нэмэгдэж буйг бид харж байна.

Гэтэл Ногоон талбайн үнэ цэнийн илэрхийлэл нь орчин үед шууд бусаар “мэдрэгдэх” ирээдүй рүү чиглэсэн тогтвортой хөгжлийн үнэ цэнэ, хотын хүн амын өсөлт, байгаль цаг уурын өөрчлөлтийг давахад хотуудын ирээдүйг улам үнэтэй болгож өгч буй “газар нутгийн зөөлөн” хүчин зүйлд тооцогдох болжээ.Өөрөөр хэлбэл, хотын ногоон байгууламж нь хотын хөгжилд зөвхөн агаарын бохирдлыг бууруулах, тоосжилтыг багасгах гэхээс илүү амар тайван орчныг бүрдүүлэх, амьдралын чанарыг дээшлүүлэх үүрэг гүйцэтгэдэг. Түүнчлэн хотын хөгжлийг хамгаалах хотын маркетингийн хамгийн чухал хэсэг болоод байна.

## Ногоон байгууламжийн менежмент

Менежмент гэдэгт аливаа асуудлыг бүхэлд нь авч үзэх, үйл явцыг оптимал болгох аливаа үйл ажиллагааг ашигтай үр дүнтэй хөтлөх гэсэн ойлголтууд багтаж байна.

Цэцэрлэгжилт ногоон талбайн менежемент, түүний эрхэм дээд зорилго нь ногоон талбайн асуудлыг бүхэлд нь харсан “хөтөлбөр”-т шийдлүүдийг боловсруулахад оршдог. Энэ нь зөвхөн нэг гудамжны эсвэл нэг цэцэрлэгийн оптимал төлөвлөлт арчилгаа биш. Түүнээс илүү өргөн хүрээг хамарсан бүр цаашилбал дээд түвшний төлөвлөлтийн хэсэгт зорилгоо холбох гэсэн үг юм. Тухайлбал,

-Хотын бүх ногоон системийг хот суурингийн хөгжлийн “хөтлөх” чиг шугам болгох

-Дээд хэлбэрийн экосистемийг хадгалан авч үлдэх дүрэм, журам

урьдчилсан заалт бий болгох

-Түүхэн ландшафтын элементийг хүлээн зөвшөөрөх

-Цэвэр агаарын урсгал болон хүйтэн агаарын үүсэх газрыг харгалзах

-Тухайн нутагт тохирсон мод бутыг хэрэглэх

-Хамгаалах шаардлагатай ганцаарчилсан объектыг баталгаажуулах

-Хотын бүх ногоон системийг нөхөх зорилгоор "хөтөлж" буй болон "холбож" буй ногоон бүтцийг тасралтгүй үргэлжлүүлэх

-Орон сууцны ногоон талбай, тоглоомын талбайн хэрэгцээг хангах, чанарыг дээшлүүлэх гэх мэт.

Засаг захиргааны анхаарлын төвд байх ёстой гол зүйл нь бий болсон ногоон байгууламжуудын хэрэглэгч нь "их хотын оршин суугч", түүнийг санхүүжүүлэгч нь мөн л тэд өөрсдөө гэдгийг ойлгуулах юм. Түүнчлэн иргэдийн хүсэн хүлээж буй зүйл буюу шаардлага нь ногоон байгууламжийн

- Accessibility- буюу хүртээмжтэй байдал
- Liability- үүрэг, хариуцлагатай байдал
- Proximity- ойр дөт байдал

зэрэг юм. Үүнийг аль аль талдаа ойлгож төлөвлөхөд оршдог.

Ийм шаардлагын нэг жишээ нь зүлгэн дээр амрах, нарлах, ил задгай орон зайг бий болгох, концерт шоу зохион байгуулах боломжоор хангах зэрэг юм.

Хотын ландшафт, ногоон байгууламжийн төлөвлөлт , түүний арчилгаа болон аж ахуй эрхлэлт хоорондоо нягт уялдаа холбоотой байдаг. Энэ нь ургамлан бүрхэвчийн төлөвлөгөө түүнийг хөгжүүлэх бидний гол зорилгууд хоорондын маш том хамаарлын Synergieeffekt-д байдагт оршдог. Иймээс Ландшафт, Ногоон байгууламжийн төлөвлөлтийг цэцэрлэгжилтийн газрын ажил үүргийн хүрээнд холбож өгөх. Ингэж зорилгодоо нийцсэн тогтвортой, залгамж бүхий төлөвлөлтийн үйл явцыг бий болгодог. Яагаад гэвэл ногоон талбай нь ерөнхийдөө олон арван жилийн дараа хөгжиж, өсөж бий болдог. Ландшафтын төлөвлөлтийн үр дүн гүйцэтгэл, биелэлт нь ногоон талбайн арчилгааны явцаас хамаарч зарим залруулах шаардлагатай үр дүн хожуу харагддаг юм. Ер нь өнөөгийн



ногоон байгууламжид хамгийн дутмаг байгаа ажил нь "Төлөвлөлт, арчилгаа" хоёрыг холбож өгөх юм. Хотын чөлөөт орон зайг цэцэрлэгжүүлэх ногоон байгууламжийн тухай аливаа төсөл хөтөлбөрүүдийг заавал арчилгааны стратегитай нь холбож боловсруулдаг. Өөрөөр хэлбэл, хаана intensive арчилгаа байх вэ, эсвэл extensive арчилгааг голлох вэ гэх мэт. Ийнхүү зөвлөлдөх нь ногоон байгууламжийн менежментийн хамгийн гол асуудал билээ.

## Төлөвлөлт ба арчилгаа

Ногоон байгууламжийг төлөвлөх талаар ярихдаа дараа нь яаж арчлах. Хэдий хэрийн мөнгө арчилгаанд нь төсөвлөх, арчилгааны үр дүнг яаж хянахыг бодолцох хэрэгтэй болдог. Арчилгааны үр дүн нь ногоон байгууламжийн чанарыг илэрхийлдэг. Ер нь анхнаасаа цэцэрлэгжүүлэлт, ногоон байгууламжийн зураг төсөл боловсруулах болон эдгээрийн арчилгааны стратегийг боловсруулахдаа эрс тэс хоёр өөр зүйл дээр анхааралтай ажиллах ёстой байдаг.

Нэгдүгээрт, байгалийн хөгжлийн процессыг өөрийн мэт хяналтдаа авах, нөгөөх нь ургамлын төрөл зүйлийн хөгжлийг "өөрөөр нь байлгах" юм.

Зарим тохиолдолд тарималжуулсан ургамал маань бүр "зэрлэгших" янзтай болдог. Яг энэ "зэрлэгших" гээд байгаа процессод чиглүүлсэн стратеги байхгүй бол, эсвэл дутвал энэ нь зөвхөн дараа дараагийн муу үр дагаварт хүргэнэ. Мөн арчилгааг хүндрүүлж ногоон байгууламжийг чанаргүй болгоно. Энэ манайд түгээмэл ажиглагддаг дутагдлын нэг. Байгалийн хуулийн уялдаа холбоог судалж мэдэхгүйгээр, ногоон байгууламжийн чанарыг дээшлүүлэх нь боломжгүй зүйл.

Тэгэхлээр одоо байгаа нөхцөл байдалдаа зохицсон практик үр дүн нь шууд харагдах ажлуудыг хэрэгжүүлэх шаардлагатай. Энэ ажлаараа шинэ туршлага хуримтлуулах боломжтой юм. Нийтэд нь авч үзвэл одоо Монголд цоо шинэ гэж хэлж болох энэ салбарт хэрэглэгчдийн хүсэл сонирхолд нийцэх ургамлын төрөл зүйл бүрдлийг бий болгох. Улмаар янз бүрийн шинэлэг бүтээлч сэдэл санааг ургамлын хэрэглээ, ургамалжуулалтын техник зэрэгт нь зохицуулан судлах нь зүйтэй. Үүний үр дүнд судалгаа шинжилгээний ажлын цар хүрээ нэмэгдэж, улам эрчимтэй хөгжилд хүргэх болно. Гарах үр дүн нь мэдээж өндөр түвшний мэргэжлийн боловсон хүчинтэй болно.

## Хэрэгжүүлэлт ба арчилгаа

Их хотоороо жаахан алхъя л даа. Тэгээд мэргэжилтнүүдийнхээ тарьсан мод ургамлыг харцгаая, цэцэрлэг паркуудаа ажиглая. Ажиглах тусам улам л их алдаатай буруу зүйлүүдийг олж харна. Хэчнээн өөдрөг үзлээр хандлаа гээд алдаагүй зүйл гэж үгүй. Эдгээр нь тухайн

ургамлын тарих ёстой байршлыг буруу сонгосноос эхлээд ерөөсөө мод ургамлын тарималжуулалтын сонгодог хэлбэрүүдийг зөрчсөн нь мэргэжлийн бус хүний нүдээр ч илэрхий харагдана. Үүнд:

- Тарьсан ургамал, байршилтайгаа зохицоогүй
- Төрөл зүйлийн сонголт буруу, бас хомс
- Ландшафтын баялаг дүр төрх илэрхийлээгүй
- Ургамлын байгалийн өрсөлдөх чадварыг, мөн амьдралын мөчлөгийг нь харгалзаагүй

Энэ мэт энгийн гэмээр алдаанууд илт ажиглагддаг. Энд л манайхны ургамал судлалын мэдлэг, судалгаа, шинжилгээ дутуу, ландшафтын архитекторчийн чадвар илт хоцрогдсон нь мэдрэгдэнэ. Бас гадаадын цэцэрлэгжүүлэлтийг дутуу дулимаг, бүр тэс ондоогоор буруу хуулбарласан нь ч мэдэгдэнэ.

Өнөөдөр нийслэл хотын маань ландшафтын төлөвлөлтийг барилгын архитекторууд хийж, ногоон байгууламжийн менежментийг агрономчид хийж, арчилгааны ажлыг хэн олдсон нь хийж байгаа. Энэ нь уг салбарын хүрээний эмгэнэл болж байгаа. Ийм мэргэжлээр их, дээд болон мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн сургуулиудад огт элсэлт байхгүй байгааг ч бас мэдэх болно.

Харин ногоон байгууламжийг төлөвлөх чадвартай, арчлах чадвартай мэргэжилтэн бэлтгэх асуудал юунаас ч илүү хэрэгцээ болсон байгааг аль аль талдаа хүлээн зөвшөөрөх хэрэгтэй болжээ.Зөвхөн манай Монголд ч төлөвлөлт гүйцэтгэлийн байдал ийм байгаа юм биш ээ. Гадаадын өндөр хөгжилтэй орны мэргэжлийн өндөр түвшний стандарт хангасан гэх ургамалжуулалтын төлөвлөлт нь ч бас зөндөө алдаатай байдаг.

Тиймээс арчилгааг хүндрүүлдэг дараахь эх үүсвэрүүдийг төлөвлөлтдөө ихээхэн анхаардаг болжээ.

- Хөрсний бэлтгэл ажил буруу эсвэл дутуу хийгдэх
- Хог ургамлын байнгын асуудал
- Тарилтын цаг хугацааг буруу шийдэх зэрэг орж байна.

Эдгээр асуудал нь харин манайд хамгийн хүндрэлтэй асуудлын нэг болоод байна. Гадаадад энэ талын стандарт, норм, шалгаруулалтын журам гэх мэтээр зохицуулах эрх зүйн орчин бүрдсэн байдаг. Жишээ нь тарилт хийхээс өмнө заавал хийгдсэн байх ёстой хамгийн чухал арга хэмжээг нормчлоод зааж өгсөн байдаг. Тухайлбал,

- Бүтцийн хувьд тогтвортой, маш сайн сийрэгжүүлсэн хөрс бэлдэх
- Тухайн байршлын нөөцийг бүрэн дайчилж, шавхаж гаргасан байх
- Ургамалжуулалттай холбоотой шимт тэжээлийн талаар судалгаа шинжилгээ хийгдсэн
- Хог ургамалгүй зүлэгжүүлэлт бий болгох
- Тарилтын улирлыг зөв сонгох зэрэг ордог байна.

## Ургамлын үйлдвэрлэл ба төлөвлөлт

Өнөөдөр Улаанбаатар хотод мод үржүүлгийн төгөл олон бий боловч тэд үнэхээр ямар нэгэн согогүй бүтээгдэхүүн нийлүүлж чадаж байгаа юу. Мөн төрөл зүйлийн хувьд /гоёлын мод, бут, сөөг/ овор хэмжээний хувьд ч зах зээлийн өнөөгийн шаардлагыг хангаж чадаж байна уу. Мэдээж үгүй.

Энэ нь төлөвлөлтийг хүндрүүлээд зогсохгүй, гүйцэтгэл, арчилгааг ч хүндрүүлж байдаг. Ялангуяа тарьсан мод ургамлын арчилгаа хэдэн арван жилээр үргэлжлэх учраас аль болох цаг хэмнэсэн арчилгаа, төлөвлөлт, гүйцэтгэл байх нь менежментийн бас нэг чухал хэсэг. Жишээ нь том оврын мод хэрэглэх, олон наст ургамлыг тарималжуулан нийтийн эзэмшлийн ногоон байгууламжид ашиглах гэх мэт. Иймээс бид үйлдвэрлэгчдийг ялангуяа хүлэмжийн болон цэцгийн аж ахуй эрхлэгчдийг дэмжиж тэдний дунд цэцэрлэгийн үзэсгэлэнг өргөнөөр зохион байгуулж яагаад болохгүй гэж. Түүнийг зөвхөн бүтээгдэхүүн худалдах зах зээл биш харин урлагийн бүтээл болгон нийтийн таашаалд хүргэхээр өндөр төвшинд зохион байгуулах нь үйлдвэрлэгчдийн дунд өрсөлдөөнийг бий болгоно. Энэ нь нийт салбарыг хөгжүүлэхээс гадна нийгэмд ногоон байгууламжийн чанарыг сайжруулах, үнэлэмжийг өсгөх чухал алхам болох юм.

## Арчилгаа нь уран бүтээл байдаг

Цэцэрлэг, ногоон байгууламжийн “арчилгаа” гэдгийг манайхан бараг л “ЦЭВЭРЛЭГЭЭ-УСАЛГАА” гэж ойлгоод байна. Тэгвэл энэ үгийг цэцэрлэгжүүлэлт гэсэн өнцгөөс нь харвал ямар нэгэн ургамал, ургамалжуулалт болон тэдгээрийн гүйцэтгэх үүргийг хадгалах, дэмжих бүх төрлийн арга ажил гэж ойлгогдоно.

Тэгвэл урын нүдээр харсан донжтой хийц гаргах үүргийг арчилгаатай уялдуулж холбоод өгөхөөр цэцэрлэгжилтийн зураг төсөл боловсруулалт, хэрэгжүүлэлт гэдэг ажил нь арай үнэ цэнэтэй болж өгөх юм. Цэцэрлэгжүүлэлтийг ажил хэрэгчээр хэрэгжүүлнэ гэвэл төслийн явцад зураг төсөл боловсруулалт байнга дагаж явна гэсэн үг. Тодорхой ганцхан зураг төсөл биш, бүхэл бүтэн зургийн цоморлиг, бүхэл бүтэн цуврал бүтээл байх ёстой. Цэцэрлэгжилт нь ургамлынхаа хөгжлийн зүй тогтлыг дагаад донж төрх нь байнга хувьсан өөрчлөгдөж байдаг. Ийм учир төлөвлөгчид хотын хүмүүсийн нүдийг байнга “шинэ” зургаар баясгаж байх бүтээлийг хийж цэцэрлэгчид тухайн ургамлын өөрийн гэсэн онцлог бүхий төрөл зүйлийнх нь динамик хөгжлийн чадвартай “хүч үзэх”, арга эвийг нь олох шаардлагатай тулгардаг. Архитекторуудын хувьд зураг төсөл боловсруулах нь шууд бэлэн бүтээгдэхүүн бас биш. Амьдралд хэрэгжүүлж бодитоор цогцлоох тэр уран бүтээлийнх нь зөвхөн төсөөлөл төдий зүйл байдаг. Харин тухайн цэцэрлэг, ногоон байгууламжийн хөгжлийг залан чиглүүлэх, уран бүтээл болгон цогцлоож, амилуулах нь арчилгааны үед л шийдэгддэг.Зөвхөн ингэж л тэдгээрийн “хотын иргэнд таалагдах” ерөнхий хийц төрхөд нөлөөлөх боломжтой.

Тэгэхлээр хэлбэр төрх, хийц донжтой болгох, арчлах гэдэг нь хэдийгээр хоёулаа байгалийн жам ёсоороо хоорондоо нягт уялдаатай боловч тус тусдаа мэргэжилтнүүд байдаг болохоор ихэнхдээ саланги хийгддэг. Арчилгаа нь маш чухал ач холбогдолтой зүйл мөнөөсөө мөн. Гэвч одоохондоо үүнийг уран бүтээлч үйл ажиллагаа гэдгийг хүмүүс хараахан ойлгоогүй байна. ■

ТЕХНОЛОГИ

# УХААЛАГ ХОТЫН ШИНЭ ЭРИН

**З.МИШЭЭЛТ**

Хөгжлийн шинэ хандлагыг мэдэрсэн барилгын компаниуд орон сууц барихдаа тоон системд суурилсан дижитал технологийг өргөн ашигладаг болжээ. Тухайлбал, Алсын зайнаас гэрээ хянаж, зарим нэг нь гэрийнхээ тодорхой хэсгийг “удирдаж”, аливаа учирч болох эрсдэлээс урдчилан сэргийлж байна. Манай улсад ч энэхүү ухаалаг хотын эхлэл болсон ухаалаг хороолол бий болж байна. “М Си Эс проперти” ХХК-ийн Холбоо дохиоллын ахлах инженер Д.Гансүх “Монгол Улс хөгжихийн хэрээр барилгын салбарт дэлхийн хэмжээний стандартыг нэвтрүүлэх зайлшгүй шаардлага бий болж байна. Тухайлбал, том байшин барьж байгаа л бол эрсдэлийн үнэлгээ хийлгэж, технологийн дэвшлийг ашиглах хэрэгтэй. Энэ шаардлагын дагуу бүтээн байгуулагдсан хорооллын нэг бол “Viva city” хороолол юм” гэжээ.

1614 айл амьдарч байгаа 32 блок барилгуудаас бүрдсэн томоохон бүтээн байгуулалт болох тус залуучуудын хороолол нь Монголдоо ухаалаг галын дохиоллын систем суурилуулагдсанаараа онцлог. Мөн томоохон хорооллыг нэг дэлгэц дээр хянах боломжийг бүрдүүлсэн нь маш том давуу тал аж. Хүний амьдрах таатай орчинг бүрдүүлсний дээр иргэдийн аюулгүй байдлыг хангахад ихээхэн анхаарсан байна.

Тухайлбал, “Viva city”-д “Ай Ти Зон” компанийн инженерүүд:

- Ухаалаг галын дохиоллын систем
- Нэгдсэн хяналтын камерийн систем
- Зарлан мэдээллэх систем
- 24 цагийн харуул хамгаалалт гэх зэрэг аюулгүй байдал, тав тух, өргөн боломжуудыг хангасан дөрвөлсөн системийг суурилуулжээ. “М-Си-Эс” группын галын аюулгүй байдлын



инженер Ж.Дэлгэр “Энэ дөрвөн систем нь ухаалаг барилгыг бүрдүүлэгч дэвшилтэт технологи юм. Гэхдээ эдгээр технологийг суурилуулаад л тухайн орон сууц ухаалаг болчихгүй. Хамгийн гол нь системүүд өөр хоорондоо хэдий чинээ үр ашигтай холбогдож байна гэдгээр нь ухаалаг эсэхийг нь тодорхойлдог. Манай компанийн суурилуулсан энэхүү ухаалаг галын дохиолол болон хяналтын камерын технологи нь Англий тэргүүлэгч “Zeta” болон “Вивотек” брэндийн бүтээгдэхүүнүүд юм. Өөрөөр хэлбэл хамгийн үр ашигтай хэлбэрээр холбогдож чаддагаараа онцлог” гэв. Хорооллын хувьд газар доогуур 400 метр тунелийн системтэй. Энэ тунелд дулаан, ус, кабелийн гээд бүх инженерийн шугам сүлжээг нэгтгэсэн системийг суурилуулснаараа тус хотхон маш том давуу талтай. Энэхүү нэгдсэн системийг тавихын тулд хонгилд галын дохиоллын, кабелийн, автоматаар гал унтраах системийг мөн суурилуулж өгчээ. Түүнчлэн хотхонд хяналтын үүрэгтэй 54 камер 24 цагаар ажиллаж нийтийн эзэмшлийн талбайг хамарсан 30 гаруй чанга яригч бүхий зарлан мэдээллэх системтэй. Энэ нь энгийн үед зар болон бусад төрлийн мэдээллийг явуулах бөгөөд онцгой байдлын үед яаралтай зарлалыг оршин суугчдад хүргэх зориулалттай аж. Энэ мэт дурдаад байвал тус хотхон технологийн дэвшлийг илэрхийлж чадна. Эдгээрээс “Ай Ти Зон” компанийн суурилуулж буй ZETA брэндийн галын дохиоллын системийг онцлох хэрэгтэй.

## Ухаалаг галын дохиоллын систем

Ухаалаг хотуудын хамгийн чухал шалгуурууд бол иргэдэд учирч болзошгүй эрсдэлийг бууруулах, барилгын насжилтыг уртасгах юм. Учирч болох эрсдэлүүдээс хамгийн өндөр эрсдэлийн тоонд галын аюул зүй ёсоор ордог. “Ай Ти Зон” компанийн худалдааны менежер Б.Наранжаргал: Цахилгаан угсралтын буруутай үйл ажиллагаа, цахилгаан хэрэгслийн аюулгүй байдлыг хангаагүй, хүний болгоомжгүй үйл ажиллагаанаас шалтгаалсан эсвэл аянга, цахилгаан, гэх мэт гал гарах олон шалтгаан бий. Тиймээс энэ болзошгүй эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх үүднээс

галын дохиоллын систем, гал унтраах системийг барилгуудад суурилуулсан байх шаардлагатай байдаг юм. Гэтэл өнөөдөр манай барилгын салбарын галын дохиоллын систем стандартын, чанарын шаардлага хангахгүйгээс болж иргэд өмч хөрөнгөөрөө удаа дараа хохирсон тохиолдлууд гарсаар байна" гэсэн юм. Ихэнх барилгуудад суурилуулагдаж байгаа галын дохиоллын систем нь аналоги технологид суурилсан байдаг аж.




Энгийнээр тайлбарлавал гал обьектын аль хэсэгт гарсныг илрүүлэхийн тулд тухайн барилгын эрсдэлд орсон жигүүрийн өрөө тус бүрийг шалгах хэрэгтэй болдог. Гэтэл гал нь богино хугацаанд тархдаг. Энэ цаг хугацааны зөрүүнээс болж тухайн байгууламж бүхэлдээ устах аюултай. Орчин үеийн галын дохиоллын дэвшилтэт шийдлүүдэд энэхүү асуудлыг бүрэн шийдвэрлэсэн байдаг. "Viva city"-д суурилуулсан ZETA брэндийн галын дохиоллын систем нь гал яг хаана гарсан бэ гэдгийг маш богино хугацаанд мэдэх боломжийг олгодог орчин үеийн дэвшилтэд, тоон системд суурилсан ухаалаг систем юм. "М Си Эс" группын галын аюулгүй байдлын инженер Ж.Дэлгэр: "Viva city" хорооллын 32 блок 1614 айлын мэдээллийг нэг дэлгэц дээр үзүүлдэг. Хэрвээ 10 дугаар байрны хоёр давхрын нэг айлд гал гарлаа гэхэд тэр талаарх мэдээлэл дэлгэц дээр шууд гарч ирнэ. Тус галын дохиолтой зэрэгцээд дэлгэцэнд тухайн айлын схем зураг болон нэмэлт мэдээлэл гарна. Энэ мэдээллийг ямар ч түвшний боловсролтой хүн хараад ойлгох боломжтой. Тиймээс галын дохиолол ирсэн даруйд харуул хамгаалалтын ажилтан цаг алдалгүйгээр очиж үзээд шаардлагатай арга хэмжээг авах боломжтой" гэв. Галын дохиоллын тоон систем нь хүнээс хамааралтай механик ажиллагааг багасгаж, өөрөө өөрийнхөө ажиллагааг хянадаг. Хэрвээ галын дохиолол системийн мэдрэгч ажиллахгүй байгаа бол тухайн орчинд байгаа хүнд мэдэгддэг, удирдлагын самбар болон хяналтын дэлгэц дээр шууд мэдээлэл өгдөг байна. Өнөөдөртөө Монголд ийм ухаалаг галын системийг суурилуулсан газар "Viva City"-гээс өөр байхгүй. Б.Наранжаргал: "Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа барилгын норм, дүрэм, стандартын дагуу галын дохиоллын системийг барилгад суурилуулах шаардлагатай байдаг. Гэтэл харагдах төдий, хямд үнэтэй удаан хугацаанд хэвийн, найдвартай ажиллагааг хангах боломжгүй галын дохиоллын системийг суурилуулж, улсын комисст нүд хуурсан байдлаар шалгуулаад өнгөрдөг явдал маш их байна. Энэ нь суурилуулсны дараах засвар үйлчилгээ байхгүйгээс гадна ашиглалтын дүрэм журамгүй байх тохиолдол их ажиглагдаж байна. Тиймээс бид барилгын захиалагч болон гүйцэтгэгч компаниудад хамгийн найдвартай системийг суурилуулж, ашиглахыг зөвлөдөг" гэв. "Ай Ти Зон" компанийн хувьд дэлхийн брэндийг оруулж ирээд зогсохгүй дэлхийн хэмжээнийн үйлчилгээг нэвтрүүлж байгаагаараа онцлог. Одоогоор тус компанид галын дохиоллын системийн шийдэл хариуцсан 20 гаруй, системийн суурилуулалт, угсралт, тохиргоог хариуцаж ажилладаг 20 гаруй инженерүүдийн баг ажиллаж байна. Дээрх инженерийн баг нь бүх төрлийн барилгын онцлогт тохирсон галын дохиололтой холбоотой шинэ дэвшилтэт технологи, зах зээлд нэвтрэх боломж зэргийг судалж, Систем Интеграцчлалын газрын борлуулалтын менежерүүд нь бүх түвшний байгууллага, хувь хүмүүст энэ талын зөвөлгөөг өгч, мэдээллээр хангаж, галын дохиоллын системийг зах зээлд нийлүүлдэг аж.

Ер нь ухаалаг системүүдийг энгийнээр суудлын автомашинтай харьцуулж тайлбарлаж болох юм. Энэ системүүд нь хэдийгээр өөрөө өөрийгөө хянах боломжтой байдаг ч гэсэн байнга хэвийн үйл ажиллагааг шалгаж, арчилж, тордож байхгүй бол эвдрэх мадаглал өндөр. "Viva city"-д ZETA брэндийн галын дохиоллын 23 удирдлагын самбар, 50 мянган метр орчим галд тэсвэртэй кабель, 2000 гаруй галын дохиоллын мэдрэгч төхөөрөмжүүд суурилуулагджээ. Тиймээс тус системийн удаан хугацаанд хэвийн найдвартайгаар ажиллуулж байхын тулд суурилуулалтын дараах засвар үйлчилгээ зайлшгүй шаардлагатай байсан байна. Энэ шаардлагын дагуу "Ай Ти Зон" компани "Viva city" хорооллын иргэдтэй засвар үйлчилгээний гэрээ байгуулжээ. Гэрээний дагуу сард нэг өрх ойролцоогоор 480 төгрөг төлнө. Энэ мөнгийг төлөөд л сардаа нэг удаа галын дохиоллын системийн аюулгүй байдлыг хангах засвар үйлчилгээ хийлгэх боломжтой нь тун дорь.

Дашрамд "Ай Ти Зон" компанийн тухай товчхон танилцуулахад Систем интеграци, Программ хангамж, Мэдээллийн технологийн сервис, Бизнесийн тоног төхөөрөмжийн дистрибьютер гэсэн үндсэн дөрвөн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Монголын мэдээллийн технологийн тэргүүлэгч компани юм. Тэд Барилгын автоматжуулалт, хамгаалалтын хүрээнд гэрлийн, галын системүүд, нэвтрэлт хяналтын систем, камерын хяналтын систем, нийтийн эзэмшлийн газрын автоматжуулалт, авто зогсоолын төлбөрийн систем зэрэг олон дэвшилтэт шийдлүүдийг хийж гүйцэтгэж байна. Ухаалаг барилгын системийн хүрээнд өнөөдрийн байдлаар International Medical Center, International Commercial Center зэрэг барилгад үйл ажиллагаагаа нэвтрүүлж байна. ■

ОЮУТОЛГОЙН БУЛАН

# ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ

**Б.ТОГТОХ**

Лондонд эхэлсэн “Оюутолгой”-н хөрөнгө оруулалтын гэрээний хэлэлцээр Монголд үргэлжилж байна. Хэрвээ хэлэлцээр үр дүнтэй болсон тохиолдолд хувь нийлүүлэгчдийн хоорондох үл ойлголцол арилж, одоогийн байдал урьдынхаас дээрдэх юм. Цаашилбал далд уурхайн санхүүжилтэд шаардлагатай хөрөнгө оруулалтыг “Рио Тинто” групп шийдэж, 2014 онд бүтээн байгуулалтын ажил эхэлнэ. Үр дүнд нь Монголын эдийн засаг тамир тэнхээ сууж, өсөлтөөрөө дэлхийд дээд амжилт тогтоох болзолыг хангах юм.

“Оюутолгой”-н эдийн засагт үзүүлэх нөлөөллийн үнэлгээг МУИС-ийн Эдийн засгийн сургуулиас 2011 онд хийсэн билээ. Тус үнэлгээнд дурдсанаар 2043 он гэхэд манай улсын ДНБ- ий хэмжээ 63.23 их наяд төгрөгт хүрэхээр байна. Тэгвэл ирэх оны төсвийн төсөлд “Оюутолгой”-н үйлдвэрлэлийн нөлөөгөөр эдийн засаг сэргэж, ДНБ-ий хэмжээг 20.4 их наяд төгрөгт хүргэхээр төлөвлөжээ. Ингэснээр Монголын эдийн засгийн хэмжээ мөнгөн дүнгээр хоёр дахин өсөх юм.

Жилийн өсөлт нь ийм өндөр орон Зүүн Азийн бүс нутагт тэдийгүй дэлхийд байхгүй гэж хэлж болно. Гэхдээ өнгөрсөн хугацаанд эдийн засаг чамгүй хурдацтай цахилсан ч тэр хэрээр ажлын байр нэмэгдээгүй. Нөгөө талаасаа уул уурхайн салбар ажиллах хүчийг тэдийлэн ихээр шаардаад байдаггүй. Өсөлтийн жилүүдэд бодит ажлын байр 11 хувиар өссөн байна.

ДНБ-д үзүүлэх “Оюутолгой”-н шууд нөлөөллөөр 2019 он гэхэд ДНБ-ий хэмжээ 36.4 хувиар, 2020 онд 25 хувиар тус тус тэлэх аж. Ирэх 20 жилийн хугацаанд Оюутолгойн ил болон далд уурхайгаас жилд дунджаар 430 мянган тонн зэс болон 425 мянган унц алт үйлдвэрлэх тооцоог “Рио Тинто” группээс гаргасан. Уг тооцоолол биелсэн тохиолдолд Монголын эдийн засаг одоогийн эрчимтэй өсөлтөө цаашид хадгалах нь дамжиггүй.

Мөн ирэх жилүүдэд төсвийн орлого баттай бүрдэх эсэх нь “Оюутолгой”-н үйлдвэрлэлээс шууд хамаарах бололтой. Тус компанийн алтны олборлолт энэ онд эхэлснээр хэмжээ нь эрс нэмэгдэж, ирэх онд 24.9 сая тонн алт бүхий баяжмал экспортлох Сангийн яамны тооцоо бий. Ингэснээр алт олборлолтын хэмжээ 31.6 сая тоннд хүрнэ. Мөн ирэх оны улсын төсөвт 89.2 тэрбум төгрөгийн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, 15 тэрбум төгрөгийн өсөн нэмэгдэх нөөц ашигласны төлбөрийн орлого тус тус орох аж.

Сүүлийн жилүүдэд төсвийн нийт орлогын гуравны нэг орчмыг ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, шууд болон шууд бус татварын орлогоор уул уурхайн салбараас бүрдүүлсэн. Тэгвэл 2016 он гэхэд уул уурхайн салбар нь ДНБ-ий тэн хагасаас илүү хувийг бүрдүүлэхээр байна. Монголбанкны тооцоолж байгаагаар “Оюутолгой” энэ онд 93.2 мянган тонн цэвэр зэс агуулсан баяжмал үйлдвэрлэж, түүнээс 57.2 мянган тонныг гадаад зах зээлд нийлүүлнэ. Түүнчлэн 9.9 тонн алт олборлож, үүнээс дөрвөн тонныг гадагш гаргахаар төлөвлөжээ. Ингэснээр нийт экспортын жилийн өсөлтөд 10, бодит ДНБ-ий жилийн өсөлтөд 5.7 хувийн нөлөө үзүүлэхээр байгаа аж. Гэхдээ өндөр өсөлт, олон оронтой тооны ард эрсдэл буйг мартахгүй байх нь чухал.

Хэрэв 2014 онд “Оюутолгой” 700 мянган тонноос дээш зэсийн баяжмал экспортолсон тохиолдолд уул уурхайн татварын орлогын 26 хувийг, нэгдсэн төсвийн орлогын таван хувийг дангаараа бүрдүүлэх юм. Хувь нийлүүлэгч талууд харилцан тохиролцоонд хүрч, хамтдаа “хундага тулгаагүй” ч гэрээний дагуу бүтээн байгуулалтын ажил хэвийн явааа. Дотоод асуудал гацаатай байгаа ч гадаад зах зээл сэргэх аваас



далд уурхайн санхүүжилтэд төдийлэн санаа зовохгүйгээр зохицуулж болох аж. Тиймээс нэн тэргүүнд хоёр тал нэг тийш харах шаардлагатайг хөрөнгө оруулагчдын зүгээс илэрхийлж буй.

“Оюутолгой” компанийн ТУЗ-ийн гишүүн Ч.Отгочулуу “Хувь нийлүүлэгчдийн хэлэлцээрийн дүнд одоогоор таван асуудалд хоёр тал байр сууриа нэгтгэсэн” гэлээ. Санал нийлээд буй таван асуудлын багцад ус, татварын урьдчилгаа төлбөр, зэс хайлуулах үйлдвэрийн төсөл орсон байна. Энэ оны эхний зургаан сарын хугацаанд “Оюутолгой” компани 168 тэрбум төгрөгийн татвар, хураамжийг төлсөн. 2009 оноос хойш бол нийт нэг их наяд гаруй төгрөгийг улсын төсөвт оруулсан хэмээн тус компанийн дэд захирал Т.Мөнхбат хэлсэн юм.

Уул уурхайн салбарт голлох үүрэг гүйцэтгэж буй “Оюутолгой” компани энэ оны есдүгээр сарын байдлаар нийтдээ 12.5 сая тонн хүдэр боловсруулжээ. Энэ хугацаанд 43 мянган тонн зэсийн баяжмал үйлдвэрлэсэн байна. Оны эцэс гэхэд 85 мянган тонн зэс агуулсан баяжмал үйлдвэрлэхээр урьдчилсан төлөвлөгөө гаргажээ. Одоогоор “Оюутолгой”-н баяжуулах үйлдвэр ил уурхайг түшиглэн хоногт 100 мянган тонн хүдэр боловсруулж байна. Дэлхийн банкнаас хагас жил тутам гаргадаг Монголын эдийн засгийн улирлын тоймд өгүүлснээр “Оюутолгой”-н үйлдвэрлэл эхэлсэн, Засгийн газрын тэлэх бодлогуудын үр дүнд эдийн засаг энэ онд 12.5 хувиар өсөх нь ээ.



*Оюутолгой компани ирэх онд уул уурхайн татварын орлогын 26 хувийг дангаар бүрдүүлнэ*

# ECONOMY TV STUDIO

НЭВТРҮҮЛЭГ ШТ РК

РЭКЛАМ СУРТАЛЧИЛГАА

## МЭРГЭЖСЭН БАГ МЭРГЭШСЭН СТУДИ




Эдийн засгийн цаад агуулга нь амьдрал гэх. Эсрэгээр нь, амьдрал өөрөө эдийн засаг гэж ч тодорхойлдог. Ямартай ч тэд хүйн холбоотой гэдэг нь хөдөлгөөнгүй үнэн.

Гагцхүү энэхүү нандин холбоос, тэрхүү ээдрээтэй харилцааг дүрслэхийн хамт эдийн засаг амьдралд хэрхэн бууж, амьдрал эдийн засгаар яаж хөглөгдөж байгааг өгүүлэх нь "Economy" ТВ студийн зорилго юм.

Эдийн засаг бол удирдах ажилтны хувьд ойрын хамтрагч нь байхад энгийн иргэн түүнийг ангид ертөнц мэтээр төсөөлөх.

Тэгвэл бид бүхий л давхаргынхны эрх ашгийг хөндөж, бүх салбарынхны байр суурийг мэргэжлийн төвшинд, мэргэшсэн хэмжээнд тусгана.

Тиймээс эдийн засагт ойр танд, эдийн засгаас хол танд ч манай хаалга нээлттэй.

сэтгүүлийн дэргэдэх
"ECONOMY" ТВ СТУДИ

Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, VI хороо, Их сургуулийн гудамж. AB center: 503 тоот УТАС : 70115476

www.mongolianeconomy.mn

# МОНГОЛ-АНГЛИ ХЭЛ ДЭЭР
# **14** ХОНОГ ТУТАМ




Утас:
7011-5476
9409-2904
9409-2905

СЭТГҮҮЛИЙН ЗАХИАЛГЫГ
РЕДАКЦИД БАЙНГА
АВЧ БАЙНА